

# АГУУЛГА

## ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ.....

### КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Монголын Криминологийн өнөөгийн байдал, чиг хандлага.....Б.Батзориг
2. Нийслэл хотод үйлдэгдэж байгаа бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад анхаарах асуудал.....С.Отгонбаатар
3. Гэмт хэрэгтэй тэмцэхэд орчин үеийн техник, технологи ашиглах нь.....Г.Бямбадорж
4. Монгол улсад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад тулгамдаж буй зарим асуудал.....О.Батжаргал

### ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагааг мэдээллээр хангахад дүн шинжилгээ хийх зорилго, зарчим.....Д.Мягмарцэрэн, М.Отгонбаяр

### ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Цагдаагийн албаны тухай хууль хэрэгжсэнээр Цагдаагийн байгууллага шинэчлэгдэх боломж бүрдэнэ.....Б.Оюутболд
2. Олон нийтийн цагдаагийн ажилтан, түүний эрх зүйн байдал.....Б.Баянмөнх
3. Цагдаагийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага.....Б.Намсрай
4. Гэмт хэрэгтэй тэмцэхэд “Цахим хянагч”-ыг ашиглах нь.....Ш.Чулуун
5. Албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон цагдаагийн алба хаагч, түүний ар гэрт үзүүлэх нийгмийн хамгааллын асуудал.....З.Цэрэнбат
6. Монголын цагдаагийн цол, түүний уламжлал судлалын асуудал.....И.Мөнхсонор

### ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Проблемы оборудования объектов уголовной-исполнительной системы системами нелетального электрошокового воздействия.....Сорокин В.М

### ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Монгол улсын шүүх эрх мэдэл дэх иргэдийн оролцооны тогтолцоо /Үндсэн хуулийг тайлбарлах асуудлын хүрээнд/..... Г.Давааням, Б.Содномдаржаа

## **ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

Цагдаагийн албаны тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулах дараах хууль зүйн болон практик шаардлага байна.Үүнд:

#### **I. Хууль зүйн үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого"-д "Төрийн үйлчилгээг хүртээмжтэй, ил тод болгох, хүний эрхийг баталгаатай хангах, нийгэм дэх аюулгүй орчныг бий болгох эрх зүйн зохицуулалтыг тус тус боловсронгуй болгоно", 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-д "Иргэдээ аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт хувь нэмрээ оруулах боломжоор хангах, хамтран ажиллахад төр онцгой анхаарах, хүний эрх, эрх чөлөөг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлж, энэ чиглэлд институци хоорондын уялдаа холбоог сайжруулна" гэж, 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т "Шүүх, хууль хяналтын байгууллагын тогтолцооны шинэчлэлт хийх"-ээр тус тус тусгажээ.

#### **II. Практик үндэслэл, шаардлага**

1993 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас баталсан Цагдаагийн байгууллагын тухай хууль нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг төлөвшүүлэн жигдэлж, материал-техникийн хувьд тодорхой хэмжээнд бэхжүүлэн, цагдаагийн албыг хөгжихөд чухал хувь нэмрээ оруулсан. Гэвч хуулийг хэрэгжүүлж эхэлснээс хойш тус улсын эдийн засаг, нийгмийн бүх талын харилцаанд ихээхэн өөрчлөлт бий болж, энэхүү өөрчлөлтийн явцад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах ажиллагааг уг хуулиар шуурхай, үр дүнтэй зохицуулах боломжгүй болжээ.

ШУА-ын Философи, социологи, эрхийн хүрээлэн, Азийн сан, Олон улсын Монгол соёлын төв, Максима судалгааны төв зэрэг байгууллагаас цагдаагийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны өнөөгийн байдалд хийсэн судалгаанууд уг байгууллагад тогтолцооны болон үйл ажиллагаа, удирдлагын зарчмын шинэчлэл хийх шаардлагатайг мөн харуулж байна.

Түүнчлэн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж олноор батлагдан гарсан, уг хуулийн зарим зүйл, заалт бусад хуулийн зүйл, заалттай давхардсан, цаг хугацааны явцад зохицуулалтын чадвараа алдсан, хуулийн зарим зүйл, заалтын найруулга нь бүхэлдээ хуучирсан байна.

Дээр дурдсан хууль зүйн болон практик шаардлагуудыг үндэслэн, олон улсын туршлагыг өөрийн орны онцлогт нийцүүлэн, цагдаагийн байгууллагын харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг харьцуулан дүгнэж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хариуцлагатай байдлыг хангах, цагдаагийн байгууллагыг удирдах, хяналт тавих эрх бүхий субъектын чиг үүрэг, бүрэн эрхийг зааглан, тодорхой болгох, иргэний

хяналт, иргэн болон цагдаагийн байгууллага харилцан бие биедээ тусалж, хамтран ажиллах эрх зүйн үндсийг бий болгох, цагдаагийн алба хаагчийн үүргээ гүйцэтгэх нөхцөл баталгааг дээшлүүлэх зорилгоор Цагдаагийн албаны тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулна.

### **Хоёр. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 15.8.1, 15.8.2-т заасныг үндэслэн хуулийн нэр томъёог сайжруулах, зарим зүйл, заалтыг хүчингүй болгох, шинээр зүйл, заалт оруулах зэргээр хуулийн тавиас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орж байгаа тул төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулна.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд уг хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгана. Үүнд:

#### **Нэгдүгээр бүлэг**

Нэгдүгээр бүлэгт хуулийн төслийн зорилтыг тодорхойлж, үйл ажиллагаа удирдлагын үндсэн зарчим, цагдаагийн байгууллагын чиг үүрэг, цагдаагийн байгууллагын тогтолцоо, бүтцийг зааж өгнө.

#### **Хоёрдугаар бүлэг**

Хоёрдугаар бүлэгт цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх үүргийг алба бүрээр тусгана.

#### **Гуравдугаар бүлэг**

Гуравдугаар бүлэгт цагдаагийн байгууллагын удирдлага, тэдгээрийн эрх хэмжээг хуульчилна.

#### **Дөрөвдүгээр бүлэг**

Энэ бүлэгт цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд тавих иргэний болон бусад хяналт, дэмжлэгийг тусгана.

#### **Тавдугаар бүлэг**

Тавдугаар бүлгээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах, олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.

#### **Зургаадугаар бүлэг**

Энэ бүлэгт цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны шуурхай, аюулгүй байдлыг хангах талаар тусгана.

#### **Долоодугаар бүлэг**

Долоодугаар бүлэгт цагдаагийн байгууллагын санхүүжилтын талаар тусгана. Ингэхдээ цагдаагийн байгууллагыг улсын төсвөөс санхүүжихээр тусгах ба санхүүжилт нь тус байгууллага үүргээ шуурхай үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг хангасан байхаар тусгана. Түүнчлэн цагдаагийн байгууллага нь хөгжлийн сантай байхаар төсөлд тусгана.

#### **Наймдугаар бүлэг**

Наймдугаар бүлгээр цагдаагийн алба хаагч, ажилтны эрх зүйн байдлыг тусгана. Цагдаагийн алба хаагч, ажилтны эрх үүрэг, үүргээ гүйцэтгэх нийтлэг нөхцөл баталгааг Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулах бөгөөд гэмт хэргийг мөрдөх, зөрчлийг шалгахтай холбоотой эрх, үүрэг, үйл ажиллагааны журмыг Хууль

сахиулагчийн үйл ажиллагааны тухай хуулиар зохицуулна. Харин энэ хуульд цагдаагийн алба хаагчийн үүргээ гүйцэтгэх онцлог, баталгааг тусгана.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар**

Хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дагавар гарна:

- Цагдаагийн байгууллагын тогтолцоо боловсронгуй болж, зарим албадын чиг үүргийн давхардал арилна;
- Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах ажилд тодорхой ахиц дэвшил гарч, хүний эрх, эрх чөлөө хамгаалагдана;
- Цагдаагийн байгууллагад өгөх иргэдийн үнэлгээ өсч, тэднийг үл хүндэтгэсэн хандлага багасна;
- Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажлын чанар, хамтын ажиллагаа сайжирна;
- Цагдаагийн алба хаагчийн үүргээ гүйцэтгэх нөхцөл баталгаа, цалин хөлс, урамшил дээшилнэ;
- Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдэж, мэдээллийн аюулгүй байдал хангагдана.

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой тодорхой хэмжээний хөрөнгө улсын төсвөөс нэмж санхүүжигдэнэ. Энэхүү хөрөнгийн зардлыг тусгайлан тооцож, төсөлд хавсаргана.

**Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн тухай**

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль бусад хуультай нийцсэн байна.

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй уялдуулан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Галт зэвсгийн тухай, Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай зэрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ

## КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ



### МОНГОЛЫН КРИМИНОЛОГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

*Б.Батзориг*

*Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх,  
соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан,  
ахлах комиссар, доктор /Ph.D/*

#### Оршил

Гэмт явдал хэмээх нийгмийн сөрөг үзэгдлийг танин мэдэх оролдлого нь хүн буруу зөвийг ялгаж салгаж чаддаг болсон үеэс өөрийгөө болон ойр дотныхноо хамгаалж эхэлснээс үүдэлтэй байж болох юм. Өөрөөр хэлбэл хүн төрөлхтөн, хүн яагаад бусдад хор аюултай муу үйл хийгээд байдаг юм бол, яагаад ийм нөхцөл байдал бий болоод байна гэдэг асуултын хариуг олж, амар амгалан, тайван амьдрах эх үүсвэр болсон гэмт явдалгүй нийгмийг бүтээхийг мөрөөдөж, түүхийн тодорхой цаг хугацаанд (социалист тогтолцоотой улс оронд) гэмт хэргийг бүрэн устгах зорилго тавин ажиллаж байсан үе ч түүхнээ бий.

Криминологи хэзээ үүссэн юм бэ? гэсэн асуултанд зарим судлаачид XIX зуун гэдэг ч тийм ч оновчтой томъёолол биш. Энэ нь шинжлэх ухаан гэсэн шалгуур тавьдаг үзэл баримтлалд бүрэн нийцэж эхэлсэн цаг хугацаа. Үүнээс өмнө криминологитой холбоотой онол, үзэл нь шашин, нийгэм, биологи, сэтгэл зүйн шинжлэх ухааны давуу нөлөөтэйгээр хөгжиж ирсэн.

Гэсэн хэдий ч криминологийн талаарх маргаан эрдэмтэн судлаачдын дунд:

1. Криминологи нь - бие даасан шинжлэх ухаан мөн үү эсхүл шинжлэх ухаан практик хоёрын нэгдэл үү?<sup>1</sup>
2. Криминологи нь - Академик шинжлэх ухаан уу?<sup>2</sup>
3. Криминологи нь - Шинжлэх ухааны салбар уу?<sup>3</sup>

<sup>1</sup> Johnson.E.H. Crime, Correction and Society. Homewood, 1964, p. 7.

<sup>2</sup> Menninger.K. The Crime of Punishment. New York, 1965., p.5.

<sup>3</sup> Caldwell.R.G. Criminology. New York, 1956.8 p.4-7

4. Криминологи нь - Хэд хэдэн шинжлэх ухаанд тулгуурласан анагаах ухаантай адил уу?<sup>4</sup> гэсэн сэдвээр үргэлжилсээр байдаг.

### Нэг. Монголын криминологийн үүсэл, мандал, буурал

Дэлхийн криминологийн хөгжлийн чиг хандлагын адил Монголд гэмт явдалтай хийх тэмцэл, урьдчилан сэргийлэх ажил шашин, зан заншлын нөлөөтэйгээр хөгжиж улмаар 1967 онд МУИС-д Монгол Улсын гавьяат хуульч, шинжлэх ухааны доктор Г.Совд анх криминологи хичээл зааж эхэлсэн цаг хугацааг Монголд криминологийн ухаан үүссэн гэж тоолж эхлэх саналтай байна.


#### а/ Монголын Криминологийн хөгжил:

Монголд криминологийг хөгжүүлэхэд ОХУ-ын прокурорын газрын дэргэдэх гэмт явдлын шалтгаан судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулах эрдэм шинжилгээний хурээлэн үлэмж хэмжээний тусламж үзүүлсэн /зураг 1, 2, 3/. Тус хурээлэнгийн эрдэмтэн, мэргэжилтэн хууль зүйн ухааны доктор В.Б.Ястребов, Г.В.Дашков, В.П.Рябцев, В.Н.Махов нар 1973-1983 онуудад манай улсад зөвлөх мэргэжилтнээр ажиллаж, эрдэм шинжилгээний ажилтнуудыг сургаж дадлагажуулах, криминологийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд биетэй тусалцаа үзүүлсэн байна.<sup>5</sup>

Гэвч гэмт явдал нь хуучин нийгмийн үлдэгдэл, хөрөнгөтний нийгэмд л байдаг учир коммунизмыг бүтээн байгуулахад гэмт явдал устана гэж үздэг байв. Гэвч гэмт явдал нь нийгмийн үзэгдэл учир устахгүй, түүний шалтгаан нөхцөл нь Монгол ардын хувьсгалт намын хэрэгжүүлж буй зарим бодлого, тухайн үеийн тогтолцоо, удирдлага зохион байгуулалтаас ямар нэг хэмжээгээр хамаардаг тухай үнэлэлт, дүгнэлт хийж эхэлсэн тул Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнг 1983 онд татан буулгасан байх талтай.

Энэ цаг хугацаанд онолын бүтээлүүдээс гадна хууль сахиулах байгууллагын ажилтнуудад зориулсан аргачилсан гарын авлага, криминологийн судалгааны арга зүй, орон нутгийн гэмт явдлын онцлогийг тусгасан онцлог бүтээлүүд хэвлэгдэж байв. Түүнчлэн криминологиор доктор /дэд эрдэмтэн/ зэрэг хамгаалсан сэдвийн болон тухайн сэдвээр бичигдсэн бүтээлийн эзлэх хувийн жин хамгийн өндөр үзүүлэлттэй. Өөрөөр хэлбэл, Монголын криминологийн хөгжлийн оргил гэж үзэхээр байна. /зураг 1, 2/


Зураг 1. Нийт эрдмийн зэрэг хамгаалсан сэдвийн дунд криминологийн чиглэлээр хамгаалсан сэдвийн эзлэх хувийн жин




<sup>4</sup> Sutherland.E.H., Cressey.D.R. Principles of Criminology. 7th ed. Philadelphia. New York, 1966., p. 20.

<sup>5</sup> Н.Жанцан, Криминологи, УБ. 2004., 26 дахь тал

Зураг 2. Монгол хэл дээр хэвлэгдсэн эрх зүйн чиглэлийн бүтээл /сурах бичиг, гарын авлага, нэг сэдэвт бүтээл/



Зураг 3. Монгол хэл дээр хэвлэгдсэн бүтээлд криминологийн чиглэлийн бүтээлийн эзлэх хувийн жин



Монголын криминологийн хөгжилд үнэлэшгүй хувь нэмэр оруулсан буюу оруулсаар байгаа олон арван эрдэмтэн, судлаачид дундаас доктор Ж.Авхиа, Г.Совд, Р.Гүнсэн, Л.Рэнчин, Д.Думбурай, С.Нарангэрэл, Н.Жанцан, С.Жанцан, Н.Баатаржав нарын хүмүүсийг онцлон тэмдэглэхийг хүсч байна.

1990-ээд оноос эхлэн Монголын криминологийн хөгжил бусад эрх зүйн шинжлэх ухаантай адил хөгжлийн доод түвшинд хүрсэн. Гэсэн хэдий ч криминологич эрдэмтэн судлаачдын идэвх санаачилгад тулгуурласан байдлаар хөгжиж эхэлсэн.

#### Б/ Монголын Криминологийн түүхэн товчоо:

1. Анх удаа Монгол Улсад Р.Гүнсэн Эрүүгийн эрх зүйн криминологийн сэдвээр 1965 онд докторын зэрэг хамгаалж, мөн ондоо “Гэмт хэрэг гарч байгаа шалтгаан” бүтээлээ хэвлүүлжээ.

2. Анхны Криминологийн сурах бичгийг Ж.Авхиа, Г.Совд нар редакторлон 1975 онд хэвлүүлжээ.

3. Анхны криминологийн судалгааны байгууллага болох Улсын прокурорын газрын дэргэдэх Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнг 1972 онд байгуулсан.<sup>6</sup>

<sup>6</sup> Улсын прокурорын 1973 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 38 дугаар тушаалаар Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнг 1973 оны 3 дугаар сарын 1-ний өдөр байгуулсан юм.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл судлах хүрээлэн «БНМАУ-д гарч байгаа гэмт явдлын шалтгаан нөхцөлийг судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулах» асуудлыг шийдвэрлэх үндсэн зорилгын үүднээс анх удаа гэмт хэрэгтэй тэмцэх онол арга зүйн үндсэн асуудал, тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулах, хуулийн байгууллагуудаас зохиож буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг судалж боловсронгуй болгох гэсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байжээ.

4. Анхны бие даасан эрдэм шинжилгээний цуврал болох “Гэмт хэрэгтэй тэмцэх асуудал” эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэлийг 1974 оноос эхлэн арван нэгэн дугаар гаргажээ. Орон нутагт гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тодорхой асуудлаар эрдэм шинжилгээ, онол, практикийн бага хурлууд олон удаа зохиогдсон.

5. Анх удаа БНМАУ-д социалист өмчийг эрүүгийн эрхээр хамгаалах нь сэдвээр Р.Гүнсэн 1974 онд, БНМАУ-д хүний амь насны эсрэг гэмт хэрэгтэй явуулах тэмцлийн эрүүгийн эрх, криминологийн асуудлууд сэдвээр Ж.Авхиа 1976 онд докторын (Sc.D.) зэрэг тус тус хамгаалсан.

6. Анхны бие даасан хууль болох “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль” 1997.12.05-ны өдөр батлагдсан.

7. Анхны Криминологийн төрийн бус байгууллага болох “Монголын криминологичдын холбоо” 1999 онд байгуулагдсан. Тус холбоо нь 2012 оноос [www.criminology.mn](http://www.criminology.mn) сайт, Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл болон эрх зүйч, математикч, статистикч, социологич, эдийн засагч, сэтгэл зүйч эрдэмтэн, судлаачдыг эгнээндээ нэгтгэн их дээд сургуулиудыг түшиглэн шинэчлэгдэн зохион байгуулагдаж байна.

8. Анхны онол, арга зүйн “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл 2002 оноос тасралтгүй 45 дугаар хэвлэгдэн гараад байна.

9. Анх удаа 1990-2005 онд бүртгэгдсэн гэмт хэргийн судалгааг хууль эрх зүй, социологи, статистик, сэтгэл зүйн үүднээс цогц байдлаар 2005 онд судалсан.

10. Хүмүүнлэг ардчилсан иргэний нийгэмд эргэлт буцалтгүй шилжсэн цаг үед анх удаа Цагдаагийн академийн дэргэд Хууль зүйн яамны дэргэдэх Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэн 2002 онд байгуулсан.

Хуульчдын давтан сургалтын төв нь Хууль зүйн Үндэсний төв болж өргөжин 2004 онд Криминологийн судалгааны сектор, 2009 онд Хууль зүйн Үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй криминологийн сектор, 2012 онд Нийтийн эрх зүйн судалгааны багт бүтцийн хувьд хамаарах болсон.

ЦЕГ-ын Криминологийн судалгаа хариуцсан байцаагчаар 2005 оноос бий болсон, 2011 оноос Мэдээлэл судалгааны төвийн Криминологи судалгааны төв байгуулагдаж хэлтэс болон өргөжсөн.

2008 онд байгуулагдсан Цагдаагийн академийн бүтцэд Криминологийн судалгааны тасаг нь 2012 онд Хууль сахиулах их сургуулийн Цагдаа судлалын төв гэсэн явцуу бүтцээр Гэмт хэрэгтэй тэмцэх бодлого боловсруулах ажлыг хийж эхэлж байна.

11. Анх удаа Гэмт явдалтай тэмцэх хууль, тогтоомжийг багцаар нь шинэчлэх ажил 2012 онд эхэлсэн.

## **Хоёр. Өнөөгийн байдал ба социалист криминологийг халахуй**

### **а/ Хэмжихгүй бол хийж чадахгүй**

---



Гэмт явдлын өсөлт бууралтыг хэмжих нэгж нь цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн статистик тоон үзүүлэлт. Энэхүү үзүүлэлтийг “загнах” аргаар амархан бууруулдаг. Субъектив хүчин зүйлээс хамааралтайгаар өөрчлөгдөх магадлал өндөр.

Нуугдмал гэмт явдлыг тодорхойлж Монгол дахь гэмт явдлыг хэмжих аргачлал байхгүй учир<sup>7</sup> Гэмт явдалтай тэмцэх оновчтой бодлого тодорхойлох, тэмцэх хүч хэрэгсэл, дэд бүтцээ урьдчилан төлөвлөхөд шаардлагатай мэдээлэл, судалгаа шинжилгээ хангалттай бус. Судалгаа шинжилгээний дэд бүтэц байхгүй.

#### **б/ Ниргэсэн хойно нь хашгирах**

Гэмт явдлыг нийгэмд хор хөнөөлөө учруулж, бусдын амь насанд хүрсэн, олны анхааралд өртсөн тохиолдолд хууль хяналтын байгууллагууд ухаан орж тэмцэж эхэлдэг. Тухайлбал,

- Анх иргэний нийгмийн байгууллага Авлига нийгэмд аюултай байна гэдгийг нилээд хэдэн жил ярьж байж түүнтэй тэмцэж эхэлсэн<sup>8</sup>

- Хүн худалдаалах гэмт хэрэг нийгэмд аюултай байна гэдгийг төрийн бус байгууллагууд олны анхааралд хүргэж гэж олон жил тэмцсэний үр дүнд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэж эхэлсэн<sup>9</sup>

- Гэр бүлийн хүчирхийлэл ноцтой түвшинд хүрээд байна гэдгийг төрийн бус байгууллагуудын төрийн анхааралд хүрсэн боловч эрч нь суларсан. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудал олны анхааралд хүрсэн хойно хууль сахиулах байгууллагууд хөдөлж эхэлж байх жишээтэй.

- Мөнгө угаах гэмт хэрэг монголд ноцтой түвшинд хүрээд байна гэдгийг гадаад дотоодын судлаачид удаа дараа хэлсэн<sup>10</sup> боловч төр, хууль сахиулах байгууллага зохих арга хэмжээ авахгүй байгаа учир мөнгө угаах өндөр эрсдэлтэй хар дансанд орох<sup>11</sup> эрсдэл бий болсноос хойш мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажил илүү эрчимжиж байна.

Монголын Криминологи буюу Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлого нь гадаадын болон олон улсын байгууллагын<sup>12</sup> тусламж дэмжлэгтэйгээр хувь хүний идэвх зүтгэлээс хамаарч байна.

#### **в/ Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлого**

Монгол Улс Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дагнасан хуультай, түүнчлэн тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон хууль, гэмт хэрэгтэйтэмцэх тухай олон улсын гэрээ конвенцид нэгдэн орсон тоогоор хэмжвэл бараг гэмт явдал монголд устдаггүй юмаа гэхэд Төрийн хяналтанд бүрэн орчихсон байх ёстой. Гэвч Монгол төрд гэмт явдалтай тэмцэх нэгдсэн бодлого, стратеги байхгүй.

Гэмт явдалтай тэмцэх чиг үүргийг Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба түүнчлэн, Монгол банкны Санхүү мэдээллийн алба, Мэргэжлийн хяналтын газар, Хил хамгаалах алба зэрэг олон байгууллага хууль тогтоомжийн дагуу шууд ба шууд бусаар гүйцэтгэж байна.

Гэмт явдлыг хэмжиж цаашдын хандлагыг прогнозчилон тодорхойлж чадахгүй байна. Монголын криминологийн бүтээлд болон хууль сахиулах байгууллагын үйл

<sup>7</sup> Авлигатай тэмцэх газар Дэлхийн банкны санхүүжилтээр авлигыг хэмжиж тодорхой бодлогын хэрэгжилтийг үнэлэх боломж хууль эрх зүйн төдийгүй, арга зүйн түвшинд бий болсон.

<sup>8</sup> Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр 1999 онд хийгдсэн “Монгол дах Авлигын талаархи олон нийтийн санаа бодол, байр суурь” судалгаанаас хойш олон улсын байгууллагын санхүүжилтээр 2006 он хүртэл нийт 8 судалгаа хийгдсэн.

<sup>9</sup> Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн зураглал, УБ., 2009. 28

<sup>10</sup> 1st Round mutual evaluation report adopted 24 July 2007 /FATF/FSRB/

<sup>11</sup> UN Analytical Support and Sanctions Monitoring TeamComments on the Mongolian laws for implementing SR III

<sup>12</sup> НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх алба, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ийн хүүхдийн сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Олон улсын Санхүүгийн гэмт хэрэгтэй газар /FATF/, Азийн сан, Мэрки кор олон улсын байгууллага, Дэлхийн зөн олон улсын байгууллага, Швейцарийн хөгжлийн агентлаг ... гэх мэт

ажиллагаанд гэмт явдлын шалтгаан, гэмт бие хүн төлөвшихөд нөлөөлөх хүчин зүйлсийг ажилгүйдэл, ядуурал, хууль эрх зүйн орчин түүнчлэн хохирогчийн буруутай үйл ажиллагаа гэх мэт нийгмийн нийтлэг үзэгдэл үйл явцаас хайсаар байна.

Энэ бүхнээс дүгнэж үзэхэд гэмт явдалтай тэмцэх үйл ажиллагаа хувь хүний үзэл бодлоос хамааралтай, гэмт хэргийн өсөлт бууралт, шалтгаан нөхцөлийг өөрсөддөө хамааралгүй байдлаар гаргадаг Социалист криминологиос салж чадахгүй байна.

### **Гурав. Чиг хандлага**

Гэмт явдлын хөдөлгөөн, хандлага, шалтгаан нөхцөлийг бие даасан хараат бусаар тогтоох зорилгоор Криминологичдын холбооноос (White paper crime book) гэсэн олон улсын нэршилтэй Гэмт хэргийн цагаан ном боловсруулах аргачлалыг хийж байна.

Монгол Улс 1992 оноос хойш хийж эхэлсэн эрүүгийн хууль тогтоомжийг шинэчлэх ажлыг үргэлжлүүлж буй Хууль зүйн сайд Х.Тэмүүжиний санаачлан Хууль зүйн цогц бодлогын хүрээнд багц хуулийн төсөл нь гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогыг тодорхойлох чухал эрх зүйн баримт бичиг болоод зогсохгүй Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх үйлсэд ихээхэн хувь нэмэр болно гэдэгт итгэлтэй байна. Үүнд эрдэмтэн судлаачид, хуульчдын санал шүүмж үнэлшгүй хувь нэмэр болно.

Монгол Улс хөгжлийн шинэ шатанд гарч байгаатай холбоотой бий болох гэмт явдлын хандлагыг тодорхойлох, гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилтэд үнэлэлт өгч боловсронгуй болгох арга замыг тодорхойлох дэд бүтцийг бий болгох, судлаачдыг чадавхжуулах шаардлагатай байна. Энэ дэд бүтцийг их, дээд сургуулиудын нөөц чадавхид тулгуурлах нь илүү үр дүнтэй гэсэн санал дэвшүүлж байна.

Эрх зүйгээс бусад шинжлэх ухааны судлаачдыг криминологийн судалгаанд өргөнөөр оролцуулан чадавхжуулж, гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогод үр дүнтэйгээр онолын төдийгүй практик үр нөлөөг дээшлүүлэх боломжтой.

Бид криминологийн дэлхийн хандлагатай өөрсдийн хөгжлийг ойртуулах хэрэгтэй байна. Учир нь орчин цагийн криминологи зөвхөн гэмт хэрэг, түүний явцуу шалтгаан нөхцөлийг судалж дуусаад, харин одоо “хүүхэд гудамжинд хамгаалалтгүй тоглож болохгүй тухай, хүмүүсийн хүнсний хэрэглээ, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын тухай асуудлууд, болон байгууллагын ажилтнуудын бие даан шийдэж буй асуудал, түүний үр дагавар, лифтэнд суух уу, үгүй юу, байшингаа хэрхэн баривал хулгайчаас сэргийлэх вэ зэргийг анхааралдаа авч, заримыг нь шийдвэрлэлчихсэн сууж байна.

Үүнийг барууны гэгдэх орнуудад “Бүх нийтээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” буюу “public criminology” гэж нэрлэж заншжээ.



**НИЙСЛЭЛ ХОТОД ҮЙЛДЭГДЭЖ БАЙГАА БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ ХУЛГАЙЛАХ ГЭМТ  
ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН  
БАЙГУУЛАХАД АНХААРАХ АСУУДАЛ**

*С.Отгонбаатар  
Нийслэлийн Цагдаагийн газрын дэд бөгөөд  
Захиргааны удирдлагын газрын дарга,  
цагдаагийн хурандаа*

Нийслэл хотын хэмжээнд эхний 10 сард 12829 гэмт хэрэг бүртгэгдэж, улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт хэргийн бүтцэд 60.5 хувийг эзэлж байна. Үүнээс бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 2013 оны эхний 10 сард 3862 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 1213 хэргээр буюу 45.7 хувиар өсчээ.

Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн 3374 буюу 87.3 хувийг иргэдийн өмчийн хулгай, 94 буюу 2.4 хувийг малын хулгай, 64 буюу 1.6 хувийг авто тээврийн хэрэгсэл хулгайлах, 302 буюу 7.8 хувийг халаасны хулгайн гэмт хэрэг эзэлж байна.

Бүртгэгдсэн бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн 1397 буюу 36.1 хувь нь хөнгөн, үүнээс: 88 буюу 6.3 хувийг хялбаршуулах журмаар, 2447 буюу 63.3 хувь нь хүндэвтэр, 8 буюу 0.2 хувь нь хүнд, 10 буюу 0,2 хувь нь онц хүнд ангиллын гэмт хэрэг эзэлж байгаа ба хөнгөн хэргийн илрүүлэлт 45.4%, хүндэвтэр хэргийн илрүүлэлт 37.7%, хүнд хэргийн илрүүлэлт 43.0%, онц хүнд хэргийн илрүүлэлт 78.0 хувьтай байна.

Хулгайлах гэмт хэргийн 286 буюу 7.4 хувийг бүлэглэн гүйцэтгэсэн, 322 буюу 8.3 хувийг эмэгтэй хүн оролцсон, 168 буюу 4.3 хувийг хүүхэд оролцсон, 308 буюу 7.9 хувийг согтуугаар үйлдэгдсэн хэрэг эзэлж байна.

Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийг үйлдэгдсэн газраар нь авч үзвэл:

Гэр орон сууцанд 1520 хэрэг буюу 39,3 хувь, үүнээс: 456 буюу 30.0 хувь нь гэрт, 319 буюу 20.9 хувь нь орон сууцанд, 62 буюу 4.0 хувь нь зуслангийн байшин буюу хауст, 511 буюу 33.6 хувь нь хувийн байшинд, 32 буюу 2.1 хувь нь гараажид, 25 буюу 1.6 хувь нь амбаар агуулахад, 35 буюу 2.3 хувь нь орц, подвальд, 80 буюу 5.2 хувь нь бусад газар үйлдэгджээ.

Гудамж талбайд 710 хэрэг буюу 18,3 хувь, үүнээс: 89 буюу 12,5 хувь нь гэр хорооллын гудамжинд, 251 буюу 35,3 хувь нь орон сууцны хорооллын гудамжинд, 216 буюу 30.4 хувь нь ил зогсоолд, 53 буюу 7,4 хувь нь автобусны буудалд, 93 буюу 13,1 хувь нь бусад газар үйлдэгджээ.

Олон нийтийн газар 732 хэрэг буюу 18,9 хувь Үүнээс: 369 буюу 50.4 хувь нийтийн зах, үзвэрийн газар, бөөний худалдааны төв, дэлгүүр, түцэнд, 83 буюу 11,3 хувь нь зочид буудалд, 72 буюу 9.9 хувь нь саун бааранд, 66 буюу 9,0 хувь нь зоогийн газар ресторанд, 142 буюу 19,4 хувь нь бусад газар үйлдэгджээ.

Нийтийн тээвэрт 65 буюу 1,6 хувь үүнээс: Том оврын автобусанд 56 буюу 86.1 хувь, Микро автобус 3 буюу 4.6 хувь Таксид 6 буюу 9.2 хувь нь үйлдэгдсэн.

Төрийн байгууллагад 38 буюу 0,9 хувь, төрийн бус байгууллагад 46 буюу 1,2 хувь, аж ахуйн нэгжид 442 буюу 11,4 хувь, бусад газар 306 буюу 7,9 хувийг нь эзэлж байна.

Гэмт хэргийг үйлдэгдсэн цагаар нь авч үзвэл:

- 721 буюу 18,6 хувь нь 06-14 цагт,
- 1086 буюу 28,1 хувь нь 14-19 цаг буюу ажлын цагаар
- 590 буюу 15,2 хувь нь 19-22 цагт,
- 1465 буюу 37,9 хувь нь 22-06 цагт буюу шөнө оройн цагаар
- Гэмт хэргийг гарсан гарагаар нь авч үзвэл:
- 670 хэрэг буюу 17,3 хувь нь даваа гарагт
- 661 хэрэг буюу 17,1 хувь нь мягмар гарагт
- 538 хэрэг буюу 13,9 хувь нь лхагва гарагт
- 584 хэрэг буюу 15,1 хувь нь пүрэв гарагт
- 584 хэрэг буюу 15,1 хувь нь баасан гарагт
- 413 хэрэг буюу 10,7 хувь нь бямба гарагт
- 412 хэрэг буюу 10,6 хувь нь ням гарагт бүртгэгдсэн байна.

Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн улмаас 3786 иргэнд 4.959.557402 төгрөгийн хохирол учирсаны 1.624.670.963 төгрөг буюу 32.7 хувийг нь нөхөн төлүүлжээ.

Хулгайлах гэмт хэрэгт 2013 оны эхний 10 сарын байдлаар 1955 хүн холбогдон шалгагдсаны 333 буюу 17,0 хувь нь эмэгтэй, 180 буюу 9,2 хувь нь хүүхэд, 1118 буюу 57.1 хувь нь 18-30 насны, 233 буюу 11,9 хувь нь 30-35 насны, 424 буюу 21.6 хувь нь 35-аас дээш насны хүмүүс байгаагийн 12 буюу 0,6 хувийг төрийн албан хаагч, 94 буюу 4,8 хувийг хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч, 170 буюу 8,7 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгч, 29 буюу 1,4 хувь нь малчин, ажилчин, 81 буюу 4,1 хувь нь оюутан, 51 буюу 2,6 хувь нь сурагч, 7 буюу 0,3 хувь нь сургууль завсардсан, 25 буюу 1,2 хувь нь тэнэмэл, 1455 буюу 74,4 хувийг ажилгүй хүмүүс эзэлж байна.

Гэмт хэрэгт холбогдогсдын 268 буюу 13,7 хувь нь согтуугаар, 377 буюу 19,2 хувь нь бүлэглэж, 44 буюу 2,2 хувь нь эрэн сурвалжлагдаж байсан, 10 буюу 0,5 хувь нь захиргааны хяналтанд байсан, урьд ял шийтгэгдсэн 156 буюу 7.9 хувь гэмт хэрэг үйлджээ.

Нийслэл хотын хэмжээнд үйлдэгдсэн хулгайлах гэмт хэргээс халаасны хулгайн гэмт хэрэг, авто тээврийн хэрэгсэл хулгайлах, мал хулгайлах гэмт хэргийн үйлдэгдэж байгаа арга хэлбэр ерөнхий байдлыг тодорхойлж үзвэл:

Авто тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэгт тээврийн хэрэгсэл төдийгүй түүний эд анги, сэлбэг хэрэгсэл, толь, дугуй, аккумулятор, бүтээлэг зэрэг эд зүйл алдагдах гэмт хэрэг тогтмол гарч байгаад дүгнэлт хийж, зориулалтын харуул хамгаалалттай зогсоол, грашид машинаа тавьдаг байх, жолооч нар машиндаа дохиолол суулгах, (учрах хохирол, эрсдэлээс урьдчилан сэргийлж даатгалд хамруулах, дохиолол хамгаалалтын систем суурилуулах), тээврийн хэрэгслийн шинэ болон хуучин сэлбэгийг худалддаг цэгүүд, дамжуулан борлуулдаг ченжүүдийн сүлжээг хяналтад авах (автомашинны аккумулятор, толь, дугуй, радио техник хэрэгсэл болон бусад эд ангиуд), автомашинны зориулалтын болон задгай граж, нэгдсэн зогсоолуудын байршлыг дохиолол, телекамерын хяналтанд бүрэн хамруулах.

Мал хулгайлах гэмт хэрэг 94 бүртгэгдэн өмнөх оны мөн үеэс 32 нэгжээр буюу 51.6% өсч, илрүүлэлт 25,3 хувьтай, өмнөх оны мөн үеэс 15.4 пунктээр буурсан. Тухайлбал: Баянгол дүүргийн 2 дугаар хэлтэст 1 хэрэг бүртгэгдэж илрээгүй илрүүлэлт 0,

Баянзүрх дүүргийн 1 дүгээр хэлтэст 26 хэрэг бүртгэгдэж бүгд сэжигтэн этгээд нь тогтоогдоогүй илрүүлэлт 0, Сүхбаатар дүүргийн 2 дугаар хэлтэст 7 хэрэг бүртгэгдэж илрүүлэлт 0, Чингэлтэй дүүргийн 2 дугаар хэлтэст 3 хэрэг бүртгэгдэж илрүүлэлт 0 байгаад анхаарч, мах, махан бүтээгдэхүүн худалдан борлуулдаг цэгүүдэд тавих хяналтыг сайжруулж, гүйцэтгэх ажлын хүч хэрэгслийг чиглүүлэх, эргүүлээр тавих хяналтыг сайжруулж малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажлаа эрчимжүүлж таслан зогсоох шаардлагатай байна.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх ажлыг эрчимүүлэхэд Нийслэл хот руу орох шалган нэвтрүүлэх товчоодын үйл ажиллагааг эрчимжүүлэх, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд бус байнгын хяналт шалгалтыг тогтмол явуулах, камержуулах, мал, мах, тэдгээрийн түүхий эдийн төвлөрлөсөн зах, худалдааны төв, үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж махны гарал үүслийн гэрчилгээнд тавих хяналтыг чангатгах, Налайх дүүргийн “Цайз”, Сонгинохайрхан дүүргийн “Эмээлт” захад малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх цагдаагийн тасаг, хэсэг байгуулах ажлыг судлан шийдвэрлэх шаардлагатай байна.

Халаасны хулгайн гэмт хэрэг 302 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 136 нэгжээр буюу 81.9 хувиар өсч, илрүүлэлт 38.6 хувьтай, өмнөх оны мөн үеэс 3.0 хувиар өссөн байна. Халаасны хулгайн гэмт хэрэг үйлдэгдээд байгаа тодорхой хороонд, тухайлбал, Баянгол дүүргийн 3, 5 дугаар 15 хэрэг, 14, 15, 16 хороонд 19 хэрэг, 20 хороонд 9 хэрэг, Баянзүрх дүүргийн 13 дугаар хороонд 7 хэрэг, 14 хороонд 15 хэрэг, Чингэлтэй дүүргийн 1, 2, 3 дугаар хороонд 36 хэрэг, Сүхбаатар дүүргийн 1-4, 6, 8 дугаар хороонд 104 хэрэг буюу нийт бүртгэгдсэн хэргийн 67.8 хувь буюу дийлэнх нь эдгээр хороонд үйлдэгдэж байгаа тул эргүүлийн чиглэл маршрутыг зөв зохион байгуулж, цагдаагийн болон олон нийтийн эргүүл, аж ахуйн нэгж байгууллагын хяналтын камер, харуул хамгаалалтын хүчээр гарч байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломжтой байна. Нийслэлийн хэмжээнд халаасны хулгайн гэмт хэрэг ихээр үйлдэгддэг учраас онцгойлон анхаарал хандуулах шаардлагатай байна.

Иргэдийн бухимдсан, хохирсон асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэх, ажлын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд энэ төрлийн гэмт хэрэг үйлддэг этгээдүүдийг бүртгэлд бүрэн авах, хяналтад байлгах, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн тохиолдолд оногдуулах хариуцлагыг чангатгах, Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх, автобус нийтийн тээврийн хэрэгслийн зорчигч орох, буух хэсэгт бичил камер байршуулах, нийтийн зах, худалдааны төв, дэлгүүрийн камерын хяналтыг чанаржуулах, иргэдэд халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл, сэрэмжлүүлгийг тогтмол хүргэх, иргэд цагдаагийн байгууллагын хамтын ажиллагаа уялдаа холбоог сайжруулж мэдээллийг цаг алдалгүй шуурхай авч шалгаж шийдвэрлэдэг байх.

**Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэхэд дараах асуудалд анхаарах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:**

1. Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хандлага, арга барилаа өөрчлөх. Хулгайн гэмт хэрэг нь нийт гэмт хэргийн ихэнх хувийг эзэлдэг, их хэмжээний хохирол учруулдаг, үйлдлийн арга хэлбэр улам нарийн болсон, төр засаг, нийгэм, иргэд жирийн сөрөг үзэгдэл мэтээр үзэж, энэ дасал болчихсон хандлагыг өөрчилж, үүнтэй тэмцэх үйл ажиллагааг шинэлэг байдлаар явуулах, тэмцэх хүн хүчээ бэхжүүлэх, орчин үеийн шинэлэг техник технологийг ашиглах нь зүйтэй.

2. Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, эрх зүйн болон үйл ажиллагааны хувьд цогц байдлаар тэмцэх шаардлагатай байна.

Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчноо сайжруулах чиглэлээр:

- Хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорих ял шийтгэхээс илүү эдийн засгийн хөшүүрэг хэрэглэж тэмцэх, учруулсан хохирлын хэмжээнээс хамааран түүнээс хэд

дахин хэмжээний төгрөгөөр торгодог, төлбөрийн чадваргүй бол албадан ажил хийлгэдэг байх,

- Хулгайлах гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хамааруулан тооцоолох бус, бодит хохирлын тодорхой тоон дүнгээр хулгайлах гэмт хэрэг мөн эсэхийг авч үздэг болох, /эд зүйлийн үнэлгээг оновчтой тогтоох/,
- Хөнгөн, хүндэвтэр ангиллын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг сунгах,
- Хулгайн гэмт хэргийн талаарх үнэн зөв, бодит мэдээлэл өгсөн шударга иргэний аюулгүй байдал, мэдээллийг нууцлалыг хангах асуудлыг анхаарч, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох,

3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх тухай заалт бүр хэрэгжихгүй байна. Иймд хуулийн заалтыг нийслэлийн хэмжээнд жинхэнэ утгаар хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Иргэдээс төлбөртэйгээр мэдээлэл авах, урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх, хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хүн хүчийг бэхжүүлэх, чадавхжуулах, мэргэшүүлэх, орчин үеийн техник хэрэгсэл худалдах авах үйл ажиллагаанд зарцуулах шаардлагатай гэж үзэж байна.

4. Нийслэл, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс харъяа цагдаагийн газар, хэлтсийн судалгааны багийн үйл ажиллагааг дэмжиж, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгаанд үндэслэсэн урьдчилан сэргийлэх ажлыг түлхүү зохион байгуулах, хөрөнгө, санхүүгийн туслалцаа үзүүлж хамтран ажиллах нь илүү үр дүнтэй байх болно.

5. Хулгайн гомдол, мэдээллийг шалгах явцад хохирлын хэмжээ хүрэхгүй үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, хэрэгсэхгүй болгосон тохиолдолд гэм буруутай бол заавал Захиргааны хариуцлагын тухай хуулийн 36 дугаар зүйлд зааснаар хариуцлага оногдуулдаг байх,

6. Хулгайн гэмт хэрэг голлон үйлдэж буй 18-30 насны, ажилгүй залуучуудыг нийгмийн хариуцлагаа ухамсарласан аж ахуйн нэгж, байгууллага, компанид ажилд зуучлуулан оруулах, тэднийг дэмжих, урамшууллын механизм хэрэглэх, мөн урьд нь хулгайн гэмт хэрэг үйлдсэн этгээд дахин үйлдэж байгаад дүгнэлт хийж нийслэл, дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс санаачлан зохион байгуулж, аливаа хэлбэрээр тэдэнд дэмжлэг үзүүлэх, нийгэмшүүлэх,

7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд хорооны Засаг дарга, нийгмийн ажилтан, зохион байгуулагч, хэсгийн ахлагч нарыг татан оролцуулах, тэднийг улирал тутам гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтад хамруулдаг байх,

8. Хулгайн гэмт халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр оршин суугчдын дунд “Иргэдийн үүсгэл санаачлага”-ыг дэмжсэн нөхөрлөл, холбоо, эргүүл зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах асуудлыг урамшууллын асуудалтай нь бодитой шийдвэрлэх,

Цаашид бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, үүний дотор урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, мөрдөн шалгах, ял шийтгэлийн бодлогыг өргөн хүрээнд хөндөж, эрх зүйн орчинг сайжруулах, орчин үеийн шинэлэг арга, хэлбэрээр эрчимтэй тэмцэх шардлагатай байна.



## **ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХЭД ОРЧИН ҮЕИЙН ТЕХНИК, ТЕХНОЛОГИ АШИГЛАХ НЬ**

*Г.Бямбадорж*

*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх  
зүйн тэнхимийн багш, докторант, цагдаагийн ахмад*

Орчин цагт гэмт хэрэг, гэмт хэрэгтэнтэй тэмцэхэд шинжлэх ухаан, технологийн дэвшлийг өргөнөөр нэвтрүүлж ашиглах нь нэн тулгамдсан асуудал болоод байна. Гадаадын улс орнууд гэмт хэрэгтнүүдийг мөрдөх, тэдний үйлдсэн гэмт хэргийг илрүүлэх нотлох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход уламжлалт аргаас гадна шинжлэх ухаан, технологийн аргуудыг өргөнөөр ашиглаж эхэлсэн нь үр дүнтэй байна.<sup>13</sup>

Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүн амын төвлөрөл, барилгажилт, хот төлөвлөлт, хотын амьдралын хэв маяг, нийгмийн ёс суртахууны доройтол, хотжилтыг даган эрчимжиж буй гэмт явдлын чиг хандлага, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөл зэргийг харьцуулан судалж цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээ онолын болон практикийн түвшинд тодорхойлж, ажиллах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Гэмт хэргийн гаралт нийгэм улс төр, эдийн засаг, ажилгүйдэл, ядуурал зэрэг нөхцөл байдлаас шалтгаалж байгаа ч нийслэл хотод шилжин суурьших хөдөлгөөн нэмэгдэж хүн амын нягтрал их байгаатай холбоотойгоор нийслэлд гэмт хэргийн гаралт нэмэгдсээр байна. Тэр тусмаа гудамж талбай олон нийтийн газар үйлдэгдэж буй хулгай, дээрэм, танхайн өмчлөх, иргэдийн амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргүүд өсөх хандлагатай байна.

Өнөөдөр гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх үүрэг бүхий хэрэг бүртгэх, мөрдөн байцаах газар, эрүүгийн цагдаагийн газар, нийслэлийн цагдаагийн газар, нийгмийн хэв журам хамгаалах газар, замын цагдаагийн алба, аймаг дүүргүүдийн цагдаагийн газар, хэлтэс зэрэг олон алба гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, иргэдийн аюулгүй байдлыг хангах, үүрэг гүйцэтгэж байгаа ч үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил бүрийг бүрэн дүүрэн илрүүлж чадахгүй байна.

Шинэчлэн найруулсан цагдаагийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлд цагдаагийн албаны үйл ажиллагаа, удирдлагын үндсэн зарчмыг шинээр хуульчилсан ба уг зүйлийн 4.1-д Цагдаагийн алба, алба хаагч нь үйл ажиллагаандаа “Монгол Улсын Үндсэн хууль, Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаас гадна хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, нууцыг чанд хадгалах, олон нийтийн итгэл хүлээж иргэний дэмжлэгийг авах, төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн өөрөө удирдах

<sup>13</sup> Цагдаа судлал сэтгүүл 2013. №3. 47 дахь тал

байгууллага, иргэдтэй харилцан хамтран ажиллах, **шинжлэх ухаан, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээний ололтыг ашиглах**, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх үндсэн зарчмыг баримтална<sup>14</sup>” гэж заасан нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулах эрх зүйн үндсийг зааж өгсөн байна.

Мөн хуулийн 21-р зүйлд Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий 5-7 иргэний төлөөллөөс бүрдсэн орон тооны бус Иргэний зөвлөл аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд байна. 21.6.2-д Иргэний хяналтын зөвлөл нь цагдаагийн алба хаагчийн сургалт, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг нэвтрүүлэх бодлогын хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй гэж тусгасан нь шинэчлэн найруулсан цагдаагийн албаны хуулийн 4-р зүйлд заасан зарчмыг хэрэгжилтыг хангаад зогсохгүй цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг үйл ажиллагааг сайжруулах, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж ашиглах чухал ач холбогдолтой заалт болсон гэж бид үзэж байна.

Гэмт хэргийн гаралтыг хүн амын өсөлттэй холбон авч үзвэл:

Монгол улсын хүн амын өсөлтийн үзүүлэлт.

График №1



Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор суурин хүн амыг Монгол Улсын нутаг дэвсгэрт болон гадаадад тоологдсон гэж нарийвчилж авч үзэх боломжтой болсноороо өмнөх тооллогоос ихээхэн онцлогтой болжээ.

Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин сууж байгаа болон албан ёсны бүртгэлтэй 2647.6 мянга, гадаадад улсад оршин сууж байгаа 107.1 мянган хүн тоологдож, суурин хүн ам 2754.7 мянга болжээ.

Монгол Улсын хүн ам 2000-2010 оны хоорондох 11 жилийн хугацаанд 16.1 хувиар өсч, жилийн дундаж өсөлт нь 1.5 хувь болсон байна. Өсөлтийн энэ хувь өмнөх тооллого хоорондынхоос 0.1 пунктээр илүү болсон нь хүн амын ердийн хөдөлгөөний цэвэр өсөлт сүүлийн арван жилд илүү байсан, 1990-ээд оны эхний хагаст гадаадад олон арван мянган хүн шилжин суурьшсан шиг томоохон хөдөлгөөн гараагүйтэй холбоотой<sup>15</sup>. Хүн амын өсөлт энэ хэвээр үргэлжилбэл Монголчууд бид 2040 гэхэд 4 сая болох судалгаа гарчээ.

Монгол улсын хүн ам өсөж хотжих үйл явц эрчимтэй явагдаж байгаа цаг үеэ дагаад гэмт хэргийн гаралт нэмэгдэж байна.


Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлт.

График №2

<sup>14</sup> legalinfo.mn. Шинэчлэн найруулсан Цагдаагийн албаны тухай хууль

<sup>15</sup> Хүн ам орон сууцны тооллогын материал 2010 он.





Дээрхи тоон үзүүлэлтүүдээс үзэхэд гэмт хэргийн гаралт арван жил тутамд тогтвортой өсөж байгаа нь харагдаж байна. Энэ нь хүн амын өсөлт болон нийгэм, улс төр, эдийн засгийн зэрэг бусад нөхцөл байдлаас шалтгаалж байгаа ч цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох үйл ажиллагаанаас ихээхэн хамааралтай.

Нөгөө талаар цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа хууль эрх зүйн орчин, бүтэц зохион байгуулалт, арга барил, техник хэрэгсэл, тоног төхөөмжийн хоцрогдол, доголдолтой холбоотой байж болох юм.

Ийм учраас цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, явдлын шалтгаан, нөхцлийг тогтоох ажлыг тэргүүлэх чиглэл болгон тодорхойлж, гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журам сахиулах үйл ажиллагаанд “Secure alert” буюу цахим хянагч “Электрон гав”, Полиграф, GPS, Comp.stat, Crime mapping, CCTY зэрэг орчин үеийн smart системүүдийг нэвтрүүлж ашиглах зэргээр хууль сахиулах салбарт инноваци хийх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

Монгол улсын хүн амд ноогдох цагдаагийн алба хаагчийн тооноос шалтгаалж гудамж талбай болон гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүдийг хянаж чадахгүй байгаа учир иргэдийн аюулгүй байдлыг хангахад нийт гудамж талбайг гэрэлтүүлэх, хянах, тогтолцоог сайжруулж, бүх гудамж талбай болон гэр хорооллыг цахилгааны шон дагуу камержуулах. Английн цагдаагийн байгууллагын нэвтрүүлсэн CCTV буюу камерын хяналтын системийг нэвтрүүлж ашиглах шаардлагатай байна.

Английн цагдаагийн байгууллага энэхүү системийг ашиглаж үйлдэгдсэн гэмт хэргийнхээ 90% илрүүлж чадаж байна энэхүү үйл ажиллагаандаа “Поли фейс” системийг давхар ашиглаж байна.

Тэгэхээр нийслэл хотын дүүрэг бүрт байрлах хяналтын төв байгуулж камеруудыг хянаж, эргүүлийн үүрэг гүйцэтгэх үүрэг бүхий цагдаа нарыг гэмт хэргийн талаар тогтмол мэдээллээр хангаж, гэмт хэрэг үйлдэгдэх магадлалтай харанхуй булан тохой, зэрэг гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй газрыг хяналтандаа авч гэмт хэргээс урьдчилан сэргийлж ажиллах.

Хяналтын систем нэвтрүүлснээр хаана гэмт хэрэг үйлдэгдэх бол гэсэн байдлаар гудамжаар үр ашиггүй холхих биш гэмт хэрэг гарсан болон сэжигтэй үйлдэл илэрсэн тохиолдолд газар дээр нь шуурхай очиж илрүүлэх боломжтой болно.

Нөгөө талаар гэмт хэрэг үйлдэгдсний дараа гэмт хэрэгтнээ хайдаг биш, гэмт хэргийг газар дээр нь илрүүлдэг, гэмт хэрэгтэнтэй хөөцөлддөг биш гэмт хэргийг урьдчилан сэргийлж, таслан зогсоож чаддаг хууль сахиулагчид бий болно.

CCTV системийг нэвтрүүлснээр дараах ач холбогдолтой байна.

- Гэмт хэрэгтэнээ хайхад үрэгддэг үр ашиггүй цаг хугацаа зардал хэмнэгдэнэ.
- Иргэний амьд явах эрх болон аюулгүй орчинд амьдрах эрх баталгаажина.
- Гэмт хэргийн гаралт багасаж, олон нийтийн газар гудамж талбайд үйлдэгддэг танхай, дээрэм бусад гэмт хэрэг эрс багасна.
- Цагдаагийн алба хаагч нарын амрах цаг бага ч болов нэмэгдэнэ.

- Цагдаагийн байгууллагын нэр хүнд өсөж жинхэнэ утгаараа хяналтыг бий болгож чадна.
- Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь нэмэгдэх зэрэг олон ач холбогдолтой болно.

Мөн гэмт хэргийн тоо үзүүлэлтэнд дүн шинжилгээ хийдэг европын орнуудын цагдаагийн байгууллагад хэрэглэдэг “Comp.stat” системийг нэвтрүүлж ашиглах шаардлагатай байна. Анх 1994 онд АНУ-ын Нью-Йорк хотод цагдаагийн комиссар Уильям Браттон цагдаагийн хэлтсийн мэдээлэлд суурилсан удирдлагын загварыг танилцуулсан бөгөөд энэхүү загвар нь АНУ даяар маш хурдан тархаж энэ нь гэмт хэрэг бууруулахад чиглэсэн орчин үеийн менежментийн загвар болж чадсан байна.<sup>16</sup>

Comp.Stat загвар нь гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөл, стратегийн ач холбогдолтой асуудлыг шийдвэрлэх, тодорхой үйл ажиллагаанд анализ хийх, гэмт хэргийн гаралт, төрөл, гэмт хэрэг гарсан цэг бусад нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлоход ашиглагдаж байгаа мэдээ мэдээлэл, түүний үнэн зөв эсэхийг цаг хугацаанд нь дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлж байна.

Энэхүү нөхцөл байдлын үнэлгээн дээр тулгуурлан, тохирсон хариу арга хэмжээ авах, алба хаагч ажилтан болон нөөц хүчийг зохих газар хурдацтай байршуулах, байдлаар хэрэгжүүлж байна.

Comp.Stat загварын хүрээнд нь асуудлыг шийдвэрлэх, шинжилгээ хийх, хариуцлагын тухай олон давхаргат загварыг ашиглаж байна. Олон давхаргат загвар нь гэмт хэрэг бууруулах “стратег”-аас урт хугацааны асуудлуудыг хэрэгжүүлэх загвар юм.<sup>17</sup>

Иймд Comp.stat системийг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлж ашигласнаар тухайн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдалд долоо хоног бүр дүн шинжилгээ хийж тухайн долоо хоногт үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэргийн төрөл, гэмт явдлын шалтгаан нөхцөл, тохироо, гэмт хэрэг үйлдэгч, хохирогч, халдлагын зүйл зэрэгт дүн шинжилгээ хийж цаашид авах арга хэмжээг төлөвлөж ямар ямар гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байна түүнийг бууруулах урьчилан сэргийлэх үйл ажиллагаагаа оновчтой тодорхойлох, гэмт явдалд прогноз хийх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Өнөөгийн байдлаар цагдаагийн байгууллагын мэдээлэл судалгааны алба үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт, гэмт хэргийн төрөл, өсөлт бууралт, хэргийн ангилал, халдаж буй нийгмийн харилцаагаар нь, гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаагаар сар бүр дүн шинжилгээ хийж байгаа ч энэхүү статистик мэдээг гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд ашиглахад төдийлөн үр дүнд хүрдэггүй байна. Энэ нь үндсэндээ гэмт хэргийн статистик үзүүлэлт, ажлын тайлан хэлбэртэй л байна.

Түүнчлэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаад “Crime mapping” буюу гэмт хэргийн зураглал үйлдэх системийг бүрэн ашиглаж болно.

“Crime mapping” буюу гэмт хэргийн зураглал нь: Гэмт хэрэг явдлын гаралт, төрөл, ангилалтыг зурагт төсөөлөн харах болон гэмт явдлыг шинжлэхийн тулд хууль сахиулах байгууллага ашигладаг систем юм.

Энэ нь гэмт хэрэгт дүн шинжилгээ хийх, цагдаагийн стратегийн Comp.Stat загварын нэг гол бүрэлдэхүүн хэсэг юм. “Crime mapping” буюу гэмт хэргийн зураглал үйлдэх системийг газар зүйн мэдээллийн систем (GIS) ашиглан бусад чиг хандлага, гэмт явдлын төлөв байдлыг шинжээчийн тусламжтайгаар тодорхойлж гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй цэгүүдийг тодорхойлох боломжийг олгодог систем юм.<sup>18</sup>

Энэхүү системийг ашигласнаар тухайн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийг зураглал дээр тусгай тэмдэглэлээр тэмдэглэж ямар гэмт хэрэг өссөн, аль дүүрэг хороонд хэд хэчнээн гэмт хэрэг үйлдэгдсэн, ямар төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байгааг аль ч үед

<sup>16</sup> <http://www.compstat.umd.edu>

<sup>17</sup> <http://www.compstat.umd.edu>

<sup>18</sup> [http://en.wikipedia.org/wiki/Crime\\_mapping](http://en.wikipedia.org/wiki/Crime_mapping).

(шаардлагатай үед) харж болох боломжтой бөгөөд энэхүү зураглалыг “Comp.stat системтэй хослуулан ашиглавал илүү үр дүнд хүрч болно.

Тэрчлэн үйлдэгдсэн гэмт хэргийн байдалд дүн шинжилгээ хийж аль дүүрэг хороонд ямар төрлийн гэмт хэрэг өсөж байна тэр дүүрэг хороонд эргүүлийн чиглэлийг түлхүү ажиллуулах, хяналтын системийг түлхүү ашиглах зэрэг үйл ажиллагаагаа сайжруулах ач холбогдолтой юм.

Түүнээс гадна цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журам сахиулах үйл ажиллагаанд “Secure alert” буюу цахим хянагч “электрон гав”, полиграф, GPS зэрэг орчин үеийн smart системүүдийг нэвтрүүлж түлхүү ашиглах шаардлагатай байна.

“Secure-alert” буюу цахим хянагч төхөөрөмжийг нэвтрүүлж ашигласнаар шүүгч, хамгаалалтанд байгаа гэрч хохирогч болон ял тэнссэн, гэрийн хорионд байгаа ялтан, батлан даалтан байгаа сэжигтэн, гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл үйлдэгчид зэрэг өндөр эрсдэлтэй гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй бусад хүмүүст зориулсан тусгай техникийн тусгай шийдэлтэй хүч хэрэглэдэггүй байрлал тогтоох GPS системийн тусламжтайгаар үр дүнтэй хяналт тавих төхөөрөмж юм.

2013 оны 07-р сарын 05-ны өдөр батлагдсан Тахарын албаны тухай хуулийн 6-р зүйлийн 6.7-д Тахарын алба нь шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцлийг бүрдүүлэх үндсэн бүтэц нь дараах чиг үүрэг бүхий нэгжтэй байна.

6.7.1.Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах.

6.7.2.Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах.

6.7.3.Мөрдөн шалгах, эрэн сурвалжлах.

6.7.4.Яллагдагч, ялтныг хуяглан хүргэх, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах.

6.7.5.Бусад нэгж<sup>19</sup>.

Дээрхи заалтын 6.7.1-д “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах” гэж заасан нь Тахарын албаны чиг үүргийг тодорхойлоод зогсохгүй шүүгчийн аюулгүй байдлыг хангахад энэхүү төхөөрөмжийг зайлшгүй хэрэглэх шаардлагатай байгааг харуулж байна. Харин шинэчлэн найруулсан цагдаагийн албаны тухай хуулийн 11.1.5-д “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу гэрч, хохирогчийг хамгаалах” гэсэн заалт шинээр оруулсан бөгөөд цагдаагийн байгууллага гэрч, хохирогчийг хамгаалах ажлын хүрээнд “Secure-alert”төхөөрөмжийг ашигласнаар гэрч, хохирогчийн хаана байгааг мэдэх, цагдаагийн байгууллагын тогтоосон аюулгүй бүст байгаа эсэхийг хянах боломжтой болох юм. Ингэснээр гэрч, хохирогчийг хамгаалах үүргээ амжилттай биелүүлэх нэг нөхцөл бүрдэнэ.

GPS (Global positioning system) буюу дэлхийн хэмжээнд байрлал тогтоох системийг АНУ болон дэлхийн бусад улс орнууд өргөнөөр ашиглаж байгаа билээ. Уг системийг 2006 онд анхлан сэжигтний гаранд электрон бугуйвч зүүж, хэрэв байх ёстой газраас хэтэрвэл хиймэл дагуулаар дамжин удирдлагын компьютерт мэдээлэл өгөх байдлаар хэрэглэх болжээ.

Тус мужийн шүүхээс хэрэгтэнд уг бугуйвчийг зүүлгэх асуудлыг хуулиар зөвшөөрдөг бөгөөд одоо АНУ-ын хэд хэдэн мужид уг хууль үйлчилж эхэлсэн байна.

Оклахомад GPS-ээр гэмт хэрэгтнийг хянах асуудлыг 100%-ийн саналаар баталсан бөгөөд. Энэхүү системийн бас нэгэн давуу тал нь хөрөнгө мөнгийг хэмнэдэг. Тухайлбал: Масачусетс мужийн цагдаагийн хэлтсийн дарга Паул Лүччигийн ярьснаар “Гэмт этгээдийг шоронд хориход жилд 30-40 мянган ам.доллар шаардлагатай. Харин GPS-ийг ашиглахад жилд 3400 ам.доллар л шаардлагатай гэсэн тооцоо гаргасан байдаг.

GPS системийг дээр дурьдснаас гадна гэмт хэрэгтэй тэмцэх ажилд дараах байдлаар ашиглаж болно.Үүнд:

---

<sup>19</sup> Legalinfo.mn Тахарын албаны тухай хууль

- Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн захиргааны хяналтанд байгаа этгээдийг хянах.
- Бага насны хүүхдийг гэмт халдлагад өртүүлэхгүй байх. Нэн ялангуяа хүний наймаа, эд эрхтэний наймааны золиос болгохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор ашиглах.
- Тээврийн хэрэгсэл, үнэт эдлэлд суулгах.
- Бурхан, үзмэр, хосгүй үнэт зүйлс гэх мэт түүх соёлын дурсгалт болон бусад эд зүйл хулгайлагдахаас урьдчилан сэргийлэх, ийм төрийн гэмт хэргийг илрүүлэх.
- Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх зэрэгт ашиглаж болно.<sup>20</sup>

Үүнээс гадна цагдаагийн байгууллагын гэмт хэрэг илрүүлэх үйл ажиллагаанд ашиглаж байгаа гарын мөрний папилон сангийн системийг криминалистикийн шинжээч томилж дүгнэлт гаргуулах байдлаар ашиглаж байгаа нь гэмт хэргийг түргэн шуурхай халуун мөрөөр нь илрүүлэхэд учир дутагдалтай байна.

Учир нь гарын мөрний адилтгалын шинжилгээ хийлгэхээр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор тогтоол үйлдэж, Шүүхийн шинжилгээний үндэсний төвд хандаж олон шат дамжлага дамжиж шинжээчийн дүгнэлт гардаг. Шинжээчийн дүгнэлт нь шүүх хурал дээр тухайн гэмт этгээдийн хууль бус үйлдлийг нотлох баримт болон үнэлэгдэж байгаа ч гэмт хэргийг халуун мөрөөр нь илрүүлэх арга хэрэгсэл болгон ашиглах боломжийг нээж өгөх шаардлагатай байна.

Криминалистикийн шинжээч хэргийн газарт үзлэг хийх явцад тухайн газраас илрүүлж, бэхжүүлсэн гарын дардасыг папилон санд байгаа хүмүүсийн гарын дардастай харьцуулах, гарын дардасаар хэн болохыг нь түргэн хугацаанд газар дээр нь тогтоодог техник, хэрэгсэлтэй болгох шаардлагатай.

Түүнчлэн санд байгаа гарын дардас нь заавал суурин техник хэрэгсэлтэй газар ашиглагдаж байгаа учир орчин үеийн гарын мөрний адилтгал хийх зөөврийн техник хэрэгслийг нэвтрүүлж, ашиглах шаардлагатай. Одоогийн байдлаар ШШҮТ-д зөөврийн хоёр техник хэрэгсэл байгаа тул хоногт үйлдэгдсэн гэмт хэрэг бүрийг илрүүлэхэд бүрэн ашиглаж чадахгүй байна.

Эдгээр орчин үеийн техник, технологи, тоног төхөөрөмж, системүүдийг ашигласнаар цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журам хамгаалах үйл ажиллагаа эерэг үр дүнд хүрэх нь ойлгожтой.

---

<sup>20</sup> Цагдаа судлал сэтгүүлийн 2013. №3 47 дахь тал

## НЭГ ХҮНИЙ ГЭРЭЛ ЗУРАГНЫ ЗАЙ ГАРГАХ

О.Батжаргал

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын  
тэнхимийн дэд профессор, цагдаагийн хурандаа

### МОНГОЛ УЛСАД ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

*Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах асуудалд бүх салбаруудын хувьд, түүгээр ч барахгүй Засгийн газрын хувьд ч бага хурал зохион байгуулах, эсвэл зөвлөмж гаргаад үүнийгээ хийсэн ажил гэж санаа нь амардаг. Олив Кобусинги – НҮБ-ын Африк дахь бүс нутаг хариуцсан зөвлөх*

Авто ослын улмаас учирсан хохирол нь тэр бүр мэдээлэгдэж олон нийтийн анхааралд хүрдэггүйгээс хэдэн зуу, мянган зам тээврийн осол нь зөвхөн түүнд нэрвэгдсэн хүмүүсийн асуудал болж салангид үйл явдал мэтээр ойлгогдож байхад галт тэрэг юм уу нисэх онгоцны осол нь олон нийтэд түүнээс илүү хүнд цочрол өгдөг.

Баруун Европ болон АНУ-д 1970-аад он хүртэл зам тээврийн нас баралт гэмтэл хурдацтай өсч байсан боловч осолд “нэрвэгдэгсдийг буруутгах” зарчмаас татгалзсанаар 1980-1990 онд тээврийн хэрэгсэл болон хүн амын тоо өсөн нэмэгдэж байгаа нөхцөлд зам тээврийн хэргийн нас баралт гэмтлийг 50% бууруулж чадсан байна. Энэ нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг удирдах системийн шинэ хандлагын үр дүн юм. Өөрөөр хэлбэл замын нөхцөл, тээврийн хэрэгслийн техникийн байдлыг хөдөлгөөнд оролцогчдын буруутай үйлдлээс салгахгүйгээр хамтруулан авч үзэх явдал юм. Гэтэл манай улсад хөгжингүй орнуудын гаргаж байсан алдааг давтаж хөдөлгөөний аюулгүй нөхцөлийг нь бүрдүүлээгүй байж жолоочийг буруутгаж байгаа нь энэ шинэ хандлагад нийцэхгүй байна. Гэхдээ шинэ хандлага нь жолоочийн хариуцлагын тухай асуудлыг огтхон ч бууруулаагүй юм.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах асуудалд иж бүрнээр хандахгүйгээр түүний сөрөг үр дагавар болох осол хэрэг, нас баралт гэмтлийн өсөлт, тээврийн хэрэгслийн хэт төвлөрөлт, хөдөлгөөний нягтрал түгжрэл үүсгэж байгааг зөвхөн ажил хариуцсан ганц нэг хүн, байгууллага шийдчих асуудал биш бөгөөд тэр байтугай хөгжил буурай орнуудын хувьд өөрсдөө дангаараа шийдвэрлэх боломжгүй бэрхшээлүүдтэй ч тулгарч байна.

Өнөөдөр дэлхий дээр жил бүр авто ослын улмаас 1.3 сая хүн амь насаа алдаж, 50 сая хүн насан туршийн эрэмдэг зэрэмдэг болж байна.<sup>21</sup> Авто ослын нас баралтын түвшин хумхаа болон сүрьеэ өвчний нас баралтын түвшинтэй ижил байгаа юм. Сүрьеэ өвчнөөр өвчлөгсдийн тоо жилд 1%-иар өсч байна. 2015 он гэхэд дээрхи халдварт өвчнийг арилгах талаар НҮБ-ын мянганы тунхаглалд тодорхойлсон байна. Гэтэл зам тээврийн осолд өртөгсдийн тоо 2020 он гэхэд түүнээс 5 дахин өсөх хандлагатай байгаа тул энэ асуудалтай холбогдох хүч хөрөнгийн талаар шийдвэрлэх шаардлагатай болжээ.

Энэ байдалд дүгнэлт хийж улс орнууд, байгууллага, хувь хүмүүс нэгдэж “Дэлхий нийтээрээ хөдөлгөөний аюулгүй байдлын төлөө тэмцэх хороо” байгуулан ажиллаж эхэллээ. Энэхүү хорооны тэргүүлэгч НАТО-ийн Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж

<sup>21</sup> [www.piarcc.org](http://www.piarcc.org) “Дэлхийн авто замын нийгэмлэг”-ийн хөдөлгөөний аюулгүй байдлын илтгэл

байсан Англи улсын иргэн Лорд Робертсон “Дэлхий нийтээрээ замын үхэлтэй тэмцэх цаг боллоо” гэж уриалсан<sup>22</sup>.

2004 онд НҮБ-аас “Хөдөлгөөний аюулгүй байдал-зам тээврийн осол гэмтэлийн тухай” Дэлхийн илтгэлийг нийтлүүлсэн.

2010 онд хөдөлгөөний аюулгүй байдлын асуудлаар зам тээврийн сайд нарын дэлхийн анхдугаар уулзалт Москва хотноо зохион байгуулагдаж 2011-2020 оныг “Хөдөлгөөний аюулгүй байдлын үйл ажиллагааны 10 жил” болгохоор уриалсныг НҮБ дэмжиж тунхаг гаргасан юм. Энэ 10 жилийн хугацаанд дэлхий нийтээрээ замын осол гэмтэл, нас баралтыг 2 дахин бууруулах өндөр зорилт дэвшүүлсэн байна.

Энэ асуудалд системтэй хандах үүднээс НҮБ-ын тунхаг болон “Дэлхийн илтгэлд” улс орны засгийн газрууд үйл ажиллагаандаа тусгах баримжаа болгох чиглэлээр

- Үндэсний замын хөдөлгөөний аюулгүй байдлыг дээшлүүлэхэд хүчин чармайлтаа чиглүүлэх Засгийн газрын тэргүүлэгч бүтцийг тодорхойлох.
- Хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний стратеги үйл ажиллагааны төлөвлөгөөг бэлтгэх зэрэг 6-н гол зөвлөмж гаргасан байна.

Үүний дагуу Монгол улс ч 2020 он хүртэлх замын хөдөлгөөний аюулгүй байдлын стратеги, төлөвлөгөөг боловсруулан гаргаж, Үндэсний хороогоо байгуулаад байна. НҮБ-ын хөдөлгөөний аюулгүй байдлын 10 жилийн ажиллагаа 2011 оны 5 дугаар сарын 11-нд дэлхий даяар албан ёсоор нээлтээ хийж эхлээд одоо удахгүй 2 жил болох гэж байхад манай улс одоо болтол Үндэсний хороогоо байгуулсан ч үйл ажиллагаагаа эхлүүлээгүй байгаад мэргэжлийн хүмүүс санаа зовниж байгаагаа илэрхийлж байна. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах асуудлыг дан ганц Замын цагдаагийн албаны үүрэг гэж нийтээрээ ойлгож байгаа нь уг чухал асуудлыг улс орны хэмжээнд шийдвэрлэхэд тодорхой бэрхшээл учруулж байгааг хэлэх нь зүйтэй. Энэ асуудал бүх төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүн иргэдийн үйл хэрэг мөн.

Гэтэл дэлхийн улс орнуудын засгийн газар замын хөдөлгөөний аюулгүй байдлын асуудлыг стратегийн төлөвлөлт, зохицуулалт, хөрөнгө хүч шаардсан үндэсний тэргүүн зэргийн асуудал болохыг хүлээн зөвшөөрч тодорхой арга хэмжээ авч эхлээд нилээдгүй хугацаа өнгөрлөө.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө зорилтыг хэрэгжүүлэхэд улс төрийн санал санаачлага гаргах нь чухал байна. Тухайлбал Франц улсын Ерөнхийлөгч асан Жак Ширак : “Миний засаг захиргааны хамгийн чухал тэргүүн зэргийн асуудлын нэг бол замын хөдөлгөөний аюулгүй байдлын асуудал” гээд, 2002 онд Францын зам дээр 7000 гаруй хүн нас барж байсан бол 2005 он гэхэд энэ үзүүлэлт 5000 - аас бага болж нас баралтын тоо даруй 20 гаруй хувиар буурчээ. Төрийн тэргүүн өөрөө хөдөлгөөний аюулгүй байдлын асуудлыг гол тэргүүн зэргийн асуудал гэж зарласан нь жолооч нарын сахилга хариуцлагад өөрчлөлт оруулах, олон нийтийг энэ асуудалд хандах хандлагыг өөрчлөхөд маш чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Ийнхүү зам тээврийн осол гэмтлийг бууруулж чадсанаар түүнтэй тэмцэхэд жилд зарцуулж байсан зардалаас 50 дахин илүү эдийн засгийн үр ашигтай ажил болжээ. Ерөнхийлөгч Ж.Ширакийн гаргасан санаачлага, түүний үр дүн нь бусад орнуудад үлгэр дууриалал болж Итали улс мөн ийм амжилтад хүрсэн байна. Мөн ОХУ хөдөлгөөний аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэх стратегийн хандлагыг өндөр түвшинд тавьж хэрэгжүүлж байна.

Дэлхийн банкнаас гаргасан зөвлөмжийн дагуу замын дэд бүтцийг сайжруулах төслийн зардлын 10-аас доошгүй хувь нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад зориулагдана гэсэн зарчмыг бүх хандивлагчид болон зээл олгогчид хэлбэрэлтгүй тууштай мөрдөх нь зүйтэй гэдгийг тогтсон байна. Коста Рика Улсын Зам тээврийн сайд Карла Гонзалес: “Дэлхийн эрүүл мэндийн шударга зарчим гэдэг нь баян ядуу аль ч орны хүмүүс

<sup>22</sup> [www.makeroadssafe.org](http://www.makeroadssafe.org) “Comission for Global Raod Safety”- Дэлхийн авто замын нийгэмлэгийн хөдөлгөөний аюулгүй байдлын илтгэл

вакцинжуулалтад хамрагдах явдал юм. Харин дэлхийн авто замын аюулгүй байдлын шударга зарчим гэдэг нь аль ч газрын хүмүүс өмнө нь болж байна гэж итгэж байсан шиг зүгээр нэг замаар зорчих биш харин бидний өнөөдрийн үзэж итгэж байгаачлан аюулгүй замаар зорчиход оршино” гэж хэлсэн нь энэ зарчмыг батлаж байх шиг. Энэ ажлыг үр ашигтай санхүүжүүлэхийн тулд 10 жилийн хугацаанд 300 сая.ам долларыг хандивлагч орнууд болон бусад эх сурвалжаас бүрдүүлэхийг санал болгож байна. “Дэлхий нийтийн замын аюулгүй байдлын Сан”-г байгуулж Дэлхийн банкаар удирдуулж байгаа ба энэ сангаас хөгжиж байгаа орнуудын замын хөдөлгөөний аюулгүй байдлын хөтөлбөрийг санхүүжүүлэх зээлийн хэлэлцээр хийж байгаа юм. Жишээ нь саяхан Вьетнам улс өөрийн орны хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах стратегийг санхүүжүүлэхэд олгох 30 сая.ам долларын хэлэлцээрт гарын үсэг зурсан байна. Бусад олон талын үйл ажиллагаатай байгууллагуудтай харьцуулахад Дэлхийн банк нь хөгжиж байгаа орнуудын улс төрчдөд нөлөөлөх талаараа мөн олон нийтийн болон хувиараа туслалцаа үзүүлэх доноруудын үйл ажиллагааг идэвхжүүлэхэд хамгийн их боломжтой байгууллага билээ.

Нэгэнт бий болсон хүнд нөхцөл байдалд шуурхай үнэлгээ дүгнэлт өгч дэлхийн улс орнуудын дээрх арга, туршлага, санал, санаачлага, НҮБ-ын зөвлөмжийг төр засгийн хэмжээнд анхааран үзэж энэ асуудлаар цаг хугацаа алдалгүй тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг улс орны болон иргэдийн нийгэм эдийн засгийн эрх ашиг байнга шаардаж байна.

Дэлхий дахинд зам тээврийн осол, гэмтлийн улмаас жилд 1,2 сая хүн амь насаа алдаж байна. Энэ байдал хэвээр үргэлжилбэл, зам тээврийн осол нь зүрхний шигдээс, сэтгэлийн дарамтын дараа хүн амын нас баралтын гурав дахь гол шалтгаан болох төлөвтэй байгаа юм. Иймд НҮБ Ерөнхий Ассемблейн 2010 оны 64/255 дугаар тогтоолоор 2011-2020 оныг “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын жилүүд” болгон зарлаж зам тээврийн ослын улмаас гарч буй нас баралтыг бууруулах зорилт дэвшүүлсэн. Манай улсад өнгөрсөн онд бүртгэгдсэн зам тээврийн ослын 99.36% нь хүний буруутай үйлдлээс болсон. Тэр дундаа 90 гаруй хувь нь жолоочийн буруугаас болсон гэсэн судалгааг Замын цагдаагийн газраас хийжээ.

Гэвч бид замын хөдөлгөөний аюулгүй байдлыг дан ганц хүний буруутай үйлдэлтэй холбон ойлгож болохгүй. Харин зам тээврийн ослын шалтгаан нөхцлийг олж тогтоон, түүнд дүгнэлт хийсний дараагаар тэрхүү шалтгаан нөхцлийг арилгах, бууруулах арга хэмжээ авах нь хамгийн үр дүнтэй. Иймээс судалгааны үр дүндээ үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэж буй тогтолцоог бүхэлд нь шинэчилж, жолооч бэлтгэх сургалтыг мэргэжлийн боловсрол, сургалтын түвшинд хүргэх
- Осол хэргийн хариуцлагыг зөвхөн жолоочид хүлээлгэх бус тухайн осолд юу нөлөөлснийг судалж дүгнэн гэм буруутай иргэн, албан байгууллагад хариуцлага хүлээлгэдэг байх
- Тээврийн хэрэгслийн оношлогоо хийдэг байгууллагыг хариуцлагажуулах
- Шинээр зам, замын байгууламж бүтээхдээ зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх хаалт, тэмдэг тэмдэглэгээг цогцоор байгуулах, замын арчлалт, засварыг тогтмол хийлгэж байх
- Хот төлөвлөлт, замын сүлжээ, түүний инженерийн зохион байгуулалтыг сайжруулах
- Авто замын салбарын эрх зүйн орчин орчинг боловсронгуй болгох, хүний нөөцийн чадавхийг сайжруулах, шинэ техник, технологи нэвтрүүлэх
- Тээврийн хэрэгслийн тоо эрс ихэссэнтэй холбогдуулан Нийтийн тээвэрт тулгуурласан хотын хөгжлийг дэмжих
- Замын хөдөлгөөнд ороцогчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлж дадал зуршил бий болгох зэрэг болно.



## ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ



### ГЭМТ ХЭРГИЙГ ИЛРҮҮЛЭХ, МӨРДӨН ШАЛГАХ<sup>23</sup> АЖИЛЛАГААГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХАД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЗОРИЛГО, ЗАРЧИМ

*Д.Мягмарцэрэн*  
*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүйн*  
*тэнхимийн эрхлэгч, доктор /Ph.D/, дэд профессор,*  
*цагдаагийн дэд хурандаа*

*М.Отгонбаяр*  
*Төмөр зам дахь Цагдаагийн хэлтсийн дарга,*  
*докторант, цагдаагийн хурандаа*

Монгол Улсад өрнөсөн ардчиллын үр дүнд эдийн засаг нийгмийн харилцаанд ихээхэн өөрчлөлт, шинэчлэлт гарсан билээ. Үүний зэрэгцээ аливаа нийгмийн сөрөг үзэгдэл болох гэмт хэрэг, түүний тоон үзүүлэлт, бүтцийн өөрчлөлтийг манай улс тойрч гарсангүй. Эдийн засгийн өсөлтийн хэрээр засаг төр, иргэдийн санхүүгийн байдал сайжирч, ардчиллаар хүртсэн өмчлөх эрхийн төлөөх тэмцэл өрнөсөн сүүлийн он жилүүдэд эрх мэдэл, албан тушаалаа хувийн ашиг сонирхолд ашиглах үзэгдэл ихээхэн нэмэгдэж, олон улсын түвшинд яригдаж эхэлснээр энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх тусгайлсан хөтөлбөр төлөвлөгөө гаргаж, олон улсын конвенцид нэгдэн орж, тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага байгуулж, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэсэн алхамууд хийгдэж байна.

Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчинг төгс бүрдээгүй, дорвитой үр дүнд хараахан хүрээгүй байгаа мэт харагдавч, нийгэмд авлигатай тэмцэх хүсэл зориг нэгэнтээ бий болсон байна. Үүний тод жишээ бол Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны олон нийтийн үнэлгээний түвшин 2010 оноос 2013 онд 7.8%-аас 44.7% хүртэл дээшилсэн байна.<sup>24</sup>

Монгол улсад бүртгэгдэж буй гэмт хэргийн бүтцэд багахан хувийг эзэлж байгаа авлига, албан тушаалын хэрэг нь нийгмийн хор аюулаар их тул олон нийтийн анхаарлын төвд ямагт байдаг. Иймээс энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх үйл ажиллагаа нь нарийн ур ухаан, олон талын мэдээлэл, мэдлэг шаарддаг болох нь олон улсын туршлагаас харагдаж

<sup>23</sup> Цагдаагийн албаны тухай хуулийн 9.1. "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах зорилгоор хууль сахиулах ажиллагаа явуулахыг гэмт хэрэгтэй тэмцэх гэнэ."

<sup>24</sup> Н.Ганболд. "Хуулийн засаглал гэдэг зүйл л авлигатай тэмцэхэд хамгийн чухал". Үндэсний тойм сэтгүүл тусгай дугаар. Хуудас 10



байгаа учир өөрийн орны нийгэм, улс төр, зан заншлын онцлогод нийцсэн арга тактик боловсруулах, түүнийг хэрэгжих хөрс болох эрх зүйн орчныг нь боловсронгуй болгох, илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагааг мэдээллээр хангах нь нэн чухал юм.

Гэмт хэргийн статистик мэдээллээр энэ төрлийн гэмт хэргийн тоо өссөн<sup>25</sup> байдал байгаа хэдий ч уг гэмт хэргийн өөрийн онцлог болох нууц далд аргаар зохион байгуулалттай үйлдэгддэг, их хэмжээний хохирол учруулдаг зэргээс үндэслэн илрүүлэх арга тактик нь эрүүгийн тагнуулын хүч, арга, хэрэгслийг ашиглах шаардлагыг бий болгодог. Иймд эрүүгийн тагнуулын хүч, арга, хэрэгслийг зөв зохистой үр дүнтэй ашиглаж, энэ төрлийн гэмт хэргийг бүрэн дүүрэн баримтжуулж илрүүлэх ажиллагаанд шаардлагатай мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээг үр дүнтэй ашиглах хэрэгтэй юм.

Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж буй этгээдүүд нь нийгмийн байр суурь, боловсролын түвшин өндөр, мэргэжлийн мэдлэг, чадвар, заль мэхтэй этгээдүүд байдаг.<sup>26</sup> Энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээллээр хангах үйл ажиллагаа нь бие даасан зохицуулалттай, зорилттой, чиглэлтэй байж эерэг үр дүнд хүрэх нь дамжиггүй.

**Гэмт хэрэг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагааг мэдээллээр хангах үйл ажиллагааны ерөнхий зорилго нь:** гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээллийг цуглуулах, боловсруулах, системчлэх арга замаар гэмт хэрэгтэй тэмцэхэд туслан дэмжихэд оршдог. Ерөнхий зорилгоос улбаалан тусгай зорилтуудыг тодорхойлж болно. Үүнд:

- Гэмт хэрэг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй болгоход тус болох мэдээллээр мөрдөн байцаагч, эрүүгийн төлөөлөгч нарыг хангах,
- Захиргааны зөрчлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх,
- Цуглуулсан болон гэмт хэргийн статистик өгөгдөхүүнд криминологи дүн шинжилгээ хийж боловсруулсан мэдээлэлд үндэслэн гэмт хэрэгтэй тэмцэх иж бүрэн арга хэмжээг төлөвлөх зэрэг болно.

Гэмт хэрэг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаанд ач холбогдол бүхий мэдээллийг цуглуулах, баяжуулах, боловсруулах, хадгалахад техник, технологийн хөгжил дэвшил ашиглах нь орчин үед тодорхой нөхцлийг шаардаж байна.

**Гэмт хэргийн тухай анхны мэдээлэл авагдахаас эхлэн шүүхэд шилжих хүртэл мөрдөн байцаалт, хэрэг бүртгэлт, тагнах үйл ажиллагааны үеүдэд мэдээллээр хангах үйл ажиллагаа нь тодорхой зарчмуудад нийцэн хэрэгжих ёстой байдаг. Үүнд:**

- Хууль ёсны зарчим. Энэхүү зарчим нь аливаа хэрх зүйт төр, ардчилсан улс гүрэнд эрүүгийн болон бусад эрх зүйн үндсэн тулгуур зарчим болдог. Гэмт хэрэг илрүүлэн, гэмт этгээдийг олж тогтоон түүний гэм бурууг нотлон тохирох хариуцлагыг хүлээлгэхэд, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалахад хууль ёсыг чанд сахих үндсэн дээр хууль сахиулах, шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэх ёстой.
- Мэдээллээр хангах ажиллагаа нь цаг үеэ олсон байх. Гэмт хэргийг илрүүлэх эрх бүхий субъектүүдэд гэмт хэрэг илрүүлэх, мөрдөн тухайн цаг хугацаанд шаардлагатай мэдээллийг хүргэх үйл явцаар илэрнэ.
- Гэмт хэргийг илрүүлэх, мөрдөхөд хамгийн их үр нөлөө ач холбогдол хүргэх мэдээллээр хангах явдал байна.
- Мэдээллээр хангах үйл явц тасралтгүй үргэлжлэх. Мөрдөн байцаагч, эрүүгийн төлөөлөгчийг цаг үеэ олсон, ач холбогдолтой мэдээллээр хангаж үр дүнд хүрэхэд мэдээллээр тасралтгүй хангах явц байна.

<sup>25</sup> 2009 онд хээл хахууль авах гэмт хэрэг 16, 2010 онд 19, 2011 онд 29, 2012 онд 26 болж өссөн. Хээл хахууль өгөх гэмт хэрэг 2009 онд 7, 2010 онд 12 болж өсчээ. Албан тушаалын гэмт хэрэг 2009 онд 99 байсан бол 2010 онд 101, 2011 онд 101, 2012 онд 110 болж өссөн дүн мэдээ байна. “Монгол улс дахь 2012 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал”. УБ., 2013

<sup>26</sup> Нийт гэмт хэрэгт холбогдогсдын 78.8% нь дээд боловсролтой, 70.5% нь төрийн албан хаагч, 50% нь бүлгээр үйлдсэн байна. “Монгол улс дахь 2012 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал”. УБ. 2013

Цаг хугацаа орон зайн хувьд авагдаж буй мэдээлэл нь өрнөж буй үйл явцын талаар бүрэн дүүрэн зураглалыг гаргахуйц хүрээний байх нь байнга мэдээлэл хүлээн авч буй цагдаагийн байгууллагын нэгжид маш их ач холбогдолтой байдаг.<sup>27</sup> Гэмт хэргийн талаар ил далд хэлбэрээр авагдаж буй мэдээллийн ач холбогдол нь түүний үнэн бодит байдалтай шууд хамааралтай байдаг ба агуулгын нэгдсэн дүгнэлт нь гэмт хэргийн үнэн мөн чанарыг шууд заадагт оршино.

- Мэдээллийн хамгаалагдсан байдал. Мэдээллийн тархалтын хэмжээгээр түүнийг нийтийн хэрэгцээний, хязгаарлагдсан хүрээний гэсэн хоёр үндсэн хэсэгт хувааж болно. Хязгаарлагдсан хүрээний мэдээллийг төрийн нууцын ба бусад нууцын гэж ангилж болно. Төрийн нууцын талаар Монгол Улсын төрийн нууцын тухай болон Төрийн нууцын жагсаалтын тухай хуулиар зохицуулагддаг бол бусад нууцын хүрээнд:

1. Иргэний хувийн нууцын талаар агуулсан мэдээлэл
2. Мөрдөн байцаалт болон шүүн таслах ажиллагааны нууцыг агуулсан мэдээлэл
3. Албаны нууц
4. Мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд хамаарах нууц /эмчийн, нотариатын, өмгөөлөгчийн шуудан харилцааны гэх мэт/
5. Аж ахуйн үйл ажиллагааны хүрээний нууц
6. Шинэ санаа, нээлт, зохион бүтээлтийн хүрээний нууц<sup>28</sup> гэж ангилсан байна.


Мэдээлэлд дүн шинжилгээ хийх үйл ажиллагааны талаар авч үзвэл: дүн шинжилгээний ажил гэж бүтээлч ажлын нэг хэсэг бөгөөд мэдээлэлд үнэлэлт өгөх шийдвэр гаргахад бэлтгэх үйл ажиллагааны үндсэн хэсэг юм. Бодит байдлыг танин мэдэх үйл явдал болохын хувьд дүн шинжилгээний ажил нь диалектикийн, ерөнхий логикийн болон бусад танин мэдэхүйн аргуудаар хэрэгждэг. Дүн шинжилгээний ажлын хэрэгсэл нь сэтгэн бодох үйл ажиллагааны хууль аргаар болон бусад техникийн багаж хэрэгслээр бодит өгөгдлийг чанартай боловсруулж, түүнээс боломжит бүх зүйлийг гарган авах явдал юм. Дүн шинжилгээний ажлын процесс нь судалгааны зорилго, зорилтод хүргэх тодорхой дэс дараалалтай, дүн шинжилгээний ажлын хэрэгсэл ашиглан хэрэгжүүлж буй сэтгэн бодох үйл явцын нийлбэр цогцыг хэлнэ.

Мэдээллийн эрин зуунд амьдарч байгаа бид мэдээллээс ихээхэн хамаарч байгаа билээ. АНУ-ын мэргэжилтнүүдийн тооцоолсноор зөвхөн компьютерийн аюулгүй байдлыг хангах системийг байхгүй болгоход дундаж компаниудын 20% хэдхэн цагийн дотор, дундажаас дээш болон том компаниуд 2-3 өдрийн дотор, банкуудын 33% нь 2-5 цагийн дотор, 50% нь 2-3 өдрийн дараа дампуурна гэсэн байна. Программ хангамжийг ашиглаж, мэдээллээр хангах үйл явцын хурдыг нэмэгдүүлснээр маш сайн үр дүнд хүрч байна. Тухайлбал, АНУ-ын Цагдаагийн байгууллага болон бусад эрх бүхий байгууллагуудад ашигладаг “COPLINK” программ нь мэдээллийн сангаас бие дааж мэдээллийн өгөгдөхүүнүүдийн хоорондын уялдаа холбоог тогтоож, хариулт мэдээлэл өгдөг алгоритмд тулгуурладаг байна. Энэхүү программыг Аризонагийн Их сургуулийн профессор Синьчунь Чэн нь КСС компанийн захиалгаар бүтээсэн бөгөөд 2011 онд IBM корпораци худалдан авч, сайжруулан ашиглаж байна.<sup>29</sup>

<sup>27</sup> Өргөдөл, гомдол мэдээлэл хүлээн авах холбооны улсын журмын 7 дугаар хэсэг. 2005 оны 01 сарын 10-ны өдрийн №985 дугаартай Дотоод явдлын сайдын тушаалаар баталсан журам. Холбооны улсын гүйцэтгэх засаглалын эрх зүйн актуудын эмхтгэл. №52 2005

<sup>28</sup> ОХУ-ын Ерөнхийлөгчийн 1997 оны 3 сарын 6 өдрийн зарлигаар баталсан жагсаалт. “Эрүүгийн цагдаа- эрх зүйн эмхтгэл”. Новая юстиция хэвлэлийн газар. 2006. М.238 хуудас

<sup>29</sup> <http://www-03.ibm.com/software/products/en/copl原因>



Уг программаар цээж зургаар сэжигтэй этгээдийг санд хайх, цаг хугацаа орон зайн өгөгдөхүүнээр давхардлыг хайх, хөдөлгөөнт камераар нөхцөл байдлын илэрцийг хайх, газар зүйн байрлалын илэрцээр хайх төрлүүдтэй байна.

Мэдээллийг олж авах, түүнд дүн шинжилгээ хийх, үр дүнг ашиглах үйл явц нь маш няхуур нямбай байдлыг шаардах бөгөөд тэдгээрийг зөв дэс дараалалтай хийж гүйцэтгэсэн тохиолдолд үр дүнгээ өгөх болно.

**Мэдээллийн эх сурвалж:** Аливаа асуудлыг шийдвэрлэхэд тодорхой хэмжээний мэдээлэл шаардлагатай байдаг. Мэдээллийн үнэ цэнэ нь түүнийг ашиглаж болох боломжоор тодорхойлогдох бөгөөд энэ нь мэдээллийн агуулга, үнэн бодит байдал, цаг үе олсон байдал зэргээс хамаардаг байна. Өгөгдөхүүн, үзэл бодол санаа, мэдээлэл (боловсруулагдсан өгөгдөхүүн) гурвыг ялгаж ойлгох хэрэгтэй. Мэдээлэлийг зөвөрлөгч зүйлээр: мэдэж байгаа хүмүүс, баримт бичиг, утасгүй холбооны хэрэгсэл (телефон утас, телефакс, радиостанц), мэдээлэл боловсруулах цахим хэрэгсэл (компьютер, цахилгаан бичгийн машин) гэж ангилж болно. Мэдэж байгаа хүмүүс гэдэгт: шаардлагатай мэдээллийг мэдэж байгаа, мэдэж болох хүмүүсийг хэлэх ба дараах байдлаар ангилж болно.

- Шинжээч гэж тухайн асуудалд мэргэжлийн түвшний мэдээлэл өгөх бололцоотой хүнийг хэлнэ.
- Дотоод мэдээлэгч гэж эсрэг талд байж материаллаг, ёс суртахууны болон бусад шалтгаанаар үнэ цэнэтэй мэдээ, мэдээлэл дамжуулж өгч буй хүн юм. Түүний мэдээллийн ач холбогдол нь тухайн талд мэдээлэгчийн эзэлж буй байр суурь бодит боломж болон бусад зүйлүүдээс ихээхэн хамаардаг.
- “Халуун” эсрэг талын бүлэглэлээс болон тэдгээртэй ойр холбоотой байдаг хүмүүсээс идэвхитэй арга хэрэгслээр (хатуу байцаалт, эрүү шүүлт, барьцаалах, гипноз ашиглах) мэдээлэл хэлсэн хүн.
- Нэвтрүүлсэн эх сурвалж: объектын хүрээлэлд ямар нэг аргаар оруулсан өөрийн хүнийг хэлнэ.
- “Чалчигч” мэдээлэгч: эсрэг талын болон тэдгээртэй хамтран ажилладаг, мэдээлэл агуулж буй хүн бөгөөд аливаа нэг яриа хөөрөлдөөний үед чухал мэдээллийг ам алдаж мэдээллэдэг хүнийг хэлнэ.
- Харилцагч: судлагдаж буй объектод ямар нэг байдлаар харилцаж байсан ба тэр харилцааны талаар тодорхой бодит факт мэдэх хүн.
- Нэг талын хамтрагч: аливаа нэг асуудлыг шийдэхээр нэгэн зүгт чиглэсэн санаа бүхий хүн байгууллага, бүлэглэлийг хэлнэ.

- Гэнэтийн эх сурвалж: чухал мэдээлэл агуулагч гэж хэзээ ч бодож тоцоолж байгаагүй этгээд нь маш чухал мэдээлэл агуулсан эх сурвалж болох тохиолдол юм.

Ийм байдлаар ангилан олон нийтийн хүртээл болгон сурах бичигт зааж өгсөн байна.<sup>30</sup> Энэ нь нэг талын ач холбогдолтой. Учир нь энгийн иргэд мэдээлэл ямар байдлаар тархан дэлгэрдэг, энэ тархалтыг хэрхэн олж авдаг талаар мэдээлэлтэй болж байгаа, нөгөө талаас нь үзвэл мэдсэн сэрэмжлүүлэгдсэн эсрэг тал маань хамгаалалтын горимд шилжсэн тохиолдолд үйл ажиллагааны ач холбогдол үр дүн буурах талтай байдаг. Энэ удаад гүйцэтгэх ажлын хүрээн дэх нэр томьёо тодорхойлолт ашиглаагүй ба энгийн аж амьдралд мэдээлэл хэрхэн оршиж байгаа түүнийг олж авах арга зам бодит бололцоо байгаа талаар авч үзсэн болно.

Олон нийтэд ил байгаа эх сурвалжуудад мэдээлэл олж авах арга хэрэгсэл тактикийн талаар зарим сурах бичигт мэдээллийн эх сурвалжийг дараах байдлаар ангилсан байна. Үүнд: Албан ёсны бичиг баримтууд, ажлын болон архивын баримт бичгүүд, хувийн архив болон бичиг баримт, “хаягдал хог”, нээлттэй болгосон баримт сэлт, хувийн захидал, хэвлэмэл баримт бичиг зэрэг болно. Мэдээлэл дамжуулах, хадгалах эх үүсвэрээс мэдээлэл авах хэсэгт утас, телетайп, телефакс, хувийн радио станц, компьютер, үүрэн болон бусад радио систем зэргийг хамааруулсан байна.

Мэдээлэл авах аргуудыг нууцаар сонсох, нууцаар ажиглах, дэл сул яриаг бүртгэх, үйл хөдлөл ажил байдлыг хянаж дүн шинжилгээ хийх, шуудангийн захиа илгээмж зэргийг үзэх зэргийг заажээ. Энэ байдлыг дүгнэвэл иргэд олон нийтэд хангалттай мэдээлэл ил далд аргаар олж авах бодит бололцоо байдаг, хэрэгжүүлж болохыг сурган зааж өгсөн байдал байна гэж дүгнэхээр байна.

Мэдээллийг туйлын найдвартай, энгийн найдвартай тийм ч найдвартай биш, найдваргүй, тодорхойгүй гэж ангилдаг. Мэдээлэл олж авсан байдлаар нь өөрөө харсан үзсэн, итгэж болох хүнээс сонссон, дэл сул яриа гэж ангилсан байна. Мэдээллийн бодит үнэн байдлыг илтгэх индекс ашиглан ангилсан: бусад фактаар баталгаажсан, магадгүй үнэн, бололцоотой үнэн, эргэлзээтэй, бодит биш, тодорхойлох боломжгүй. Мэдээллийг дээрх байдлаар ангилсан нь практикт хэрэглэгдэж байгаа ба мэдээллийн эх сурвалжийг тодруулах үүднээс дараах ангиллыг нэмж оруулах саналтай байна. Худал мэдээллээр төөрөгдүүлэх эх сурвалжид мэдээллийг өгсөн, мэдээллийг зориуд гажуудуулсан, мэдээллийн агуулга дамжуулах процесст гажсан гэсэн нэмэгдэл ангиллыг оруулсан тохиолдол мэдээлэлд хэт хөтлөгдөх асуудал багасах талтай. Дээрхи мэдээллийн эх сурвалжийн баталгаатай байдлыг шалгаж тогтоохын тулд мэдээллийн эх сурвалж нь мэдээллийн агуулгын логик болон цаг хугацааны дарааллын алдаа гаргахгүй байх, мэдээллийн агуулгын гол цөмийг бусад анхаарал татахуйц мэдээлэлтэй холихгүй байх, олон төрлийн мэдээлэл, санаа бодлыг нэг доор төвлөрүүлэхгүй байх, олон утга санаа агуулсан үг хэрэглэхгүй байх, мэдээллийн хагасыг мэдээлэхгүй байх, өөрийн үгээр хачир нэмэхгүй байх, өөрийн үзэл бодлын хэмжүүрээр мэдээллийг оруулахгүй байх, бодит факт санаа бодол хоёрыг ялгаж байх, мэдээлэл өгч буй эх сурвалж уг мэдээллийг олж авсан бахй бололцоотой эсэхэд анхаарах, олон шат дамжлага дамжуулахгүй байх зэрэг байдлуудыг анхаарч шалгаж баталгаажуулах шаардлагатай билээ.

Мэдээллийг эхний байдлаар олж авсан хэдий тэр нь ашиглах бодит бололцоогүй байдаг ба ашиглалт эргэлтэд оруулах явдал нь хамгийн чухал зүйл бөгөөд энэ нь мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийх явдал мөн. Нэг үгээр бол мэдээллийг боловсруулах явдал. Цугларсан мэдээллийн ач холбогдол анхны мэдээлэлд дурьдсан агуулгад байдаггүй ба түүнийг зөв тайлбарлан таних, бусад мэдээлэлтэй харьцуулах, нэгтгэх, логик холбоонд оруулах зэргээр боловсруулалт хийх явцад ач холбогдол нь өсөн дээшилж ирдэг.

<sup>30</sup> “Учебник по информационно-аналитической работе. Информация. Сбор.защита.анализ”. И.Н.Кузнецов. 2001.М.Яуза.33.

Тийм учир дээр өгүүлсний дагуу авлига, албан тушаалын гэмт хэргийн тухай мэдээллийн тархах үйл явц нь ердийн хэлбэрийг агуулдаг хэдий ч түүний мөн чанар болох нотолгооны ач холбогдол бүхий мэдээлэл нь ямагт далд байх ба илрүүлэх мөрдөн шалгах үйл ажиллагааг чиглүүлэх үүрэг давамгайлах хэлбэрийг агуулдаг. Нотлох ач холбогдолтой үйл явц нь эрх зүйн болон үйл ажиллагааны чанд төлөвлөлтийг шаарддаг. Авлига, албан тушаалын гэмт хэргийн оролцогч талууд ямагт сэтгэл хангалуун үлддэг онцлогтой учир мэдээлэл задрах магадлал багатай, мөн шууд нэр заасан ашиг орлого байдаггүй, үйлдлийн үргэлжлэх хугацаа их байдаг зэрэг хүндрэл байдгаас улбаалан илрүүлэх, мөрдөн шалгах эрх бүхий байгууллага албан тушаалтнаас ихээхэн ур чадвар сэтгэлгээ шаарддаг болно. Тийм учир авлига, албан тушаалын гэмт хэргийг илрүүлэх мөрдөн шалгах ажиллагааг зөв зохистой, эрх зүйн ач холбогдолтой, логик дэс дараатай мэдээллээр хангах нь эцсийн үр дүнд шууд нөлөөлдөг гэдгийг анхаарч энэ чиглэлийг баримтлан үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллах цаг үе ирсэн байна.

## ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ



### ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ ХЭРЭГЖСЭНЭЭР ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА ШИНЭЧЛЭГДЭХ БОЛОМЖ БҮРДЭНЭ

*Б.Оюутболд  
Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын дарга,  
цагдаагийн дэд хурандаа*

Монгол улс хүмүүнлэг энэрэнгүй, ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжээд 20 гаруй жил өнгөрчээ. Ардчилсан нийгэмд цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нь Монгол Улсын Үндсэн хуулинд заасан иргэдийн эрх, эрх чөлөөг хангаж, тэдний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг гэмт халдлагаас хамгаалах явдал юм.

Гэтэл цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт оновчгүй, шударга бус менежменттэй, шат шатандаа хариуцлага сул, үүрэг гүйцэтгэж ажиллах нөхцөл боломж тааруу, эрх зүйн болон нийгмийн баталгааны асуудал өнөөгийн шаардлагад нийцэхгүй байгааг өнгөрсөн хугацаанд бид шүүмжилсээр ирсэн. Мөн Цагдаагийн ажил үйлчилгээнд сэтгэл хангалуун бус, иргэний хяналтгүйгээр ажиллаж хүний эрхэд халддаг, зан харилцааны хувьд уналтад орсон гэх шүүмжлэлийг үгүйсгэх аргагүй юм.

Дээрх бүх асуудлын гол гогцоо нь цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт оновчтой бус, үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн боловсронгуй бусаас шалтгаалж байна.

Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хууль анх 1993 оны 12 дугаар сарын 02-ны өдөр батлагдсан бөгөөд үүнээс хойш 93 хуульд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хамаарах зохицуулалт тусгаснаас 60 гаруй хуульд цагдаагийн байгууллагад үүрэг болгосон хэм хэмжээ тогтоосон заалт байдаг.

Өнгөрсөн 20 жилийн хугацаанд дээрх хуульд нийт 13 удаа нэмэлт, өөрчлөлт орсон ч тэдгээрийн аль нь ч зарчмын шинжтэй томоохон өөрчлөлт байгаагүй буюу тухайн хууль

нь анх батлагдсан үеийн үзэл баримтлал, зарчим, зохицуулалтынхаа хүрээнд хүчин төгөлдөр үйлчилсээр байна.

Гэвч цагдаагийн алба хаагчид бусдаас хараат бус байх байдлыг хангах, үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн орчныг сайжруулах, тэдний хууль зүй, улс төр, нийгэм, эдийн засгийн баталгааг хангах зэрэг олон асуудал шийдвэрлэгдэхгүй үлдэж байсан нь өргөсөн тангарагтаа үнэнч байж, ажил үүргээ гүйцэтгэж яваа албан хаагчдын ахуй амьдрал, алдаа дутагдлаас бэлхнээ харагдаж байна. Мөн хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэж яваад гэмтсэн, амь насаа алдсан цагдаагийн албан хаагчдын ар гэрт өгдөг тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ туйлын хангалтгүй, тусгай хэрэгслийн хангамж тааруу, хангалтанд өгч буй хувцас, тусгай хэрэгсэл стандартын шаардлага хангахгүй байна.


Хуучин тогтолцооны үед байсан бүтэц, хангамж, эрх зүйн зохицуулалт хурдацтай хөгжиж буй өнөөгийн нийгмийн шаардлагад тохирохгүй байгаагийн хор хөнөөл үүгээр илэрч байна.

Цагдаагийн байгууллага нь цагдаагийн албан хаагчдаасаа “Цагдаагийн албан хаагчийн сэтгэл ханамж, байгууллагын үйл ажиллагаа” сэдэвт санал асуулгыг жилд 1 удаа, иргэдээс оршин суугаа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны өнөөгийн байдал, ажил үйлчилгээний чанар, түвшин тодорхойлох зорилго бүхий “Хэрэглэгчийн үнэлгээний асуулга”-г тус тус авч нэгтгэн, үр дүнгийн дагуу холбогдох ажил арга хэмжээг зохион байгуулан ажилладаг.

**Дээрх судалгаануудын зарим дүнг сүүлийн 3 жилээр товч танилцуулбал:** “Хэрэглэгчийн үнэлгээний асуулга”-д оролцсон иргэд “Цагдаагийн байгууллагын ажил, үйлчилгээний чанар, хүртээмж, түргэн шуурхай байдал, алба хаагчдын ажлын бүтээмж”-ийг дараах хүчин зүйлүүдтэй шууд холбон тайлбарласан байна. Үүнд:



“Цагдаагийн албан хаагчийн сэтгэл ханамж, байгууллагын үйл ажиллагаа” сэдэвт санал асуулгад оролцсон албан хаагчдын ажлаасаа гарах, ажлаа солих, ажилдаа сэтгэл ханамжгүй байх, зөрчил дутагдал гаргах зэрэг шалтгааныг дараах хүчин зүйлстэй холбон тайлбарласан байна. Үүнд:



Энэ судалгааны дүнгээс үзэхэд иргэд болон албан хаагчдын цагдаагийн байгууллагатай холбоотой гарган тавьж байгаа асуудал адилхан байгаа ба цагдаагийн байгууллага шинэчлэгдэж өөрчлөгдөх зайлшгүй шаардлагатай буйг тод харуулж байна.

**Мөн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны тухай бичсэн зарим нэг нийтлэлээс иш татвал:**

**“Цагдаагийн байгууллага дотроосоо ялзарчээ” нийтлэлд:** ...“Сүржин нэртэй даржин амьдралтай цагдаа нарыг өмөөрч хэлэх хэдэн зүйл байна. Нэг л сайхан дүрэмт хувцастай, сүрдмээр залуус сэтгэлдээ ямар их шаналал, дарамттай явдгыг бид төдийлөн мэддэггүй. Төрийн цагдаа төмөр биетэй биш шүү дээ. Ингэж хэлсний учир нь цагдаа тэр тусмаа хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, эрүүгийн төлөөлөгч нар даргын ёс бус харилцаанд дарамтлагдаж, цаг наргүй ажилладаг хэрнээ хоногийн хоолноос хэтрэхгүй цалин авдаг гээд бод доо. Бидний аав, ах дүү, садан төрөл, найз нөхдийн маань хэн нэг нь цагдаагийн байгууллагад ажиллаж л байгаа.”<sup>31</sup>

**“Үзэл бодлоо илэрхийлэх эрхгүй цагдаа” нийтлэлд:** “Хүний эрхийг ноцтой зөрчдөг газар бол цагдаагийн байгууллага. Цагдаа гэм бурууг олж, үнэн зөвийг тогтоодог байтал өөрсдөө хүний эрхийг дээдэлдэггүй байж бусдад хэрхэн энэ талаар ярих билээ. Дарга яв гээгүй бол шөнө ч хамаагүй ажиллана. Нөгөө дарга ажлаа орхиод хаана юу хийж яваа нь үл мэдэгдэх ч “Эдний цагийг бүртгээрэй” гээд “өөрийн хүндээ” үүрэг өгөөд алга болдог. Цагдаа нарын ажил гэлтгүй ар гэрт нь ч асуудалтай. Шөнө нөхрөө хүлээж ядсан цагдаагийн гэргий уурлах, хардахаас эхлээд салах дээрээ тулна. Мөрдөн байцаагч нарын дундаж цалин 300 мянга, хоёр хувааж авдаг энэ мөнгөөрөө олигтой хувцас ч аваад өмсч чадахгүй. Ажлаасаа гаръя гэсэн ч эхнэр хүүхэд нь нүдэнд нь харагдаад, эзэмшсэн мэргэжил нь энэ тул яаж ийж байгаад цагдаагийн байгууллагаас тэтгэвэрт гарахыг л бодно.”<sup>32</sup>

**“Үйлдвэрчний эвлэлгүй цагдаа” нийтлэлд:** “Ажлын хангамж, хүртээмжийн талаар яриад ч хэрэггүй. Тухайлбал, 15 мөрдөн байцаагч дундаа нэг машинтай. Өдөрт 15 литр шатахууны нормтой. Гэтэл яаралтай хэрэг гарлаа гэхэд унах машин хангалтгүй гар утсандаа нэгжгүй цагдаа нар яах вэ. Хэргийн гэрч, холбогдох хүмүүстэй харилцахад хамгийн багадаа сард утасны төлбөр 55-60 мянган төгрөгийг өөрийнхөө халааснаас гаргана. Цагдаа нарыг боловсрол нимгэн, харилцааны соёлгүй гэх хүн захиасаа аваад таарах ч тэдний ажлын ачаалал, нөхцөл байдал руу нь өнгийсөн нь ховор. Тэдний эрхийг хамгаалах газар Монголд байна уу. Тэдэнд үйлдвэрчний эвлэл гэж бий юу. Энэ талаар Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Ерөнхийлөгч С.Ганбаатараас хариулт авсан байна.

- Цагдаагийн байгууллагад үйлдвэрчний эвлэл байж болох уу. Болохгүй гэсэн хуулийн заалт бий юу?

-Цагдаагийн байгууллага хуулиараа үйлдвэрчний эвлэл байгуулах ёстой. Герман, Солонгос зэрэг олон орны цагдаагийн байгууллагад үйлдвэрчний эвлэл байдаг. Дарангуйллын систем байдаггүй ардчилсан орон бүрийн хүчний байгууллагад үйлдвэрчний эвлэл байх хэрэгтэй. Арми ч үйлдвэрчний эвлэлтэй байх ёстой. Гэхдээ цагдаагийн байгууллагынхан ажил хаялт хийж болохгүй. Үүнийг хамтын гэрээнд тусгаж өгдөг. Үндсэн хуулиар олгосон эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний дагуу жагсах, хэлэлцээр хийх эрхтэй. Цагдаа чинь хүн шүү дээ. Тэд бидэнтэй адил хөдөлмөрийн харилцаанд орж байна. Ажил үүргээ гүйцэтгэхдээ хэрэглэдэг бороохой, машин, хувцас, цалин хөлс нь ямар байгаа талаар хэлэлцээр хийх хэрэгтэй.”<sup>33</sup>

**“Сумын цагдаа” нийтлэлд:** “Малын хулгай гарсан гэнэ, машинаа өгөөч” гэж захиргаа хавиар гүйх сумын цагдааг өрөвдөх шиг ч инээд хүрэх шиг ч. Түүнийг хараад төрийн ажил хийж байж ганц унаатай болоход яадаг байна гэх үе ч байлаа. Ууланд гарсан

<sup>31</sup> News.mn “Цагдаагийн байгууллага дотроосоо ялзарчээ” нийтлэл

<sup>32</sup> Olloo.mn “Үзэл бодлоо илэрхийлэх эрхгүй цагдаа” нийтлэл

<sup>33</sup> Монголын Үйлдвэрчний эвлэлийн ерөнхийлөгч С.Ганбаатартай хийсэн ярилцлагын хэсгээс



малын хулгайн араас улсаас тавьж өгсөн хувцаснаас өөр юмгүй энэ муу цагдаа яваад юу олж долоох вэ дээ ч гэж бодох үе надад байсан. Толгодын дунд өндөлзөх сумын төвийн минь хэдэн цагаан байшин одоо ч нүдэнд тодхон харагдсаар л. Тэр байшингуудын нэгэнд нь манай сумын цагдаагийн хэсэг байрладаг. Тэрхүү хэсэгт хэрэг зөрчил, гэмт хэргийг таслан зогсоохоор үүрэг хүлээсэн 20 гаруйхан насны цагдаа хавтаст хэргээ бүртгэж суугаа. Төрийнхөө сүлдийг магнай дээрээ залсан энэ л залуу бидний хойч ирээдүй, амар амгаланг хамгаална.<sup>34</sup>

“Монгол Улс ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжээд хорь гаруй жил болсон атлаа цэрэг, цагдаа, шүүх гээд аюулгүй байдлыг сахин хамгаалах байгууллагуудынхаа тогтолцоог өнөөгийн нийгэмд нийцүүлэн шинэчлэх талаар далайцтай өөрчлөлт хийж амжаагүй. Холбогдох хуулиудыг ганц нэгээр нь өөрчилж, зарим талаар эрхзүйн орчин нь шинэчлэгдэж ирсэн боловч бодит амьдрал дээр бүтэц, тогтолцооныхоо хувьд өмнөх нийгмийн хэв шинжийг хадгалсаар байгааг юу гэж үзэх вэ?. Үүрэг даалгавар өгсөн бол төр цагдаагаа хамгаалалтдаа байлгадаг эрх зүйн тогтолцоо байх ёстой. Цагдаа нарын цалин бага байгаа. Ажил үүргээ гүйцэтгэж яваад бэртэж гэмтэж, амь насаараа хохирч байна. Энэ тохиолдолд олгодог нөхөн олговор, тэтгэмжийн хэмжээ бусад орнуудынхтай харьцуулахад дэндүү гэмээр бага. Нөгөө талаас ажил үүргээ гүйцэтгэхдээ хэрэглэдэг тусгай хэрэгсэл тааруу. Өөрийнх нь амь нас баталгаагүй байдалд байгаа. Тэгэхээр хангамж, хэрэгслийг нь хүртэл хуульчилж, эрхийг нь хангаж өгөөд шаардлагаа ч хатуу тавих хэрэгтэй. Энэ хууль хэрэгжиж эхэлснээр нийгэм цагдаатайгаа илүү нийцтэй хамтарч ажиллана, амар тайван байдал илүү хангагдана гэж ойлгож байна.”<sup>35</sup> гэжээ.

Тиймээ энэ бүгд бодит үнэн. Өнөөдөр Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн 80 гаруй хувийг хэрэгжүүлэн, өргөсөн тангарагтаа үнэнч байж, өмссөн хувцсандаа захирагдан өдөр, шөнөгүй ажиллан, хувийн амьдралаа умартан яваа цагдаагийн албан хаагчид бид цалин бага, цаг наргүй ажилтай гэж хэн нэгэнд гомдоллож, жагсаал, цуглаан хийлгүй, 92 жилийн турш гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ нэр төртэй биелүүлж яваа нь Монгол улсын бас нэгэн бахархал юм.

**2012 онд Монгол улсад Шинэчлэлийн Засгийн газар байгуулагдснаар хүчин төгөлдөр үйлчилж, даган мөрдөж байгаа Цагдаагийн байгууллагын тухай хууль нь хэт ерөнхий, цагдаагийн байгууллагын бүтэц, тогтолцоо, чиг үүргийг бүрэн тодорхойлоогүй, хөгжлөө даган өөрчлөгдөж буй нийгмийн харилцааг зохицуулж чадахгүй байгааг олж харж, өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангасан Цагдаагийн албаны тухай хуулийг шинэчлэн найруулж, 2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хурлаас баталж, 2014 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр болоод байгаа нь бидний хувьд томоохон өөрчлөлт, шинэчлэлт хийгдэх эрх зүйн боломж бүрдсэн гэж үзэж болохоор байна.**

**УИХ, Засгийн газрын гишүүн, Хууль зүйн сайд Х.Тэмүүжин** Хууль зүйн Үндэсний хүрээлэнгийн “Хуульчдын танхим”-д сэтгүүлчидтэй уулзаж, цагдаагийн байгууллагад хийгдэж байгаа шинэчлэлийн талаар хийсэн мэдээлэлдээ *“Цагдаагийн байгууллагын шинэчлэлийг таван жилийн хугацаанд хийнэ. Энэ шинэчлэлийг хийхэд саад бэрхшээл учрах нь дамжиггүй. Гэхдээ хуулиа өөрчилснөөр хуулийн дагуу боловсон хүчнээ бэлдэж, сургалтын программдаа өөрчлөлт оруулснаар иргэнээ дээдэлдэг, хамгаалдаг, үйлчилдэг цагдаагийн байгууллага болон шинэчлэгдэнэ”* гэж мэдэгдсэн.<sup>36</sup>

**Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, цагдаагийн хурандаа Ж.Ганбаатар** “Цагдаагийн байгууллага удирдлагын нүсэр, босоо тогтолцооноос татгалзана” ярилцлагадаа: *“Цагдаагийн байгууллагыг иргэнтэйгээ ойрхон, иргэний хяналттай*

<sup>34</sup> Shuurhai.mn Oct 1, 2013 “Сумын цагдаа” нийтлэл

<sup>35</sup> Shuurhai.mn Oct 1, 2013 “Сумын цагдаа” нийтлэл

<sup>36</sup> Report.mn

*болгохыг зорьж байгаа. Энэ шинэчлэлийн зорилгоо хэрэгжүүлж эхлэхдээ иргэдээ сонсоё, шүүмжлүүлэе, зөвлөгөөг нь авъя гэж шийдсэн. Ажлын чадавхийг сайжруулахын тулд ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, боловсон хүчин, хүний нөөцийн асуудлыг тодорхой болгох ёстой нь харагдаж байна. Цагдаагийн ажил гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, иргэдийн амгалан тайван байдлыг хангахад л чиглэгддэг. Тиймээс удирдлагын хүнд нүсэр, босоо тогтолцооноос татгалзах ёстой<sup>37</sup> гэж хэлсэн байна.*

Цагдаагийн байгууллагын шинэчлэлийг хууль эрх зүй, эдийн засаг, олон нийтийн ухамсар зэрэг олон хүрээнд шат дараатай, цогцолбор байдлаар хэрэгжүүлэхэд хугацаа нэлээд шаардагдсан үйл ажиллагаа бөгөөд үүнд алба хаагч хүн бүрийн хүчин чармайлт, оролцоо хэрэгтэй гэдгийг дурдмаар байна.

Шинэчлэн найруулсан Цагдаагийн албаны тухай хуулинд дараах асуудлуудыг хуульчилж өгсөн нь цагдаагийн албан хаагч үүргээ гүйцэтгэх нийгэм, эдийн засгийн таатай орчин бүрдэхийн зэрэгцээ, үүрэг, хариуцлагыг өндөржүүлж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих иргэдийн оролцоо нэмэгдсэн. Тухайлбал,

- Цагдаагийн байгууллагын удирдлага, түүний эрх хэмжээний асуудлын талаар;
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд тавих иргэний болон бусад хяналт, дэмжлэгийн талаар;
- Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааны журмын талаар;
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны шуурхай, аюулгүй байдлыг хангах журмын талаар;
- Цагдаагийн байгууллагын санхүүжилтийн талаар;
- Цагдаагийн алба хаагч, ажилтны эрхзүйн байдлын талаар зэрэг шинэлэг, нийгмийн хэрэгцээ шаардлага хангасан олон заалтууд тусгагдсан.

***Цагдаагийн албаны тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээр дараах эерэг үр дүн бий болно. Үүнд:***

1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцүүлэн цагдаагийн албаны эрхзүй, удирдлага, зохион байгуулалтын шинэчлэл хийгдэнэ.
2. Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, захиргааны үүрэг гүйцэтгэх ажлыг хуулиар тогтоож, тодорхой болно.
3. Цагдаагийн байгууллагын эрх зүйн орчин сайжирч, аливаа саад, бэрхшээл, хүнд суртал буурна.
4. Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, захиргааны үүрэг гүйцэтгэх ажлын үр нөлөө дээшилж, ажлын давхардал арилна.
5. Нутаг дэвсгэрийн болон хотын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих эрх зүйн орчин бүрдэж, байгууллагын ил тод, нээлттэй байдлыг бий болгох нөхцөл бүрдэнэ.
6. Цагдаагийн албан хаагч, ажилтны ажиллах орчин нөхцөл, баталгаа сайжирч, үйл ажиллагааны үр дүн дээшилнэ.

Цагдаагийн алба хаагчид нь ажиллаж, амьдрах орон байр, ахуй нөхцлийн тааруу байдал зэргээс шалтгаалан хөдөө орон нутагт томилогдон ажиллах сонирхолгүй, аль болох нийслэлд суурьшин ажиллах хүсэлтэй байдаг. Гэвч Хууль сахиулахын их сургуулийг шинээр төгсөгчдийн 80 гаруй хувь нь хэсгийн төлөөлөгчийн сул орон тоон дээр томилогддог. Цагдаагийн албаны тухай хууль батлагдснаар сумдад ажиллаж байгаа албан хаагчдын нийгмийн асуудал шийдэгдэж, тэдний ажиллах урам зориг нэмэгдэн, ажлын бүтээмж эрс сайжрах хандлагатай.

Цагдаагийн албаны тухай хуулийг сайтар судалж ойлгохын зэрэгцээ эерэгээр хүлээн авч, төрийн хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах нь албан хаагч бүрийн үүрэг

<sup>37</sup> Ж.Ганбаатар. Цагдаагийн байгууллага удирдлагын нүсэр, босоо тогтолцооноос татгалзана гэсэн ярилцлагын хэсгээс

юм. Иргэдийн ухамсар сэтгэхүйд цагдаагийн байгууллага нь “цагдагч” биш “сэргийлэгч” бөгөөд амар тайван амьдралыг хүсэмжлэгч гэдгийг суулгаж, энэ нь амьдралд хэрэгжиж чадвал энэ бол цагдаагийн байгууллагын шинэчлэл.

**Цагдаагийн байгууллага нь цаашид:**

- Цагдаагийн байгууллагын удирдлага бол зөвлөгч байж эрх үүргийн тэнцвэрийн цэг байна.
- Цагдаагийн байгууллага нь ажил үүргийн давхцалгүй, зөв чадварлаг бүтэцтэй, хуулиар чиг үүрэг нь тогтоогдсон байна.
- Алба хаагчдын нийгэм, эрх зүй, эдийн засгийн баталгаат орчин сайжирч, ажил үүргийн хуваарь оновчтой болж, ажлын ачаалал багасна.
- Цагдаагийн байгууллагын иргэдэд үзүүлэх үйлчилгээний түргэн шуурхай байдал, хүртээмж, чанар сайжирна.
- Цагдаагийн албан хаагчийн ажлын байрны стандартыг бүс нутгийн онцлогт тааруулан тогтооно.
- Цагдаагийн алба хаагчийн нийгмийн асуудлыг шийдэх орон нутгийн онцлогийг харгалзсан бодлого хэрэгжинэ.
- Зөв цагдаагийн алба хаагч болгож төлөвшүүлэх сургалтын арга зүй боловсруулж сургана.
- Мэдээлэл технологийн дэвшлийг нэвтрүүлэх, турших, сурталчилах зөвлөл ажиллана.
- Олон нийттэй нээлттэй байх цахим хэрэгслийг цагдаагийн байгууллагын бүх түвшинд нэвтрүүлнэ. /Facebook, twitter гэх мэт/
- Цагдаагийн албаны хууль болон цагдаагийн байгууллагын чиг үүргийг олон нийтэд сурталчилан таниулах орон нутгийн телевизийн тогтмол нэвтрүүлэгтэй байхаас гадна олон нийтэд тараах улирал тутам гаргадаг сонинтой болно.

***Цагдаагийн албаны тухай хууль батлагдан хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотой дараах ажлуудыг нэн түрүүнд хийх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:***

1. Цагдаагийн албан хаагчдад Цагдаагийн албаны тухай хууль болон түүнд нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль, журмуудыг үе шаттайгаар танилцуулан, судлуулах,
2. Энэхүү хуулийн үзэл баримтлалд нийцүүлж ажил, үйлчилгээгээ явуулах, иргэншсэн цагдаагийн байгууллагын албан хаагч болгон төлөвшүүлэх талаар сургалтыг явуулахын зэрэгцээ хууль сурталчлахад тодорхой хэмжээний санхүүгийн дэмжлэг үзүүлэх,
3. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд бусад төрийн болон төрийн бус байгууллага хэвлэл мэдээллийн байгууллагын хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах талаар судалгаа, шинжилгээний багийг ажиллуулж, гаргасан санал, санаачилгыг хэвшил болгон ашиглах
4. Олон нийтийн цагдаагийн ажилтны үүрэг, оролцоог нэмэгдүүлэх талаар мэргэжлийн удирдлагаар хангах, байнгын мэргэшүүлэх сургалтыг явуулах зэрэг болно.



## **ОЛОН НИЙТИЙН ЦАГДААГИЙН АЖИЛТАН, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ**

*Б.Баянмөнх*

*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн  
тэнхимийн ахлах багш, докторант, цагдаагийн ахмад*

Хууль зүйн салбарын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ зөв оновчтой хэлбэрийг сонгон авч, эрх зүйн орчныг богино хугацаанд бүрдүүлж өгөх нь Монгол Улсад шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх, төрийн үйл ажиллагаа хуулийн хүрээнд явуулах чухал ач холбогдолтой.

Ардчилсан хувьсгал ялж, нийгмийн тогтолцоо өөрчлөгдсөн 1990 оноос хойш хууль зүйн салбарын шинэчлэл цаг үетэйгээ уялдан байнга идэвхитэйгээр хийгдсээр ирсэн боловч цогц байдлаар хийгдэлгүй өдийг хүрсэн.

Тэгвэл энэ өөрчлөлт өнөөдөр цогц байдлаар хийгдэх зайлшгүй шаардлага бий болсныг Монгол Улсын Ерөнхийлөгч олж харан, эрх зүйн шинэтгэлийн бодлого хэрэгжүүлэх санаачлагыг гаргаж, үүнийг Улсын Их Хурал дэмжиж, улмаар эрх зүйн шинэтгэлийн бодлого хэрэгжиж эхэлсэн.

Тэр дундаа Хууль зүйн салбарын шинэчлэл нь цогц байдлаар явагдаж эрх зүйн шинэтгэлийн бодлого хууль сахиулах салбарын үйл ажиллагаанд бүрэн утгаараа хэрэгжинэ. Гэхдээ хууль сахиулах салбарын эрх зүйн орчинг бүхлээр нь шинэчлэхээс эхлэн институтын хувьд өөрчлөх, бүтэц зохион байгуулалт, санхүү, дэд бүтцийг иж бүрнээр нь шинэчлэж байж шинэчлэлийн бодлого бүрэн утгаараа хэрэгжих болно.

Хууль сахиулах салбарын үйл ажиллагааны шинэчлэлийн их хүлээлт иргэдийн дунд их байгаа, тэр дундаа салбарын албан хаагчдын дунд хамгийн их байсан бөгөөд энэ шинэчлэлийг Хууль зүйн яам маш их эрчимтэйгээр явуулж байгаа нь цаг үеэ олсон чухал алхам болж байна. Гагцхүү салбарын шинэчлэлийн бодлогоо хугацаа алдахгүй хэрэгжүүлэх ажлыг хурдан хугацаанд хийх хэрэгтэй гэдгийг нэгж дээр ажиллаж байгаа бид ойлгож мэдэрч, тэрхүү ажлыг дэмжин хурдан хугацаанд өөрчлөлтийг өөрөөсөө хийх ёстой гэдгийг сайтар ухамсарлах нь чухал юм.

Ер нь Хууль зүйн яамны явуулж буй шинэтгэлийн бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг яаралтай бүрдүүлэх, гарсан бодлого, шийдвэрийг хууль сахиулах салбарын харъяа агентлагууд шат шатандаа хэрэгжүүлж, өөрчлөлтийг хийгээд явбал богино хугацаанд хууль зүйн салбар шинэчлэгдэх боломжтой юм.

Манай улсад community oriented policing буюу олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааг хөгжүүлэх талаар хэд хэдэн удаагийн төсөл хэрэгжиж тодорхой үр дүнгээ үзүүлсэн.

1990-ээд оны үед урамшилтай, цалинтай, гэрээт эргүүл гэж ажиллуулан тодорхой үр дүнд хүрч байсан туршлага бий. Мөн Засгийн газраас олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны хөтөлбөрийг 2011 онд баталж хэрэгжүүлж байна. Энэ нь товчхондоо бол,

хүний аюулгүй байдлыг хангахын тулд иргэдийн идэвх санаачилгыг дэмжиж ажиллахад чиглэсэн арга байсан юм.

Анх 1940-өөд оноос төрийн үйл хэрэгт цагдан сэргийлэх байгууллагын үйл ажиллагаанд иргэд өргөнөөр оролцох эхлэл тавигдаж, 1942 онд МАХН-ын Төв хорооны тэргүүлэгчид, Ардын Сайд нарын Зөвлөлийн хамтарсан 41, 43-р хурлаар цагдан сэргийлэх хөдөлмөрчдийн холбоог бэхжүүлж, хөдөлмөрчдөөс төрийн хэрэгт оролцох, сайн дурын бригад байгуулсан.

Сайн дурын бригадууд нь гол төлөв хот суурин газруудад байгуулагдан ажиллаж байсан бөгөөд 1960-аад оныг хүртэлх хугацаанд туршлага дутагдалтайгаас үйл ажиллагаа нь тогтмолжиж чадаагүй, зөвхөн баяр ёслолын үед хэв журам сахиулах, энгийн харуул, манаа болон ариун цэврийн үзлэг шалгалтад үе үе оролцох, хууль дүрэм зөрчсөн, зохисгүй үзэгдлийн талаар цагдан сэргийлэх байгууллагад мэдэгдэх зэргээр ажиллаж байсан.

1941 оны 8-р сарын 15-ны өдөр Намын төв хороо, Сайд нарын Зөвлөлийн 43\41-р тогтоолоор “Цагдан сэргийлэхийн ажилд туслах сайн дурын бригад”-ыг байгуулахаар шийдвэрлэн, дүрмийг нь баталжээ. Үүний дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг өргөнөөр татан оролцуулсанаар 1949 онд Цагдан сэргийлэх байгууллагад туслах бригад 95, гишүүд 1280 байсан бол 1951 онд бригад 107, гишүүд 1421 болж олширчээ. Төр, засгаас дэс дараатай олон арга хэмжээ авсны үр дүнд Цагдаагийн байгууллага жилээс жилд бэхжин, 1947 онд улсын хэмжээнд гарсан гэмт хэргийн дөнгөж 50 хувийг илрүүлж байсан бол 1951 онд 74 хувь, 1954 онд 83 хувь, 1958 онд 92 хувийг нь илрүүлдэг болжээ. Энэ бол улс орны хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх ажил жилээс жилд эрчимжиж байсны илрэл юм.

Цагдан сэргийлэх байгууллагад туслах сайн дурын бригад нь байгуулагдсан үеэсээ эхлэн ерөнхий зорилго, чиглэл нэгтэй байсан боловч 1960 он хүртэл Сэргийлэхэд туслах сайн дурын бригад залуучуудын тавт, аравт зэрэг янз бүрийн нэртэй, бүтэц бүрэлдэхүүн нь харилцан адилгүй байжээ.

Эдгээр сайн дурын байгууллагуудын ажиллах бололцоо нөхцлийг хангахын тулд 1962 онд БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигаар Цагдан сэргийлэх байгууллагад туслах олон нийтийн бригадын гишүүдийн амь бие, эрүүл мэнд, эрх чөлөө, нэр алдрыг ардын Цагдан сэргийлэх байгууллагын ажилтан нарын нэгэн адил үзэж, хуулиар хамгаалсан нь энэ ажилд ихээхэн ахиц дэвшил гарах нэг үндэс болсон байна.

1974 оны байдлаар манай улсын хэмжээгээр Цагдан сэргийлэх байгууллагад туслах олон нийтийн байгууллагад 838, штаб 65, бригадын гишүүд 16000 гаруй болж байсан байна.

Энэ үеийн онцлог нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил зөвхөн цагдаагийн үүргийн хүрээнд явагдаж байсан байна. Үүнийг засах зорилгоор 1960 онд Намын Төв Хорооны 170 дугаар тогтоол гаргаж, хөдөлмөрчдийн дунд хууль сурталчлах олон хэлбэрийн ажил зохиох, гэмт хэрэг зөрчил гаргаж болзошгүй хүмүүстэй нэг бүрчлэн уулзаж, хүмүүжлийн ажил хийх, эргүүл шалгалтыг хүчтэй болгож, гэмт хэрэг гарч болох байдлуудыг урьдчилан илрүүлж, арилгах ажлыг нам, улс, олон нийтийн байгууллага, хөдөлмөрчдийн олон түмний тусалцаатайгаар зохион байгуулж эхэлсэн байна. Энэ нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын эрчим нээгдэж, иргэн хүний үүрэг, оролцоог, өндөрт тавьж байсан тухайн үеийн бодлогын илэрхийлэл байв<sup>38</sup>.

Монгол Улсад цагдаа-иргэдийн харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд хийгдсэн хамгийн том, далайцтай ажил нь 1999-2005 оны хооронд хэрэгжүүлсэн “Цагдаа-Олон нийтийн хамтын ажиллагаа хөтөлбөр” юм. Энэхүү төсөл хөтөлбөр нь Монголын нээлттэй нийгэм хүрээлэн, Унгар дахь Үндсэн хуулийн эрх зүйн институт, Эрх зүйн

---

<sup>38</sup> Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн түүхэн замнал, УБ. 2005. 14-15 дахь тал

санаачлага нээлттэй нийгмийн оролцоо, дэмжлэгтэйгээр хэрэгжсэн маш том төсөл байсан юм.

Дээрхи төслийн хүрээнд 2002 онд “Цагдаагийн хариуцлагын тогтолцоо ба цагдаагийн байгууллагын тухай хууль” сэдэвт олон улсын бага хурал зохион байгуулагдаж, үүний үр дүнд 2003 онд “Цагдаагийн байгууллагын тухай хууль”<sup>39</sup>-ийн 10-р зүйлийн 6-д “Цагдаагийн байгууллага нь ГХУС ажлыг төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн туслалцаа, тэдний хамтын ажиллагаанд түшиглэн зохион байгуулна” гэсэн заалт шинээр тусгагдсан нь цагдаагийн байгууллагаас иргэд, олон нийтийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, хамтран ажиллах хууль, эрх зүйн үндсийг тавьж өгсөн байна.

“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” хуулиар цагдаа-олон нийтийн хамтын ажиллагааны зарим эрх зүйн үндсийг тодорхойлж байдаг бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь **олон нийтийн хүчинд түшиглэх**,...аж ахуйн нэгж, байгууллага дотооддоо болон үйл ажиллагааныхаа хүрээнд гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг арилгах ажлыг хариуцан зохион байгуулах зарчимд тулгуурлана. Түүнчлэн уг хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дах хэсэгт “ ... эрдэм шинжилгээний байгууллага нь гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах шинжилгээ судалгааны ажлыг Хууль зүйн сайдын болон сонирхогч бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэний захиалгаар гүйцэтгэж санхүүжүүлнэ.” гэж заасан өгсөн нь Цагдаагийн байгууллага болон тус байгууллагын хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлсон ажил болсон юм.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь оршин суух нутаг дэвсгэр дэх амьдралын чанарыг сайжруулж, дахин дахин авагдаж буй цагдаагийн арга хэмжээний зардлыг багасгаж, ард иргэд цагдаагийн харилцааг сайжруулж чадна<sup>40</sup>.

Өнөөдөр олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа нь “Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн цагдаагийн үйл ажиллагаа” нэртэйгээр шинэ эрх зүйн зохицуулалтаар явагдахаар болж байна.

Өмнө нь мөрдөгдөж байсан Цагдаагийн байгууллагын тухай хууль нь 1993 онд батлагдаж, 1994 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш хорь шахам жил өнгөрсөн байна. Энэ хугацаанд нийтдээ 16 удаа нэмэлт өөрчлөлт орж, цаг үеийнхээ үйл ажиллагаагаа зохицуулсаар ирсэн байна.

Түүнээс гадна ШУА-ын Философи, социологи, эрхийн хүрээлэн, Азийн сан, Олон улсын соёлын төв, Максима судалгааны төв, ХСИС-ийн Цагдаа судлалын төв зэрэг байгууллагуудтай хамтран болон дангаараа цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны өнөөгийн байдалд хийсэн судалгаанууд Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, түүний эрх зүйн орчинд шинэчлэл хийх шаардлагатай болохыг харуулсан байна.

Тиймдээ ч 2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хурлын чуулганаар “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг баталж, 2014 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхлээд байна.

Өнөөдөр Цагдаагийн алба иргэний өмнө хариуцлага хүлээдэг байхын тулд иргэний хяналттай байх ёстой бөгөөд энэ талаар Цагдаагийн албаны тухай хуульд нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын төсвийн зарцуулалт, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэх, сургалт, үйл ажиллагаандаа орчин үеийн технологи нэвтрүүлэх бодлогын хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Иргэний зөвлөлтэй байхаар тусгасан.

Түүнээс гадна Цагдаагийн албаны тухай хуульд олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааны гол үндсэн субъект болох олон нийтийн цагдаагийн ажилтаны эрх зүйн байдлыг тодорхойлж өгсөн байна.

<sup>39</sup> Цагдаагийн байгууллагын тухай хууль 2014 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчингүй болж, Цагдаагийн албаны тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн

<sup>40</sup> Цагдаа. ЦЕГ-н сургалт арга зүйн сэтгүүл.УБ.,2000.

Цагдаагийн албаны тухай хуульд цагдаагийн албаны үйл ажиллагааны зарчмыг “иргэний дэмжлэг авах, төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэдтэй харилцан хамтран ажиллах” гэж тодорхойлсон байгаа. Үүний дагуу “Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа” гэсэн бүлэг нэмж тусгасан бөгөөд Нутгийн өөрөө удирдах байгууллага нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг хамгаалах үүрэг бүхий олон нийтийн цагдаагийн ажилтныг гэрээ байгуулан ажиллуулах, түүнд олгох урамшил, холбооны болон тусгай хэрэгслээр хангах, сургах зардлыг хариуцахаар болсон.

Түүнчлэн Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь Иргэний зөвлөл, цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн тухайн жилдээ ажиллуулах олон нийтийн цагдаагийн ажилтны тоог тогтооно.

“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай”<sup>41</sup> хуулийн 3.12.1-д “Нутгийн захиргааны байгууллага, харъяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахдаа иргэдийг дараах хэлбэрээр татан оролцуулахыг хуульчлан заасан байна. Энэ нь, хэсгийн байцаагчийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлаа явуулах, түүнд иргэдийг татан оролцуулахад гол эрх зүйн үндэс болж байна. Үүнд:

1. Иргэдийг нийтийн эргүүлд гаргах;
2. Хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрийг томилох;
3. Нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчаар ажиллуулах;

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, үйлчлэх нутаг дэвсгэрийн хэмжээ, оршин суух хүн амын тоо, ажлын ачаалал зэрэг хүчин зүйлээсээ хамаарч хэдэн нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагч ажиллуулахдаа Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17.1-д “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилго бүхий төрийн бус байгууллагын болон баг, хорооны Засаг даргын саналыг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга харъяа нутаг дэвсгэртээ ажиллах нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг томилно” гэсэн заалтыг баримталдаг байжээ.

Өнөөдөр нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийн оронд шинээр “олон нийтийн цагдаа” гэсэн стастус бүхий иргэнийг ажиллуулахаар болж байна.

Өмнө нь нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийн ажил үүргийг “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”<sup>42</sup>-ийн Дөрөвдүгээр бүлгийн 17, 18-р зүйлээр зохицуулж байсан бол шинэчлэн батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулийн 5 дугаар бүлгийн 24 дүгээр зүйлд “Олон нийтийн цагдаагийн ажилтан”-ны үйл ажиллагаа, эрх зүйн байдлыг нарийвчлан зохицуулж өгсөн заалт орсон байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийн 17.1-д “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилго бүхий төрийн бус байгууллагын болон баг, хорооны Засаг даргын саналыг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга харъяа нутаг дэвсгэртээ ажиллах нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг томилно” гэж заасан байсан бол шинэ “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 24.2-д “Аймаг, нийслэлийн Засаг даргаас Иргэний зөвлөл, цагдаагийн байгууллагатай зөвшилцөн гаргасан саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил бүр олон нийтийн цагдаагийн ажилтны тоог тогтооно” гэж заасан нь олон нийтийн цагдаагийн ажилтны томилгоог арай илүү тодорхой болгож өгсөн юм.

Өөрөөр хэлбэл нь өмнө “нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагч”-ийг Засаг дарга томилж байсан бол шинэ хуулиар Нутгийн захиргааны байгууллага томилохоор болсон явдал юм. Тухайлбал Нутгийн өөрөө удирдах байгууллага буюу Нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх,

<sup>41</sup> “Төрийн мэдээлэл” 1998 он №1

<sup>42</sup> Төрийн мэдээлэл. 1993. №1

нийтийн хэв журам хамгаалах ажилд олон нийтийн цагдаагийн ажилтан ажиллуулахаар болж байна.

Цагдаагийн албаны тухай хуулиар 20 нас хүрсэн иргэнийг сайн дурын үндсэн дээр, Засаг даргаас ирүүлсэн саналыг үндэслэн олон нийтийн цагдаагийн ажилтнаар томилох шийдвэр гаргаж, гэрээ байгуулах ба уг гэрээнд хариуцах ажил, талуудын харилцан хүлээх үүрэг, урамшил, гэрээ цуцлах үндэслэлийг заахаар зохицуулсан бөгөөд өмнө нь ямар ч хуулинд ийм зохицуулалт байгаагүй билээ.

Харин өнгөрсөн 2013 онд Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “Олон нийтийн цагдаагийн ажилтны дүрэм”-ийн төслийг боловсруулаад өргөн бариад байгаа ч хараахан батлагдаагүй байна.

Түүнчлэн Олон нийтийн цагдаагийн ажилтан хууль сахиулах үүрэг гүйцэтгэхдээ баримтлах зарчмыг уг хуулийн 24.5-д заасан “Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хууль тогтоомжийг чанд сахиж, зөвхөн гэрээнд заасан үүргийг биелүүлнэ” гэсэн зарчмыг баримтлан ажиллахаар болж байна.

Өмнө нь Нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагч нь “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 18.1.1-д “нийгмийн хэв журам хангах зорилгоор Захиргааны хариуцлагын тухай хуулийн 21, 23, 24, 251, 32 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 38 дугаар зүйл, 52 дугаар зүйлийн 5 дахь заалтын “Хог хаягдлаа ил асгах, орчин тойрноо бохирдуулах зөрчил”, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22, 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 1, 4,7,8 дахь хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 2,3 дахь хэсгийн 2 дахь заалт, Тамхины хор хөнөөлтэй тэмцэх тухай хуулийн 13 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 6 дугаар зүйл, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчлийг таслан зогсоох шаардлага тавьж, биелүүлээгүй тохиолдолд хуульд заасан торгууль ногдуулах”, 18.1.2-д “гэмт хэрэг, эрх зүйн зөрчлийн талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэж, хууль тогтоомжид заасан бусад арга хэмжээ авахуулах” гэсэн 2 үндсэн эрхийг эдэлж байсан бол шинэ хуулинд зааснаар олон нийтийн цагдаагийн ажилтан:

- Гэмт хэрэг, зөрчил гарсан газар, ул мөрийг хамгаалах,
- Шаардлагатай этгээдийн баримт бичгийг шалгаж, оршин суугаа газрын хаягийг тогтоох,
- Хэв журам сахих талаар иргэн, хуулийн этгээдэд шаардлага тавих,
- Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг түр саатуулах, цагдаагийн байгууллагад хүргэх эрхтэй байхаар зохицуулалт орсон байна.

Түүнээс гадна олон нийтийн цагдаагийн ажилтан гэмт хэргийн талаар цагдаагийн байгууллагад, зөрчил гарсан тухай төрийн холбогдох байгууллагад шуурхай мэдээлэх үүрэг хүлээнэ.

Шинээр хуулиар өмнөх нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчаас олон нийтийн цагдаагийн ялгагдах нэг онцлог заалт бол “Үүрэг гүйцэтгэж байгаа олон нийтийн цагдаагийн ажилтанд шаардлагатай холбооны болон хамгаалах тусгай хэрэгсэл тавьж олгоно” гэсэн зохицуулалт орсон бөгөөд энэ заалт нь нэг талаар олон нийтийн цагдаагийн ажилтныг хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлсэн, нөгөө талаараа өөрийнх нь аюулгүй байдлыг хангах бололцоог бий болгосон чухал ач холбогдолтой заалт орсон юм.

Олон нийтийн цагдаагийн ажилтны таних тэмдэг, хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай хувцас, нэг бүрийн тусгай хэрэгсэл, урамшил, сургалт явуулахтай холбогдсон зардлыг тухайн шатны Засаг дарга гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжид заасны дагуу санхүүжүүлнэ.

Энэ нь “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”<sup>43</sup>-ийн 19.1-д “Тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах

---

<sup>43</sup> Төрийн мэдээлэл. 1993. №1



чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” заасныг баримтлан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сан”-гаас санхүүжүүлэхээр болж байна.

Түүнээс гадна олон нийтийн цагдаагийн ажилтныг үүргээ биелүүлсэнтэй нь холбогдуулан доромжилсон, заналхийлсэн, бусад хохирол учруулсан, түүнээс тавьсан хууль ёсны шаардлагыг зориуд үл биелүүлсэн, эсэргүүцсэн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр тусгаж өгсөн нь түүний эрх зүйн хамгаалалтыг хийж өгсөн чухал зохицуулалт болсон юм.

Цагдаагийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээнийхээ хүрээнд олон нийтийн цагдаагийн ажилтны тавьсан шаардлагыг иргэн, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй.

Түүнчлэн Цагдаагийн албаны тухай хууль<sup>44</sup>-ийн 24.11-д Олон нийтийн цагдаагийн ажилтны хүлээх үүргийг тодорхой болгож өгчээ. Үүнд:

1. Хуулиар харъяалуулсан зөрчилд торгууль ногдуулах;
2. Хууль тогтоомжийг иргэдэд тайлбарлан таниулах;
3. Нийтийн хэв журам хамгаалах талаар хууль сахиулах байгууллага болон бусад хуулийн этгээдээс зохион байгуулж байгаа ажилд оролцох;

Харин олон нийтийн цагдаагийн ажилтныг сургаж, дадлагажуулах үүргийг цагдаагийн байгууллага хүлээхээр зохицуулалт орсон бөгөөд уг хуулийн 24.9-д заасан таних тэмдэг, хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай хувцасны загвар, хэрэглэх журмыг цагдаагийн төв байгууллагын дарга батлахаар болжээ.

Бид одоо нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагч гэж байснаас илүү эрх мэдэлтэй, хуулиар хүлээсэн үүрэгтэй, хүлээх хариуцлагатай, тусгай хэрэгсэл хэрэглэх эрх бүхий чадварлаг олон нийтийн цагдаатай болсоноор гэмт хэрэг, зөрчил тодорхой хэмжээгээр буурах нөхцөл бүрдэх, нөгөө талаараа цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах үүргийн тодорхой хэсгийг олон нийтийн цагдаа гүйцэтгэснээр иргэд цагдаагийн хоорондын хамтын ажиллагаа шинэ түвшинд гарах боломж бололцоо бий болсон гэж үзэж болохоор байна.

Гагцхүү цагдаагийн алба хаагч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам сахиулахдаа дангаараа бус олон нийтийн цагдаатайгаа хамтарч, нэг багийн хэлбэрээр үүрэг гүйцэтгэснээр гэмт хэрэг, зөрчил багасгаж, иргэд, олон нийт амар тайван амьдрах нөхцөл боломж төдий хэмжээгээр нэмэгдэх юм.

Эцэст нь олон нийтийн цагдаагаар ажиллах иргэнийг зөв сонгон авч, сургалтанд сайн хамруулах, түүнд эрх зүйн болон ёс зүйн өндөр шалгуурыг тавих, нөгөө талаасаа түүний эдийн засгийн баталгааг нь сайтар хангаж өгөх аваас жинхэнэ утгаараа сайн ажиллах боломж бүрдэх болно.

---

<sup>44</sup> Төрийн мэдээлэл. 1993. № 8



## **ЦАГДААГИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА**

*Б.Намсрай*

*ЦЕГ-ын Мэдээллийн шинжилгээ, криминологийн  
хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн ахмад*

Гадаад орны жишиг туршлагаас үзэхэд<sup>45</sup> цагдаагийн байгууллага бүр өөрийн гэсэн мөрийн хөтөлбөртэй байдаг. Учир нь хууль сахиулах байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл, стратегийн зорилго, зорилтыг орчин үед мөрийн хөтөлбөрөөр тодорхойлж байна.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д Монгол хүний аюулгүй амьдрах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах, хууль сахиулах байгууллагын албан хаагчид тавих ёс зүй, мэргэжлийн чадвар, хариуцлага, хууль сахин биелүүлэх шаардлагыг өндөржүүлж, эрх зүй, нийгмийн баталгааг дээшлүүлэхээр заасан.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2011 оны 4 дүгээр сард зохион байгуулагдсан “Шүүх эрх мэдлийн байгууллагын шинэчлэл” чуулга уулзалтын үеэр Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг шинэчлэх зайлшгүй шаардлага байгааг онцлон тэмдэглэсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт цагдаагийн хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг орон нутгийн эрх мэдлийн түвшинд зохион байгуулах, төрийн байгууллага, алба хаагчийн эрх, үүргийг боловсронгуй болгож иргэддээ үйлчилдэг, ил тод, нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлэх зорилт тусгагдсан.

Засгийн газрын 2012 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Хууль зүйн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т харъяа агентлагийн эрх зүйн шинэтгэлийн талаарх бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах гол зорилтыг дэвшүүлсэн.

Монгол Улсын Их Хурлаас 2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Цагдаагийн албаны тухай хуулийг баталснаар хууль сахиулж, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйлчилгээг иргэдэд үзүүлэх үүргийг цагдаагийн байгууллагад хүлээлгэн, хууль сахиулах албаны шинэчлэлийн эхлэлийг тависан.

---

<sup>45</sup> Police, Future directions strategy, 2012

Монголын цагдаагийн байгууллагад мэргэжлийн болон технологийн шинэчлэлийг хийх нь цагдаагийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэх үндсэн нөхцөл гэж гадаадын зарим улсын тэргүүлэх экспертүүд<sup>46</sup> судалгааны ажилдаа дүгнэсэн.

Үүнд олон улсын илүү өргөн цар хүрээтэй, урт хугацааны хамтын ажиллагаанд тулгуурласан шинэтгэл (реформ) хийх замаар л цагдаагийн ажил, үйлчилгээг мэргэжлийн түвшинд хүргэж, иргэдийн итгэлийг эргэн олж авах ба зөвлөлт маягийн цагдаагийн арга барилаас орчин үеийн цагдаагийн загварт шилжихэд Монгол Улсын Засгийн газар, Цагдаагийн төв байгууллага болон олон улсын байгууллагуудын байнгын анхаарал, идэвхтэй оролцоо шаардагдана хэмээн зөвлөсөн.

Судалгаагаар<sup>47</sup> цагдаагийн байгууллага нь хүнд сурталтай, цагдаагийн ажилтнууд дээрэнгүй, харьцааны соёлгүй, мэдлэг, мэргэжлийн ур чадваргүй, иргэдтэй тэгш бус харилцдаг, цагдаагийн удирдлагаас алба хаагчдын ажил үүргийн хараат бус байдалд нөлөөлдөг, танил тал, мөнгөтэй хүнд үйлчилдэг гэж олон нийт дүгнэсэн.

Нөгөө талаар, иргэдээс цагдаагийн алба хаагчдыг дорд үзэх, гүтгэх, доромжлох нь ердийн үзэгдэл болсон, түүнчлэн алба хаагчдын ажлын цаг ихэнхдээ тодорхой бус, гэр бүлдээ анхаарал тавих цаг гардаггүй зэргээс шалтгаалж алба хаагчид бухимдах, цочролд /стресс/ орж улмаар иргэдтэй зүй бусаар харьцах байдал гаргадаг болох нь тогтоогдсон байна.

Цагдаагийн байгууллагаас үзүүлж байгаа ажил үйлчилгээнд иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг судлахад<sup>48</sup> 70 орчим хувь нь дунд буюу түүнээс доош үнэлгээ, харин алба хаагчдын харилцааны соёлын тухайд 50 хувь нь хангалтгүй үнэлгээ өгчээ.

Цагдаагийн байгууллагын гадаад, дотоод орчны шинжилгээгээр Цагдаагийн албаны тухай хууль, үйл ажиллагааны журам батлагдаж, байгууллага, алба хаагчийн ажил үүргийн технологи боловсронгуй болох эхлэл тавигдсан, цагдаагийн байгууллагад шинэчлэл хийх хүсэл эрмэлзлэл төр, иргэд, олон нийт, алба хаагчдын хүрээнд бий болсон, байгууллагын үйл ажиллагааны технологийг хөгжүүлэх, техник хэрэгслийн хангамжийг олон улсын нийтлэг жишигт нийцүүлэх, хүний нөөцийг чадавхжуулахад гадны байгууллагын дэмжлэг авах зэрэг боломж, давуу тал байна.

Байгууллагын дотоод, гадаад соёл төлөвшөөгүй, байгууллагын үнэт зүйлийг бий болгож чадаагүй, боловсон хүчнийг сонгон шалгаруулж авах тогтолцоо шинэчлэгдээгүй, менежерийн сонголт учир дутагдалтай бөгөөд удирдах ажилтан бэлтгэх тогтолцоо бий болоогүй, алба хаагчдын гадаад хэлний мэдлэг хангалтгүй, шинэ мэдээлэл олж авах арга барилд суралцаагүй, багаар хамтран ажиллах чадвар муутай, боловсон хүчний дунд өвчлөл их, алба хаагчдыг цол, албан тушаалын байдлаар ялгаварлан гадуурхах хандлага бий болсон, төсөв хомсдолтой, төсвийн зарцуулалт оновчтой биш зэрэг бэрхшээл, сул тал байсаар байна.

Дээрх хүчин зүйлүүд нь Цагдаагийн байгууллагын бодлого үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилтыг тодорхойлсон үндсэн баримт бичиг болох “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”-ийг батлан гаргах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж байна.

Хууль сахиулах салбарт хийгдэж буй шинэчлэлийн бодлогын хүрээнд Улсын Их Хурлаас батлан гаргасан Цагдаагийн албаны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг Засгийн газар батлана гэж заасныг үндэслэн Цагдаагийн ерөнхий газраас хөгжлийн хөтөлбөрийн төслийг боловсруулж, Хууль зүйн яаманд хүргүүлснийг та бүгдэд танилцуулж байна. Үүнд:

#### **Цагдаагийн эрхэм зорилго:**

“Найдвартай баталгаатай үйлчилгээ-иргэд, олон нийтийн итгэл, дэмжлэг”

<sup>46</sup> “Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, чадавхийн үнэлгээ”, Ирвин Бейкин, Стив Корич, 2009 он

<sup>47</sup> Цагдаагийн байгууллага, цагдаагийн алба хаагчдын үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх үнэлгээний судалгаа, “Максима” судалгааны төв, 2007, 2013 он

<sup>48</sup> “Иргэн-цагдаагийн харилцаа, хамтын ажиллагаа” нээлттэй уулзалт, санал асуулга, Цагдаагийн ерөнхий газар, 2012 он

### **Сайн удирдлага, зохион байгуулалт:**

1.Байгууллагын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн болон эрсдлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлнэ.

2.Цагдаагийн байгууллагад үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хөгжүүлнэ.

3.Хууль тогтоомжоор нууцад хамааруулснаас бусад асуудлаар ил тод, нээлттэй байж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэний зөвлөл, олон нийтийн бодит хяналтад оруулна.

4.Цагдаагийн үйл ажиллагааг хууль сахиулах салбарын шинэчлэл, шүүх эрх мэдлийн болон нутгийн удирдлагын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дэмжлэгтэй нягт уялдуулан хууль сахиулах, хуулийн хэрэгжилтийг хангах, нийгмийн хариуцлагыг төлөвшүүлэх чиглэлээр харилцан ажиллана.

5.Цагдаагийн албаны бүх шатанд эрх мэдэл, хариуцлагыг оновчтой хуваарилж, иргэдэд хүртээмжтэй, үр ашигтай бүтэц, тогтолцоог нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх зарчмыг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагыг бие даан хөгжүүлэх бодлоготой уялдуулан бий болгож, Засгийн газраас тогтоосон жишиг нормативийн дагуу ажил, үйлчилгээ үзүүлнэ.

6.Цагдаагийн үйл ажиллагаанд эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнг тухай бүр, байнга, тасралтгүй ашиглаж, “Цагдаагийн инноваци” төсөл хэрэгжүүлнэ.

7.Гадаад оронд оршин суугаа Монгол Улсын иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхолыг хамгаалах, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор зарим оронд цагдаагийн атташег ажиллуулна.

8.Гадаад орны цагдаагийн байгууллагын сайн туршлагаас ямагт суралцаж үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.

9.Байгууллагын дотоод ардчилал, соёлыг /сэтгэл зүй, үзэл хандлага, туршлага, итгэл үнэмшил, үнэт зүйл, өнгө төрх/ төлөвшүүлнэ.

10.Алба, алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг чиг үүргийн онцлог, ажлын ачааллыг харгалзан үр дүнгээр нь тооцдог болно.

### **Мэргэшсэн үйл ажиллагаа:**

1.Цагдаагийн албаны хууль сахиулах үйл ажиллагааг стандарт, арга зүй, аргачлалын дагуу явуулдаг болно.

2.Цагдаагийн хууль сахиулах үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, шударга, тэгш, хараат бус байх хэмжүүрийг бий болгон дагаж мөрдөнө.

3.Мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа зөвхөн хууль ёсны, үндэслэлтэй, хангалттай нотлох баримтанд тулгуурлан шийдвэр гаргана.

4.Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны стратеги, тактик арга зүйг эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үндэслэлтэйгээр хөгжүүлж, үйл ажиллагаанд ашиглана.

5.Цагдаагийн үйл ажиллагаанд шаардлагатай мэдээлэл цуглуулах, шалгах, үнэлэн шинжлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх үйл ажиллагааг мэдээллийн технологийн хөгжилд тулгуурлан саадгүй, шуурхай зохион байгуулна.

6.Цагдаагийн хууль сахиулах үйл ажиллагаанд хүний оролцоог багасган мэдээллийн технологийг нэвтрүүлж “Цахим цагдаа” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

### **Эрүүл, чадварлаг хүний нөөц:**

1.“Эрүүл мэнд-цагдаа” төслийг хэрэгжүүлнэ.

2.Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, үндсэн чиг үүргийн болон дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллах хүний нөөцийн бүтцийн зохистой харьцааг бий болгоно.

3.Цагдаагийн албан тушаал /ажлын байр/-ын тодорхойлолт, судалгаа, сонгон шалгаруулалт явуулж, томилох журмыг шинэчилж, тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн, мэргэшсэн, авьяас чадвартай, хүнлэг хүний нөөцийг бүрдүүлнэ.

4.Цагдаагийн алба хаагчийн бакалавр, магистр, докторын түвшний сургалтыг уялдуулан зохион байгуулж, давтан сургах, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, бүсчилсэн сургалтын төвүүдийг байгуулна.

5.Манлайлах чадвар бүхий цагдаагийн удирдах ажилтан бэлтгэх бодлого баримтална.

6.Ажлын байрны шаардлагыг бүрэн ханган ажиллаж байгаа алба хаагч, ажилтныг тогтвортой ажиллах, дэвших боломжтой байлгаж, цагдаагийн албанд төрийн албаны мерит тогтолцоог төлөвшүүлнэ.

7.Цагдаагийн алба хаагчийн гаргасан ёс зүйн зөрчлийг олон нийтийн оролцоотой ёс зүйн хороогоор хэлэлцэж шийдвэрлэдэг болно.

8.Цагдаагийн алба хаагч, ажилтны өмч хөрөнгө, хуримтлалтай болох, амьдралын чанараа дээшлүүлэхэд нь цалин хөлсийг нэмэгдүүлэх, нөхөн олговор, даатгалд хамруулах, мөнгөн урамшил, тусламж өгөх, амины орон сууцаар хангах зэрэг арга замаар бодитой хувь нэмэр, дэмжлэг үзүүлнэ.

9.Алба хаагч ажилтны хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, хөдөлмөрийн нөхцлийг дээшлүүлнэ.

#### **Үр ашигтай төсөв, санхүү, хөрөнгө оруулалт:**

1.Төсөв, хөрөнгө оруулалтыг байгууллагын хөгжлийн стратеги төлөвлөгөө, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний бодит хэрэгцээнд тулгуурлан үндэслэлтэй оновчтой төсөвлөнө.

2.Санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж шилэн дансны тогтолцоог хөгжүүлнэ.

3.Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангана.

4.Зардал үр дүнгийн тооцоо, санхүүгийн шинжилгээг тогтмол хийж үр ашиггүй зардал гаргахгүй ажиллана.

5.Цагдаагийн хөгжлийн санг үүсгэн хөгжүүлнэ.

#### **Олон нийттэй (үйлчлүүлэгч, хэрэглэгчтэй) харилцах /маркетинг/-ийг хөгжүүлэх:**

1. Цагдаагийн байгууллагын үйлчилгээний маркетингийг залуучууд, насанд хүрээгүйчүүд зэрэг нийгмийн зарим төрлийн бүлэг рүү чиглүүлж, хууль сахиулах үйл ажиллагаанд тэдгээр бүлгээс хариу дэмжлэг авч ажиллана.

2. Нэгэн ижил стандартын үйлчилгээний арга барил, зан харьцаа, барилга байгууламж, албаны автомашин, техник хэрэгслийг нэвтрүүлж гадаад өнгө төрхийг шинээр бий болгоно.

3. Цагдаагийн үйл ажиллагааны талаар олон нийтэд эрэлттэй мэдээллийн төрлийг судалж, харилцагч үйлчлүүлэгч байгууллага, аж ахуйн нэгж, иргэний санал, хүсэлтэд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр тэдний түгээмэл ашигладаг мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээллээр туслах тогтолцоо бий болгоно.

4. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс зохион байгуулж байгаа аливаа арга хэмжээ, үйл ажиллагаанд цагдаагийн байгууллагын оролцоог нэмэгдүүлж, харилцан ажиллагааны явцад байгууллагад шинээр нэвтрүүлсэн ажил, үйлчилгээний талаар сурталчилгаа явуулна.

5. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн бусад эх сурвалжаас иргэдэд хүрч байгаа сөрөг мэдээллийг удирдах, хянах, нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах байдлаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж хэвшинэ.

6. Цагдаагийн үйл ажиллагааны маркетингийн удирдлагыг чанартай, шуурхай, соёлтой үйлчилгээг олон нийтийн итгэл дэмжлэг, иргэний хяналтад тулгуурлан хөгжүүлнэ.

### **Дүгнэлт:**

Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн хамгийн чухал хэсэг бол эрхэм зорилго байдаг. Жишээ нь Өмнөд Австралийн цагдаагийн эрхэм зорилго /уриа/-ыг “гэмт хэрэг, эмх замбараагүй байдлаас олон нийтийг хамгаалж, амар тайван амьдрахын төлөө хамтдаа”<sup>49</sup> гэсэн байна.

Policing буюу цагдаагийн үйл ажиллагааны хандлагыг problem oriented буюу нийгмийн өмнө тулгамдсан тодорхой төрлийн гэмт явдалтай тэмцэх<sup>50</sup>, community буюу олон нийтийн идэвхи оролцоонд түшиглэж цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэх, zero tolerance буюу цагдаагийн нийтлэг үүргийг өргөн хүрээнд хэрэгжүүлэх, intelligence-led policing буюу мэдээллийг нэгтгэн боловсруулах зэргээр томъёолж байна.

Эдгээрийн аль нь ч цагдаагийн үүрэг тул аль болох олон талаас нь судалж, хөгжлийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх нь зайлшгүй.

Цагдаагийн чиг үүрэг бөгөөд иргэдийн чин хүсэл болсон “амар тайван амьдрал” нь дэлхийн олон орны цагдаагийн албаны уриа байдаг бол “найдвартай баталгаатай үйлчилгээ-иргэд, олон нийтийн итгэл, дэмжлэг” нь орчин үеийн цагдаагийн эрхэм зорилго байсаар иржээ.

Цагдаагийн албаны үнэт зүйл, бахархалыг эрдэмтэд<sup>51</sup> томъёолсон бөгөөд “Эх орон, ард түмэндээ өргөсөн тангараг”, “цагдаагийн түүхэн уламжлал, хуримтлуулсан туршлага, туг, бэлгэ тэмдэг, дүрэмт хувцас, цол, үнэмлэх, энгэрийн тэмдэг”-ийг цагдаагийн албаны бахархал /үнэт зүйл/ болгон томъёолох боломжтой байна.

“Найдвартай баталгаатай үйлчилгээ-иргэд, олон нийтийн итгэл, дэмжлэг” гэсэн эрхэм зорилго дор сайн удирдлага зохион байгуулалт, мэргэшсэн үйл ажиллагаа, эрүүл чадварлаг хүний нөөц, үр ашигтай төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, олон нийттэй харилцах маркетинг гэсэн үндсэн стратегийн зорилгын хүрээнд хөгжлийн хөтөлбөрийн мөн чанар /философи/ оршино.

Хууль сахиулах салбарт хийгдэж буй шинэчлэлийн бодлогын хүрээнд цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр батлагдсанаар цагдаагийн байгууллага ирээдүйн хөгжлөө эрх зүйн баримт бичгээр баталгаажуулах боломж бүрдэнэ.

Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хууль зүйн салбарт хийгдэх шинэчлэлийн бодлогын салшгүй хэсэг бөгөөд хууль сахиулах үйл ажиллагааг Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, стандарт, олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд үр ашигтай хэрэгжүүлэх, байгууллагын хөгжлийн бодлого үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилтыг тодорхойлсон үндсэн баримт бичиг болон батлагдах юм.

Олон Улсын жишгээр хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацааг хэт урт төлөвлөдөггүй. Нөгөө талаар цагдаагийн байгууллагад хийх шинэчлэлийг аль болох богино хугацаанд хийхээр салбарын яам төлөвлөж байгаа. Иймд хөтөлбөрийн үргэлжлэх хугацааг 4 жил байхаар төлөвлөөд байна.

Улсын болон орон нутгийн төсөв, цагдаагийн хөгжлийн сан нь хөтөлбөрийг бодитой үр дүнд хүргэх санхүүжилтийн эх үүсвэр гэж найдаж байна.

ЦЕГ-ын харьяа алба, төв, орон нутгийн цагдаагийн нэгж, алба хаагчид хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд багийн зохион байгуулалтаар оролцож, хөтөлбөрийн зорилго, зорилт тус бүрийг чиглүүлэх баг, мэргэжилтний бүрэлдэхүүнийг Хууль зүйн сайдын төсвийн багцаас сургаж, дадлагажуулах санал дэвшүүлсэн.

Хөтөлбөрийн биелэлтэд цагдаагийн төв байгууллагаас томилогдсон баг хөндлөнгийн судалгааны мэргэжлийн байгууллагатай хамтран жил бүр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмж гаргана.

<sup>49</sup> The South Australia Police, Future directions strategy 2003-2006, p 6

<sup>50</sup> Ц.Азбаяр, Цагдаагийн албаны хууль боловсруулах шаардлагын тухайд, илтгэл, 2013

<sup>51</sup> Доктор /ScD/ Ж.Болдбаатар, доктор /PhD/ Б.Бат-Эрдэнэ нар 2010 онд “Цагдаагийн номлол”-ыг боловсруулж байхдаа цагдаагийн үнэт зүйл, түүний агуулгыг анх гаргаж тавьсан.

Цагдаагийн албаны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилтын хүрээнд цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр жил бүр тодорхойлж, холбогдох стратегийг төлөвлөн чиглүүлэх ажлыг зохион байгуулах юм.



## ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХЭД “ЦАХИМ ХЯНАГЧ”-ЫГ АШИГЛАХ НЬ

*Ш.Чулуун*

*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн  
ахлах багш, докторант, цагдаагийн хошууч*

Өнөөдөр мэдээллийн технологи хөгжихийн хэрээр хүн өөрийн хэрэгцээндээ тулгуурлан техникийн хөгжлийг цаг, минут, секунд тутамд ашиглах болжээ. Одоо цагт хүн дэлхий дээр өөрийгөө чухам хаана байгааг тодорхойлж болдог GPS (global positioning system) хэмээх төхөөрөмж ашиглаад тодорхой хугацаа өнгөрчээ. Энэхүү төхөөрөмжийг хүмүүс зөвхөн өөрийн байрлалыг тодорхойлоод зогсохгүй Google map ашиглан бусад хүмүүс хаана байгааг тодорхойлох боломжтой болсон. Дамжуулагчтай GPS нь ямар үйл ажиллагаанд зориулагдан ашиглаж байгаагаасаа хамаарч тодорхой төрөлтэй байна. Тухайлбал,

- Автомашин /ачаа, суудлын, мотоцикл/
- Гэрийн тэжээвэр амьтанд зориулсан
- Хувь хүнд /хүүхэд, өндөр настан, сэтгэцийн өвчтэй/
- Тусгай төрлийн /Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий хууль сахиулах салбар/

ОХУ, АНУ, Израль, Герман, Испани, Энэтхэг, Хятад зэрэг улс оронд ял эдлүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд GPS төхөөрөмж хосолсон цахим хяналтын төхөөрөмж /электрон гав/-ийг ашиглаж байна. Хамгийн ашиглах боломжтой стандарт, чанар шаардлагыг хангасан цахим хяналтын төхөөрөмж нь АНУ-ын Secure Cutt технологи юм. АНУ-д хуулийн хүрээнд гэмт хэрэг үйлдсэн болон гэрийн хорионд байгаа этгээдийг шүүхийн тогтоолоор GPS төхөөрөмж хосолсон цахим хяналтын төхөөрөмжийг ашиглан хугацаатай мөрдөх, мөрдлөгийн явцад гарах зардлыг тухайн этгээдээр өөрөөр нь төлүүлж 24 цагийн турш хянадаг туршлага байна. Энэхүү хяналтыг АНУ-ын газар нутаг дээр хүчин төгөлдөр үйлчилдэг хуулийн дагуу гэмт этгээдээр өөрийг нь хянах хоног тутамд хэрэглэх цагийн хураамжийг нь хяналтын компанид төлүүлж тухайн компани нь уг этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах замаар хамтарч ажилладаг байна.

Өнөөдөр дэлхий тойрон эргэлдэж буй 27 хиймэл дагуулын 24 нь идэвхтэй горимд ажиллаж GPS төхөөрөмж чухам хаана байгааг хянаж байдаг. Цахим хяналтын төхөөрөмж нь аюулын буюу ослын дуудлага хийх, бодит байдалд хяналт тавих, явахыг хориглосон газрыг тэмдэглэх, зай дуусвал хэрэглэгчдэд LED гэрэл болон чичиргээгээр мэдрэгдэж төв рүү дохио илгээх бүрэн бололцоотой 100 хувь усны хамгаалалттай, хурд хэмжигчтэй, хэрвээ хэрэглэгч хөдлөхгүй бол дохиог төвд илгээх бөгөөд Google map хэрэглэж болно, нууцлал программ хангамж, өнгө үзэмж сайтай бөгөөд АНУ-ын SecureCutt технологийн загварыг ашиглан хийсэн тул гэмт этгээд уг төхөөрөмжийг тайлах болон тайлахыг оролдох үед түгшүүрийн дохиог төв рүү болон цагдаагийн байгууллагад мэдээлдэг байна.



Ардчилсан нийгэмд Үндсэн хуулиар хүний эрх эрх чөлөөг дээдлэн баталгаажуулснаар хүний хөгжлийг эрхэм зорилго болгож баривчлах, хорих ялыг иргэнд үр нөлөөтэй нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэх, нөгөө талаас гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг сайжруулах, иргэдийн амьдрах аюулгүй, амар тайван орчинг бүрдүүлэх явдал юм.

Сүүлийн үед гэмт хэрэг, зөрчлийн гаралт өсөн нэмэгдэж, нийгэм, ард иргэд болон улс оронд их хэмжээний хор хохирол учруулах явдал өсөх хандлагатай байгаа бөгөөд үүний эсрэг арга хэмжээнд ашиглаж болох хамгийн оновчтой арга хэрэгслийн нэг нь гэмт хэргийг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, эрэн сурвалжлах зорилгоор ашиглах зориулалт бүхий цахим хяналтын төхөөрөмж /электрон гав/ юм.

Тухайлбал: Монгол Улс дахь гэмт хэргийн нөхцөл байдлыг 2012 оны байдлаар авч үзвэл:

- 19734 хүн гэмт хэрэгт холбогдсоноос 71 хүн захиргааны хяналтад байхдаа, 152 хүн хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд батлан даалтанд байхдаа гэмт хэрэг дахин үйлдсэн байна.<sup>52</sup>
- Одоо хоригдож байгаа 6911 ялтны 3414 нь давтан гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, хэрэв эдгээр давтан гэмт хэрэг үйлдсэн 3414 хүнд электрон гавыг хэрэглэж хяналт тогтоосон бол 80% нь гэмт хэрэгт холбогдохгүй байх боломжтой байжээ.<sup>53</sup>
- Нийт 2573 хүн, 382 хүүхэд хорих ял шийтгүүлж, ял хойшлогдсон гэсэн шалтгаанаар цагдаагийн байгууллагын хяналтад байна гэсэн тоо баримт байна.<sup>54</sup>

Эдгээр тоо баримтуудыг нэгтгэн дүгнэж, эрүүгийн гэмт хэрэгт холбогдогчдын болон давтан гэмт хэрэг үйлдэгсэд, захиргааны хяналтад авах хүний судалгааны үндсэн дээр цахим хяналтын төхөөрөмжийг хэрэглэх субъектын тоог тодорхойлж болохоор байна. Иймд хууль сахиулах байгууллагын дараах үйл ажиллагаанд цахим хяналтын төхөөрөмжийг ашиглаж болно. Үүнд:

#### **Захиргааны хяналтад байгаа хүнд хэрэглэх**

Хорихоос суллагдсан хүнийг давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хуульд заасан журмын дагуу захиргааны хяналт тогтоохдоо гэмт хэргийн төрөл, учирсан хохирол хэмжээнээс шалтгаалан хугацаатайгаар хэрэглэдэг байх. Захиргааны хяналтыг үр дүнтэй авч хэрэгжүүлж, хяналтад байвал зохих хүн бүрт цахим хяналтын төхөөрөмжийг хэрэглэж, байнгын хяналтад байлгаж чадсанаар гэмт хэрэг үйлдэх боломжийг хязгаарлаж, ингэснээр түүний гэмт хэрэг үйлдэх санаа, сэдлийг бууруулж чадах ба үйлдсэн тохиолдолд түүний цаг, маршрутыг гэмт хэргийн гаралт, үетэй тохируулан үзэж хэргийг илрүүлэх ач холбогдолтой.

#### **Батлан даалтын арга хэмжээ авагдсан хүнд хэрэглэх**

- 2012 онд нийт 19734 хүн гэмт хэрэг үйлдсэнээс хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд болон эрх хязгаарлах арга хэмжээ авагдсан үед 161 хүн дахин гэмт хэрэгт холбогдсон гэх судалгаанаас үзэхэд энэ шатанд цахим хяналтын төхөөрөмжийг хэрэглэх хэрэгцээ, шаардлага байгааг харуулж байна.

#### **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ял эдэлж байгаа ялтанд хэрэглэх**

- Ялтныг хуяглан хүргэх үед цахим хяналтын төхөөрөмж хэрэглэх. Энэ тохиолдолд ялтан оргон зайлахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ болох бөгөөд оргон зайлсан тохиолдолд уг төхөөрөмжөөр байршил, замыг шууд тогтоох боломжтой.

<sup>52</sup> Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл судалгааны төвийн 2012 оны мэдээ

<sup>53</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2012 оны ажлын мэдээ

<sup>54</sup> Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл судалгааны төвийн 2012 оны мэдээ

- Ялтан түр чөлөөгөөр гарч буй үед цахим хяналтын төхөөрөмж хэрэглэх. Энэ нь түүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлнэ.
- Ялтныг гадуур хөдөлмөр эрхлүүлэх үед цахим хяналтын төхөөрөмж хэрэглэх. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас 2012 онд хөдөлмөр эрхэлж буй ялтан 6808 байсан байна.

#### **Гэмт хэрэг үйлдсэн этгээд ял эдлүүлэх ажиллагаанд ашиглах**

- Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд эрх хязгаарлах ял эдлүүлэхэд цахим хяналтын төхөөрөмжийг хэрэглэх боломжтой байна.

Иймд Монгол Улсын хууль сахиулах салбарын инновацийн бодлогыг хэрэгжүүлэх, хууль сахиулах үйл ажиллагаанд тэргүүний дэвшилтэт техник, технологийг эрчимтэй нэвтрүүлэх замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мөрдөн шалгах ажлын үр дүнг дээшлүүлэх зорилтын хүрээнд дэлхийн хөгжилтэй зарим орнууд хууль сахиулах үйл ажиллагаандаа хэрэглэдэг цахим хяналтын төхөөрөмжийг судалж, туршин практикт нэвтрүүлэх шаардлагатай байна. Энэхүү цахим хяналтын төхөөрөмжийг хэрэглэх хууль эрх зүйн үндэслэл нь Монгол Улсын дараах хуулиудад доорхи байдлаар тусгагдсан байна. Үүнд:

- Засгийн газар нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.<sup>55</sup>
- Ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдалд тохирсон байна.<sup>56</sup>
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг явуулахдаа гэмт хэргийн ул мөрийг илрүүлэх, түүнийг буулган авах, бэхжүүлэхдээ шинжлэх ухааны үндэслэл бүхий арга, техник хэрэгслийг ашиглана.<sup>57</sup>
- Эрүүгийн хуулийн 73-75, 86, 90, 111-113, 123, 125, 127, 239, 254-р зүйлд заасан гэмт хэрэгт 5-аас дээш жил хорих ял эдэлсэн, эсхүл түүнийг давтан үйлдсэн хүн хорих ял эдэлж суллагдсан бол дахин гэмт хэрэг үйлдэх, нийгмийн хэв журам зөрчихөөс нь урьдчилан сэргийлэх зорилгоор захиргааны хяналт тогтооно.<sup>58</sup>
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх ашиг сонирхлыг хүндэтгэх, шуурхай, энэрэнгүй байх зарчимд үндэслэнэ.<sup>59</sup>
- Улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам сахиулах хэрэгцээнд зориулж хуваарилсан радио давтамжийн зурвасыг тусгай хэрэглээний гэнэ.<sup>60</sup> гэж тус тус заасан байна.

Цахим хяналтын төхөөрөмжийг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль сахиулах үйл ажиллагаанд ашиглах, тодруулбал захиргааны хяналтад байгаа хүнд хэрэглэх, батлан даалтын арга хэмжээ авагдсан хүнд хэрэглэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ял эдэлж байгаа ялтанд хэрэглэх, гэмт хэрэг үйлдсэн этгээд ял эдлүүлэх ажиллагаанд ашиглах зайлшгүй хэрэгцээ, шаардлага байна. Цахим хяналтын төхөөрөмжийг хууль сахиулах тусгай чиг үүргийн албанд нэвтрүүлж ашигласнаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хүний эрх, эрх чөлөө, аюулгүй байдлыг баталгаатай хангах таатай нөхцөл бүрдэх, хууль сахиулах байгууллагын ажилтнуудын хөдөлмөр хөнгөвчлөх, ажлын бүтээмжийг нь дээшлүүлэх, хувь хүнийг хүнийг хүмүүжүүлэх зэрэг ач холбогдолтой юм. Мөн гэмт хэргийн гаралтыг бууруулахад эерэгээр нөлөөлөөд

<sup>55</sup> Үндсэн хуулийн 38-р зүйлийн 2-р хэсгийн 7 дахь заалт

<sup>56</sup> Эрүүгийн хуулийн 6-р зүйлийн 6.1 дэх заалт

<sup>57</sup> Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 186-р зүйлийн 186.2 дахь заалт

<sup>58</sup> Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15-р зүйлийн 15.1 дэх заалт

<sup>59</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 3-р зүйлийн 3.1 дэх заалт


<sup>60</sup> Радио долгионы тухай хуулийн 6-р зүйлийн 6.1 дэх заалт

зогсохгүй, гэмт хэргийн улмаас иргэн, байгууллагад учрах хохирлын хэмжээ, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, эрэн сурвалжлах ажиллагаанд зарцуулагдах зардал багасах үр дүнтэй ажил болох юм.


#### Санал:

Цахим хяналтын төхөөрөмжийг хууль сахиулах үйл ажиллагаанд ашиглахад дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Цахим хяналтын төхөөрөмжийг ашиглах онол, арга зүйг шинжлэх ухааны үндэстэй боловсруулах
- Цахим хяналтын төхөөрөмжийн сургалт, эрдэм шинжилгээний лаборатори байгуулж түүндээ нэгдсэн иж бүрэн туршилт, судалгаа хийх замаар цахим хяналтын төхөөрөмжийг судалж, турших
- Цахим хяналтын төхөөрөмжийг ашиглах стандарт, аргачлалыг боловсруулах
- Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах, ашиглах журмыг нэмж батлан хууль эрх зүйн орчинг сайтар бүрдүүлсэн байх шаардлагатай байна.



## ЦАХИМ ХЯНАЛТЫН ТӨХӨӨРӨМЖ



**Электрон гавын нийтлэг боломж**

- GSM/GPRS
- Цахилгаан түгжээтэй
- Биеийн дулаан мэдэрдэг.
- Тайлах, таслах боломжгүй
- Дахин программчлах боломжгүй
- Цельсийн 100 градус, 5 метрийн гүн усанд 15 минут хүртэлх хугацаагаар битүүмжилсэн орчинд ажиллах
- Радио станц, хиймэл дагуул, эсхүл элгээрийн хосломол нөхцөлд ажилладаг.
- Явах хилийг зааглаж, цагийг хязгаарлах

fppt.com




## GPS ТӨХӨӨРӨМЖ ХОСОЛСОН ЦАХИМ ХЯНАЛТЫН ТӨХӨӨРӨМЖ

### ReliAlert™XC Features





## ХЯНАЛТЫН ТӨВ /ТЕХНИК ХЭРЭГСЭЛ, ПРОГРАММ ХАНГАМЖ/



## НЭГ ХҮНИЙ ЗУРАГНЫ ЗАЙ ГАРГАХ

### АЛБАН ҮҮРГЭЭ ГҮЙЦЭТГЭЖ ЯВААД АМЬ НАСАА АЛДСАН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ БОЛСОН ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧ, ТҮҮНИЙ АР ГЭРТ ҮЗҮҮЛЭХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН АСУУДАЛ

З.Цэрэнбат  
ОХУ-ын ДЯЯ-ны Москвагийн их сургуулийн  
докторант, цагдаагийн дэд хурандаа

Цагдаагийн алба нь төр, ард түмнийхээ өмнө тангараг өргөж гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах нэр хүндтэй бөгөөд амаргүй, эрсдэлтэй албанд нэгэн амьдралаа зориулах чин сэтгэлтэй эрчүүдээс бүрддэг билээ.

Бид энэхүү нийтлэлээр албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон цагдаагийн албан хаагчдын ар гэрт төрөөс үзүүлэх нийгмийн хамгааллын асуудлыг хөндөж байна.

**Нийгмийн хамгаалал гэдэг** олон улсын болон үндэсний эрх зүйн хэм хэмжээний үндсэн дээр хүний нийгмийн эрхийг хангах талаар баримтлах төрийн бодлогын нэг чухал хэсэг<sup>61</sup> бөгөөд нийгэмд хувь хүн нийгмийн гишүүнийхээ үүргийг биелүүлэх, нийгэм нь хамгаалах, нийгэм, эдийн засгийн болон эрх зүйн баталгааг үндэсний хууль тогтоомжийн үндсэн дээр бодитой хангах, нийгэм, улс төрийн зорилт, хүний амьдралын зорилгыг биелүүлэх, урьдчилан тооцоолсон төрийн бодлогын үйл ажиллагааг хэлнэ.<sup>62</sup>

Цагдаагийн байгууллагын алба хаагчийн нийгмийн хамгаалал гэдэг нь: албаны онцлог, нөхцөлтэй холбоотой эрх зүйн хэм хэмжээний зохицуулалт, төрөл бүрийн хөнгөлөлт, баталгаа, иргэний ерөнхий эрх, албанаас чөлөөлөгдсөн алба хаагч, иргэн, тэдгээрийн гэр бүлийн эрхийг хамгаалах зорилго бүхий олон нийтийн байгууллага, байгууллагын удирдлага, төрийн засаглалын байгууллагуудын хамтын үйл ажиллагааны үр дүн юм.<sup>63</sup>

Нийгмийн хамгаалалтын үндсэн зорилго нь ямар ч тохиолдолд амь насаараа хохирсон алба хаагчийн ар гэр, байлдааны ажиллагаанд оролцсонтой холбоотой сэтгэл зүйн болон эрүүл мэнд, бие махбодын хохирол амссан, тодорхой гавъяа байгуулсан алба хаагчийг бүх талаар дэмжих, хамгаалахад оршдог.<sup>64</sup>

Албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон цагдаагийн алба хаагчдын ар гэрт үзүүлэх нийгмийн хамгааллын баталгаа нь хүн нэг бүр дээр тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, нөхөн олголт, тусламж, туслалцааны хэлбэрээр, төрийн засаглалын механизм, эрх зүйн зохицуулалтын үр дүнд биелэлээ олж бодит байдлаар хэрэгжинэ.

Монгол хэлний тайлбар тольд **“тэтгэмж”** гэж тэтгэсэн зүйл, тусламж, тэтгэвэр, **“Тэтгэвэр”** гэж тусламж, нэмэр, тусламж тэтгэвэр хоршоо үг<sup>65</sup> гэж тайлбарласан байна.

<sup>61</sup> Правовая и социальная защита сотрудников органов внутренних дел: Учебное пособие /В.Я.Кикоть, В.А. Рыбин. Введение доктора юридических наук, профессор С.И. Гирько. М., ЦОКР МВД России, 2009. С.12

<sup>62</sup> Мөн тэнд

<sup>63</sup> Мөн тэнд 13 дахь тал

<sup>64</sup> Коровников.А.В. Социальная защита военнослужащих и зарубежных государств: правовое регулирование. М., 1997.С.13.

<sup>65</sup> Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966

Манай орны хувьд төр, ард түмнийхээ төлөө шаардлагатай үед онц төвөгтөй албан даалгавар биелүүлсэн<sup>66</sup> болон хуульд заасан бусад ажиллагаанд (амь нас дүйсэн ажил) оролцсон, албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан алба хаагчийн ар гэр, түүнчлэн тахир дутуу болсон цагдаагийн алба хаагчдад үзүүлэх нийгмийн хамгааллын асуудал тулгамдаж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж тунхагласан. Гэтэл 2008-2012 онд захиргааны зөрчлийн халдлагад 552, гэмт хэргийн халдлагад 235 цагдаагийн алба хаагч өртөж, 973 алба хаагч эрүүл мэндээрээ хохирсон.<sup>67</sup>

Цагдаагийн алба хаагчдыг доромжлох, дарамтлах, тэдний хууль ёсны шаардлагыг эсэргүүцэх, хүч хэрэглэх, амь биед нь халдах зэрэг үзэгдэл сүүлийн үед нэмэгдэж байна.<sup>68</sup>

### **1. Албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан цагдаагийн алба хаагчийн ар гэрт төрөөс үзүүлэх нийгмийн хамгаалал**

Монголын цагдаа, дотоодын цэргийн байгууллагын түүхэнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах үүргээ биелүүлж яваад 100 гаруй албан хаагч амь насаа алдсан.

Цагдаагийн алба хаагчийн гүйцэтгэж байгаа үүрэг нь бусад төрийн тусгай алба хаагчдаас дараах онцлог ялгаатай бөгөөд цагдаагийн алба хаагчид гэмт халдлагад өртөхөд дараах хүчин зүйл нөлөөлж байна. Үүнд:

- Хуучин арга барилаар цагдаагийн алба үйл ажиллагаанд хандах, удирдах, нийгмийн орчин байхгүй болсон.
- Нийгэмд баян, хоосны ялгаа эрс нэмэгдэж, шударга бус явдлууд газар авсан зэргээс шалтгаалан иргэд, нийгэм бухамдалтай байгаа өнөө үед цагдаа албан үүргээ хэвийн гүйцэтгэхэд хүндрэлтэй.
- Эрүүгийн болон хэв журмын нөхцөл таатай биш ( ...хоногт дунджаар 54 гэмт хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 3 хүн нас барж, 21 хүн хөнгөн, хүнд, хүндэвтэр хэлбэрээр гэмтэж байна<sup>69</sup>...) байгаатай уялдаад цагдаагийн алба үйл ажиллагаанд нийгмийн зүгээс алхам тутам эрсдэл дагуулж байна.
- Нийгмийн тодорхой хэсэг буюу гэмт хэрэг үйлдэж, захиргааны зөрчил гаргаж шүүхээр шийтгэгдэж байсан, болзошгүй, сэжигтэн, хохирогч, гэрч гэх мэт хүмүүстэй байнга харилцаж холбогдох асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэр гаргадаг.

Саяхан Ховд аймгийн Булган суманд цагдаагийн алба хаагчийг буудаж амь насыг нь хөнөөсөн хэрэг үйлдэгдсэн. 1994 оны Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай Монгол улсын хуулийн 4.13.1-т заасны дагуу ар гэрт нь алба хаасан жилээс нь шалтгаалан 5 сая төгрөг, оршуулгын тэтгэмж 148.500 олгосон байна.<sup>70</sup> Энэ нь дээрхи хуульд “албан үүргээ гүйцэтгэж яваад” гэсэн заалт байхгүй бөгөөд “байлдааны талбар, энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох, байлдааны галт хэрэгслээр буудлага хийх, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, аюултай хорт бодистой үүргийнхээ дагуу харьцах, гамшиг, онцгой нөхцлийн байдалд ажиллах, улсын хил, онц чухал объектыг хамгаалсны улмаас” гэж заасан байна.

<sup>66</sup> Хууль сахиулагчдын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 6.31.5

<sup>67</sup> Монгол Улсын Хууль зүйн яам, Хууль сахиулахын их сургууль, Цагдаагийн Ерөнхий газар. Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, үйл ажиллагааны орчин, түүний шинэтгэл. судалгааны тайлан. УБ., 2013. 8 дахь тал.

<sup>68</sup> ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн гаргасан судалгаа.УБ., 2012.

<sup>69</sup> Монгол улсын цагдаагийн ерөнхий газар мэдээлэл судалгааны төв. Монгол улс дахь 2010 оны гэмт хэргийн байдал, шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам. / албан хэрэгцээнд / УБ., 2011.С.5

<sup>70</sup> Criminology.mn.

Энэ нь цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад амиа алдсан тохиолдолд ар гэрт үзүүлэх нийгмийн хамгаалал нь бодитой биш байгааг илтгэж байна.

2009 оны 07-р сарын 09-ны өдрийн Хохирогчид нөхөн олговор олгох тухай Монгол улсын хуулийн 4.1.2-т заасныг үндэслэн 2008 оны 7-р сарын 1-ны өдрийн үймээний үед албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэндээрээ хохирсон төрийн тусгай албан хаагчид шүүх эмнэлгийн шинжилгээгээр тогтоогдсон гэмтлийн зэргийг нь харгалзан тухайн албан хаагчийн албан тушаалын нэг сарын цалинг хүнд 36, хүндэвтэр 12, хөнгөн 3 дахин өсгөх хэмжээгээр нөхөх олгохоор тусгасан байдаг. Тухайлбал, нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед албан үүргээ гүйцэтгэж байхдаа гэмтэж бэртсэн цагдаа дотоодын цэргийн 396 алба хаагчдад гэмтлийн зэргийг нь үндэслэн албан тушаалын нэг сарын цалинг нь 3-36 дахин нэмэгдүүлэн тооцож, 442.5 сая төгрөгийн нөхөн олговор өгч, нийт 421 алба хаагчид тус бүр 100 мянган төгрөгний тэтгэмж, алба хаагчдын эмчилгээ, оношлогооны зардалд 55 сая төгрөг зарцуулжээ<sup>71</sup>.

Мөн хуулийн 4.1.1-д заасны дагуу 2008 оны 7-р сарын 1-ны өдрийн эмх замбараагүй байдлын үед амь үрэгдсэн 4 иргэн тус бүрт төрөөс тавин сая төгрөгийн тусламж үзүүлжээ. Мөн хуулийн 7.1-т нөхөн олговрыг буцаан төлүүлэх талаар “Хохирогчид учирсан хохирлыг энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самуунд оролцож, ял шийтгүүлсэн этгээдийн хувьд ноогдох эд хөрөнгөөс гаргуулахаар шүүх шийдвэрлэсэн бол уг төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлнэ” гэж дурдсан байна. Одоогоор хэн хэдэн төгрөг төсөвт төвлөрүүлсэн талаар тодорхой баримт байхгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд “Хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно”<sup>72</sup> гэж заасан. Төрийн цагдаа ч жирийн иргэн ч амь насаа алдах нь харамсалтай. Адилхан Монгол улсын л иргэн. **Гэхдээ цагдаагийн алба хаагч төр, ард түмэндээ өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэж /хүний амь насыг хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэхгүй байж болохгүй/ яваад амь насаа алдах, харин өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөгөө (тухайн цаг үед энэ эрхээ эдлэхгүй байж болно) хэрэгжүүлж яваад амь насаа алдах нь хоорондоо ялгаатай. Монгол Улсын Үндсэн хуулийн 19.3 д заахдаа: “Хүн эрх чөлөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй” гэж түнхагласныг үндэслэл болгож асуудалд хандах нь үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцнэ.**

Нийгэм иргэдийн эрх ашиг, сонирхолд тулгарсан аюулаас гарцаагүй байдлын нөхцөлд хамгаалах нь цагдаа, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, авилгатай тэмцэх газар зэрэг төрийн тусгай байгууллагуудын хувьд хуулиар хүлээсэн үүрэг болдог.<sup>73</sup> Албан тушаалтан хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хайнга хандсан тохиолдолд Монгол Улсын Эрүүгийн хуулийн 272-р зүйлээр эрүүгийн хариуцлага хүлээнэ.

Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд<sup>74</sup> албан үүргээ гүйцэтгэж яваад нас барсан тохиолдолд хэрэгжүүлэх арга хэмжээ (929), албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон болон амь насаа алдсан үед тэтгэвэр, тэтгэмж олгох (930) асуудлыг дараах байдлаар тусгасан.

<sup>71</sup> ЦЕГ-ын даргын 2010 оны 691 тоот тушаалаар батлагдсан. Цагдаа дотоодын цэргийн алба хаагч, ажиллагсадын эрх хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах хөтөлбөр. Цагдаа сэтгүүл /2011.№ 01. 107 /

<sup>72</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 14-р зүйл. Төрийн мэдээлэл. УБ., 1992. №1

<sup>73</sup> С.Жанцан. Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол. /Гэмт хэргийн тухай сургаал/ I боть УБ., 2009. 718 дахь тал

<sup>74</sup> Цагдаагийн ерөнхий газар. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. УБ., 2011.



Алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон буюу амь насаа алдсан тохиолдолд дараах тэтгэвэр, тэтгэмж, зардлыг олгоно. ( 930.2.1)

- Хөдөлмөрийн чадвараа түр алдсан бол эмнэлгийн чөлөөтэй байсан хугацааны тэтгэмж, авч байсан цалингийн зөрүү;
- Тахир дутуу болсон тохиолдолд тахир дутуугийн тэтгэвэр, авч байсан цалингийн зөрүү;
- Амь насаа алдсан тохиолдолд ар гэрт нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр;
- Алба хаагч байлдааны талбар, энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох, байлдааны галт хэрэгслээр буудлага хийх, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, аюултай хорт бодистой үүргийнхээ дагуу харьцах, гамшиг, онцгой нөхцөлийн байдалд ажиллах, улсын хил, онц чухал объектыг хамгаалсны улмаас амь насаа алдвал 10 жилийн цалин;
- Энэ зүйлийн “г”-д зааснаас бусад албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон ослын улмаас амь насаа алдвал 5 жилийн цалин;
- Албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдолгүй осол, тарилгын дараах хүндрэл, ердийн өвчний улмаас амь насаа алдвал 3 жилийн цалин;
- Хиймэл эрхтэн хийлгэх бол түүний зардал;
- Бусад зардал.

#### Тэжээгчээ алдсаны тэтгэвэр. (930.5)

- Алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад нас барсан бол түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд тэжээгчээ алдсаны тэтгэврийг хууль, тогтоомжид зааснаар олгоно. (930.5.1.)
- Алба хаагч албан үүргээ гүйцэтгэж байгаад нас барсан бол тэтгэвэр тогтоолгосон цалин хөлсний 15 хувийн нэмэгдэл олгоно. (930.5.2.)
- Тэжээгчээ алдсаны тэтгэврийн доод хэмжээ нь Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байна. (930.5.2.)

#### Нэг удаагийн буцалтгүй тусламж олгох. (930.6)

- Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдвал хууль, тогтоомжид зааснаар тэдний ар гэрт нэг удаа буцалтгүй тусламж олгоно. (930.1),

Цагдаагийн алба хаагч амь насаа алдсан тохиолдолд ар гэрт нь нэг удаагийн буцалтгүй тусламж олгохдоо сарын дундаж цалин хөлсөнд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, доктор, профессорын, мэргэшлийн зэргийн нэмэгдэл, урамшил, байгууллагаас албан хаагчид олгож байгаа хоол, унааны зардал, орон сууц, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, түүнтэй адилтгах бусад орлого зэргийг оруулж тооцно (930.2) гэж заасан.

Ардчилсан хүний эрх, эрх чөлөөг дээдэлдэг улс орнуудын туршлагаас ажиглахад цагдаагийн алба үйл ажилагааг **“эрсдэлтэй, онцгой нөхцөл”** гэдэгт хамааруулан үздэг бөгөөд албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан цагдаагийн алба хаагч, түүний ар гэрт хүндэтгэлтэй ханддаж, шаардлагатай нийгмийн хамгааллын тусламж үйлчилгээг үзүүлдэг байна. Тухайлбал, ОХУ-ын 2011 оны Цагдаагийн тухай хуулийн Цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгаа гэсэн 8-р бүлгийн 43-р зүйлд: “Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж явахад үүссэн хохирлыг арилгах зорилгоор нөхөн төлбөр олгох даатгалын баталгаа”, ОХУ-ын 2012 оны Дотоод хэргийн байгууллагуудын алба хаагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 12-р зүйлд: Албан үүргээ гүйцэтгэж яваад сураггүй алга болсон, амь насаа алдсан алба хаагчдын ар гэрт нийгмийн дэмжлэг үзүүлнэ” зэрэг байдлаар хуульчилсан байна.

**Австрали улсад VSL (Value of Statistical Life) буюу хүний амьдралын статистик үнэ цэнийг тогтоохдоо өөрийн орны иргэдийн дундаж наслалтаас уг хүний насалсан насыг хасаж, гарсан тоог улсынхаа нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) тоогоор үржүүлж гаргадаг<sup>75</sup>. Энэ үнэлгээр албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан монгол цагдаагийн алба хаагчийн үнэлэмж 137.978 ам.доллар буюу 240 орчим сая төгрөг болж байна.**

Цаашид Хууль зүйн яамны 2012-2016 онд хийх ажлын хүрээний төлөвлөгөөнд тусгагдсан “Цагдаагийн алба хаагчийн эрсдлийн менежмент”-ийг боловсруулан мөрдүүлэх нь зайлшгүй болжээ<sup>76</sup>.

## **2. Албан үүргээ гүйцэтгэж яваад хөгжлийн бэрхшээлтэй болсон цагдаагийн алба хаагчийн нийгмийн хамгаалал**

Дэлхий нийтэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх нь зөрчигдсөн, тэгш бус байдлыг харгалзан улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын бүхий л салбарын хүрээнд асуудалд нухацтай хандаж, байнга анхаарлын төвд байх иргэд хэмээн үздэг.

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэдэг нь** нийгмийн хамгаалалт зайлшгүй шаардлагатай, амьдралын хэвийн үйл ажиллагаа нь бэртэл гэмтлийн улмаас өвчилсөн, эд эрхтэн хагас дутуу болсон, эрүүл мэндээрээ хохирсон иргэнийг хэлнэ<sup>77</sup>. Мөн хуульд **хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллыг** нийгмийн амьдралд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралын хэвийн нөхцлийг хангах зорилгоор тэдэнд тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговор олгох хэлбэрээр бусад иргэдийн нэгэн адил тэгш боломжоор хангах төрийн эдийн засаг, нийгэм, эрх зүйн хэм хэмжээний тогтолцоо юм” гэж заажээ.

2008 оны 7-р сарын 1-ны өдрийн нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үеэр албан үүрэг гүйцэтгэж байсан цагдаа, дотоодын цэргийн 523 алба хаагч эрүүл мэндээрээ хохирсноос хөнгөн гэмтэл учирсан 393, хүндэвтэр гэмтэл учирсан 17, хүнд гэмтэл учирсан 1 байна. Албан үүргээ гүйцэтгэж явсан цагдаа, дотоодын цэргийн 397 алба хаагч гэмтсэний 87 нь тархи, хүзүү, толгойны, 22 нь нүүр, нүд, шүдний, 53 нь нуруу нугасны, 41 нь хэвлий гэдэс, цээжний, 96 нь гар, шуу, тохойдоо, 245 нь хөл, шилбэ, тавхайндаа, түүнчлэн онцгой байдлын байгууллагын 3 алба хаагч, 8 иргэн бие эрхтэндээ гэмтэл авч, 270 гаруй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 11.4 тэрбум төгрөгийн хохирол учирсан<sup>78</sup>.

**Албан үүргээ гүйцэтгэж яваад гэмтэж бэртэн цаашид эмчилгээ сувилгаа шаардлагатай байгаа нийт цагдаа, дотоодын цэргийн 115 алба хаагч, тэднээс 30 гаруй нь хөгжлийн бэрхшээлтэй болж, хөдөлмөрийн чадвараа алдсан байна<sup>79</sup>.**

1960-аад оноос дэлхийн нийгэмлэг тахир дутуу болсон иргэдийн эрх, эрх чөлөөний хүрээнд тахир дутуу иргэдтэй харьцах олон улсын бодлого, загварыг тодорхойлж, тэдэнд тавих анхаарал, халамжийн үйлчилгээг дээшлүүлэхээр болсон. Үүний үр дүнд 1971 онд “Орхигдсон иргэдийн оюун ухааны тухай” НҮБ-ын тунхаглал, 1975 онд “Тахир дутуу иргэдийн эрхийн тухай” НҮБ-ын тунхаглал, 1982 онд “Тахир дутуу иргэдийг хамгаалах үйл ажиллагааны дэлхий нийтийн хөтөлбөр”, 1993 онд “Тахир дутуу иргэдийг тэгш боломжоор хангах хэм хэмжээний дүрэм” зэргийг тус тус баталсан юм.

2007 оны 1-р сарын 24-ны өдрийн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хуралдааны дээд түвшинд тахир дутуу иргэдийн нийгмийн хамгааллыг дээшлүүлэх, гэмтлийн хор уршгийг бууруулах, “тахир дутуу иргэдийн эрхийн тухай улс хоорондын хамтын гэрээ” баталсан. Хамтын гэрээний зорилго нь тахир дутуу иргэдийн амьдралын нөхцлийг тасралтгүй

<sup>75</sup> . Mongolnews.mn 2013.04.05.

<sup>76</sup> Монгол Улсын Хууль зүйн яам, Хууль сахиулахын их сургууль, Цагдаагийн Ерөнхий газар. Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, үйл ажиллагааны орчин, түүний шинэтгэл. “Судалгааны тайлан, санал, зөвлөмж” УБ., 2013. 8 дахь тал

<sup>77</sup> Федеральные закон о социальной защите инвалидов в Российской Федерации.СЗ РФ.1995. №48

<sup>78</sup> Монгол улсын Цагдаагийн ерөнхий газрын 2008 оны 7-рсарын 1-ны өдрийн нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын талаар танилцуулга мэдээ. УБ хот. 2009.

<sup>79</sup> Мөн тэнд.

дээшлүүлэх, орон сууц, хувцас, хоол хүнсээр хангах, тэдний ар гэр амьдралын түвшин, тахир дутуу иргэдийн эрхийг хамгаалах, урамшуулах, бусад иргэдийн нэгэн адил хүний үндсэн эрх, эрх чөлөөгөөр нь хангахтай холбоотой асуудлуудыг тухайн улсын төр, засгийн түвшинд харилцан тохиролцож, хүлээн зөвшөөрүүлэх явдал юм. (Хамтын гэрээний 1.28)

Монгол улс НҮБ-ын бүрэн эрх гишүүн улс болохын хувьд дээрх олон улсын гэрээ, конвенцийг өөрийн улсад дагаж мөрдөх үүргийг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн өмнө хүлээнэ. Төрийн бодлогын зорилго, зарчмын үндсэн дээр тахир дутуу иргэдийн нийгмийн болон эрх зүйн баталгаатай холбоотой асуудлыг олон улсын гэрээ конвенцийг дагаж мөрдөхөөс гадна өөрийн улсын хууль тогтоомжийн хүрээнд дараах байдлаар зохицуулагддаг.

Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг улс төр, эдийн засаг, хүмүүнлэгийн салбарт эрхээ эдлэх боломж нөхцлөөр хангагдах, тэдэнд учирсан сэтгэл санааны хохирлоо барагдуулахад анхаарах шаардлагатай байна.

**1994 оны Цэргийн албан хагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай Монгол улсын хууль болон Монгол улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам<sup>80</sup>-д албан үүргээ гүйцэтгэж яваад хөгжлийн бэрхшээлтэй болсон цагдаагийн алба хаагчид тэтгэвэр, тэтгэмж олгохоор заасан боловч энэхүү тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ нь тэдний амьдралын хэвийн нөхцлийг хангаж чадахгүй, дээрх Олон улсын хэм хэмжээнд нийцэхгүй байна.**

Манай улсад албан үүргээ гүйцэтгэж яваад хөгжлийн бэрхшээлтэй болсон алба хаагчдад тавих төрийн бодлого, үйл ажиллагаа суларч, нийгмийн хамгааллын тусламж үйлчилгээний хүртээмж дутмаг, тэдэнд тавих анхаарал халамж орхигдсон, хүний төлөө гэсэн сэтгэл бүдгэрч байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй иргэд амиа хорлох, согтууруулах ундаанд донтох явдал нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, Ой, хээрийн түймэр унтраахаар явж байсан онцгой байдлын алба хаагчдын сууж явсан МИ8 нисдэг тэрэгтэй сүйрч, олон алба хаагч амь эрсдсэн. Энэ ослоос амьд үлдсэн боловч хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэнд олгож байсан нийгмийн хамгааллын тусламжийг зогсоосон тул амиа хорлохыг завдсан. Иймд хөгжлийн бэрхшээлтэй болсон, хөдөлмөрийн чадвараа алдсан цагдаагийн алба хаагчдад онцгойлон анхаарал хандуулж ажиллах нь зүйтэй.

**ОХУ-ын ДЯЯ-ны сайдын 2007 оны 9-р сарын 24-ны өдрийн тушаалаар баталсан заавраар “ДЯЯ-ны бүтцэд ажиллаж, албан үүргээ гүйцэтгэж яваад хөдөлмөрийн чадвараа алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон алба хаагчдын дунд зохион байгуулах нийгмийн ажил, нийгмийн хамгааллын ажлын үндсэн чиглэлийг тодорхойлсон.<sup>81</sup> Тухайлбал,**

**Цагдаагийн төв болон орон нутгийн байгууллагаас албан үүргээ гүйцэтгэж яваад хөгжлийн бэрхшээлтэй болсон алба хаагчидтай ажиллах нийгмийн хамгааллын ажлын үндсэн чиглэл:**

- Албан үүргээ гүйцэтгэж яваад хөгжлийн бэрхшээлтэй болсон алба хаагчдын нийгэм, эдийн засгийн байдалд албан байгууллагын зүгээс хэрхэн анхаарч ажиллаж байгаад хяналт тавих ажлыг зохион байгуулах,
- Албан үүргээ гүйцэтгэж яваад хөгжлийн бэрхшээлтэй болсон алба хаагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлийг зөрчсөн нөхцөл, шалтгааныг тодорхойлох,
- Тэдэнд шаардлагатай нийгэм, эдийн засаг, сэтгэл санааны дэмжлэг тусалцааг шуурхай үзүүлэх,
- Тэднийг нөхөн сэргээх, эмчлэх, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах,

<sup>80</sup> Цагдаагийн ерөнхий газар. /Албан хэрэгцээнд/ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. Standart operating procedure. Анх дугаар хэвлэл. УБ., 2011.

<sup>81</sup> Социальная работа в органах внутренних дел( документы и материалы) 2007.С.9-18.

- Тэдэнд шаардлагатай байнгын сахиур, өдөр тутмын үзлэг, дэмжлэг, туслалцааг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах,
- Нийгмийн амьдралд дасан зохицох, хөдөлмөр эрхлэхэд тусламж үзүүлэх арга хэмжээ авах,
- Тэдний дунд иргэний мэргэжлээр суралцах, дахин сургах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах,
- Тэдэнд тулгамдаж байгаа амьдралын чухал асуудлыг шийдвэрлэх, эмнэлэгийн нөхөн сэргээх эмчилгээний төв, амралт, сувилалд явж амрах эрхийн бичиг олгох, орон сууцны нөхцлөө дээшлүүлэх, холбоогоор хангах ажлыг зохион байгуулах,
- Нийгэм, эрх зүйн хамгааллын асуудлаар мэдээлэл, лавлагаа авах нөхцлийг бий болгох, тэдэнд хууль зүйн зөвлөгөө өгөх,
- Даатгалын болон бусад тооцоо, тэтгэвэр, тэтгэмж авахад нь холбогдох бичиг баримтыг нь бүрдүүлж өгөх зэрэг болно.

**Цагдаагийн төв болон орон нутгийн байгууллагаас албан үүргээ гүйцэтгэж яваад хөгжлийн бэрхшээлтэй болсон, хөдөлмөрийн чадвараа алдсан алба хаагчдын дунд урьдчилсан төлөвлөгөөний дагуу нийгмийн ажлыг дараах байдлаар зохион байгуулахаар заажээ<sup>82</sup>. Үүнд:**

- Хөгжлийн бэрхшээлтэй болсон цагдаагийн алба хаагчийн нийгмийн болон эрх зүйн хамгааллын ажлыг зохион байгуулах тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өвчлөлийн зэрэглэлийг тогтоох /шарх, бэртэл, гэмтэл, битүү гэмтэл/ хүнд гэмтэл, шарх авсан алба хаагчийг хүндрэхээс өмнө эмчилгээ сувилалд хамруулах;
- Тэднийг тухайн орчин, нийгэмд нь дасгах, нөхөн сэргээх нийгмийн ажлыг явуулах,
- Эмнэлэгийн байнгын болон түр хяналтанд байдаг иргэнд тусламж үйлчилгээ үзүүлэх,
- ОХУ-ын ДЯЯ-ны байгууллагуудын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүртгэл тооцоог хөтлөх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нөхөн сэргээх, нийгмийн тусламж үйлчилгээ, амьдралын нөхцөл байдал, нийгэм, эрх зүй, эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллага, албан тушаалтанд илтгэж шийдвэрлүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой хууль, эрх зүйн хэм хэмжээний биелэлт, нийгмийн дэмжлэгийн арга хэмжээний үр дүн, тэтгэвэр, тэтгэмжийн хүрэлцээ болон тэдэнд тулгамдаж байгаа асуудалд тодруулах, шийдвэрлэх зорилгоор байгууллагын удирдлагатай жилд 2 оос доошгүй уулзалт хийх ажлыг зохион байгуулах;
- Тэдэнд шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэх хүн нэг бүрийн саналыг нийгмийн ажлын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх,
- Нийгмийн асуудлын комиссын ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд эрх зүй, нийгмийн дэмжлэг үзүүлэх ажлыг анги байгууллагын боловсон хүчин, хууль эрх зүй, эмнэлэг, санхүү, ар тал, хангалтын ажилтай уялдуулан зохицуулах<sup>83</sup>;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын нэмэлт арга хэмжээг сонирхсон байгууллага, олон нийтийн байгууллага, төв орон нутгийн цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулах,

<sup>82</sup> Социальная работа в органах внутренних дел( документы и материалы) 2007.С.10-11

<sup>83</sup> Комиссии по социальным вопросам членов семей погибших сотрудников и сотрудников инвалидами вследствие военной травмы (ранений, травм, контузий) заболеваний, полученных при исполнении служебных обязанностей, создаются в органах, подразделениях и учреждениях системы МВД России ( Социальная работа в органах внутренних дел ( документы и материалы) с.6 )

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгаалалд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор сонирхсон алба, байгууллагын хамтын ажиллагааны асуудлын хүрээнд нийгмийн асуудал эрхэлсэн комиссын хуралдаанаар авч хэлэлцэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын асуудлаар (шуурхай хуралдаан) даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэх;
- Нийгмийн ажлын үр дүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн тухай төв байгууллагын даргад илтгэх;
- Нийгмийн ажилтай холбоотой ажил, үр дүнгийн талаар тогтоосон журмын дагуу мэдээллийн хэрэгслээр сурталчилах;

ОХУ-д террористуудын эсрэг сөрөг тусгай ажиллагаанд оролцох явцдаа гавъяа байгуулж, шархадсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон алба хаагчтай холбогдсон нийгмийн хамгааллын асуудлыг улсын “Терроризмын эсрэг тэмцэх тухай” хуулиар зохицуулдаг.

**Европын холбооны ихэнх улс орнууд мөн дээрх байдлаар албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон, хөдөлмөрийн чадвараа алдсан алба хаагчийн ар гэрт төрөөс үзүүлэх нийгмийн хамгаалалтай холбоотой асуудлыг зохицуулж байгаа бөгөөд манай улсын хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага анхаарч, эрх зүйн орчин, зохион байгуулалтын арга хэмжээг авснаар төрөөс иргэд рүүгээ чиглэсэн бодлого амьдралд тусгалаа олоход бодитой дэмжлэг болох юм.**



## МОНГОЛЫН ЦАГДААГИЙН ЦОЛ, ТҮҮНИЙ УЛАМЖЛАЛ СУДЛАЛЫН АСУУДАЛ

*И.Мөнхсонор  
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн  
343-р дамжааны сонсогч*

Монгол улсад өрнөж буй эрх зүйн шинэчлэлтийн хүрээнд шинэчлэн найруулсан Цагдаагийн албаны тухай хуулийн 34-р зүйлд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий цагдаагийн алба хаагчдад цагдаагийн албан тушаалын цол олгохоор заасан нь иргэд, алба хаагчдын шүүмжлэл, талархлын аль алинтай тулгарч байна.

Иймд бид цагдаагийн албан хаагчдад цэргийн цол олгохоос татгалзаж, албан тушаалын цол олгохын ач холбогдол, эрх зүйн үр дагаврыг тодорхойлохын тулд Монголын төрийн цагдаагийн цол, түүнийг олгож байсан хууль, дүрмүүдийг судлахдаа тухайн цаг үеийн нөхцөл байдал, төрийн дэглэм, бодлого, хууль тогтоомжийн хөгжил зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан Монгол нутагт төр үүссэн цагаас хойш XIII зууны үе /Их Монгол улс оршин тогтнож байсан/, XIII зууны сүүлээс Манжийн ноёрхлын үе, Манжийн ноёрхлын түлхэн унагаж, Монгол оронд Ардын хувьсгал ялсан 1921 он хүртэлх үе, 1921 оноос 1990-ээд оны үе, ардчилал шинэчлэл өрнөсөн 1990 оноос хойшхи үе гэсэн үечлэлд хуваан судалсан болно.

### ***1.Монгол нутагт төр үүссэн цагаас хойш XIII зууны үе /Их Монгол улс оршин тогтнож байсан/***

Монгол төрийн цагдаагийн түүхэн уламжлал нь Их эзэн Чингис хааны хишигтэн цэргээс улбаатай. Энэ үед “Их засаг” хуулийн хэм хэмжээг дагаж мөрдөх, дотоодод дэг журам тогтоож, хэв журам сахиулах, хэрэг зөрчилтэй тэмцэх явдал төрийн чухал үүрэг байсан. Дотоодод дэг журам тогтоож, хэв журам хамгаалах, хэрэг зөрчилтэй тэмцэх үүргийг Чингис хааны хишигтэн цэргүүд гүйцэтгэдэг байжээ. Мөн хэрэг зөрчлийн зөв бурууг Улсын Заргач ялган шийтгэдэг байжээ. Тухайн үед Чингис хааны хишигтэн цэргүүдийг гүйцэтгэх үүргээс нь хамааруулан **Хэвтүүл, Торгууд, Хорчин, Баатар хишигтэн цэргүүд** гэж өөрөөр нэрлэдэг байжээ.

- **Хэвтүүл цэргийн гол үүрэг нь** шөнийн манаач бөгөөд шөнө хааны ордны үүд сахиж, ордны өмнө хойгуур явах хүнийг барих, шөнө хааны ордонд нэвтрэх хүнийг саатуулан барих, хэрэв хаанд яаралтай хэл дуулгах хүн байвал дамжуулах, хэвтүүлийн тоог асууж сонирхвол тэр хүнийг алах, хааны ордон нүүж буудаллахад нутаг ус үзэж, нүүдэл тээвэрлэлтийг хамгаалах, хааныг дагаж ан гөрөө авлахад нь

хамгаалах, хааны ордны зэр зэвсгийг төвхнүүлж, өгч, авах зэргийг хариуцан гүйцэтгэдэг байжээ.

- **Торгууд цэргийн үүрэг нь** өдрийн харуул бөгөөд 8000 цэрэг байдаг ба мянга мянгаараа хуваагдан найман ахлагчид захирагддаг бөгөөд өдрийн цагаар Чингис хааныг хамгаалах, хэв журмыг сахиулах, хэрэг зөрчилтэй тэмцэх үүргийг гүйцэтгэдэг байв.
- **Хорчин цэргийн үүрэг нь** хор агсагч цэрэг бөгөөд байлдааны зэр зэвсгийг эзэмшин хэрэглэх үүрэгтэй байжээ.
- **Баатар цэрэг нь** дайн байлдааны тусгай цэрэг байв.<sup>84</sup>

## **2. XIII зууны сүүлчээс Манжийн ноёрхлын үе**

Хубилай хааны байгуулсан Юан гүрэнд төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг, нарийн бүтэц, зохион байгуулалт бүхий төрийн яамдууд ажилладаг байв. Тухайлбал, хэв журам сахиулах, хэрэг зөрчилтэй тэмцэх чиг үүрэг бүхий баруун, зүүн этгээдийг манаж цагдах яамыг байгуулан ажиллуулж, энэхүү яаманд ажиллагсад нь:

- **Сахиж номхотгох түшмэл,**
- **Цааз хянагч түшмэл,**
- **Хэрэг бүртгэгч түшмэл,**
- **Хулгай барих түшмэл,**
- **Гэмт хэрэг мэдэгч дэс түшмэл** зэрэг цол, зэрэг дэвтэйгээр ажилладаг байжээ.<sup>85</sup>

Их хаадын үед “Их Засаг” хуулийг хуулийн иш үндэс болгон хэв журам сахиулах, хэрэг зөрчилтэй тэмцэх ажлыг урьдын адил хишигтэн цэргийн хэвтүүл, торгууд, баатрууд, хорчин, захирагч түшмэл, засаг ноёдууд, түшмэдүүдийн хүчээр цагдан сэргийлж, хэрэгжүүлэх үйл ажиллагаа явагдаж байсан. Харин бага хаадын үед хэв журам сахиулах, хэрэг зөрчилтэй тэмцэх тусгайлсан байгууллага байгаагүй бөгөөд цэрэг, жанжнууд, ноёд түшмэд, заргач шүүгч нар энэхүү чиг үүргийг гүйцэтгэж иржээ. Ингэж бага хаадын үед Их эзэн Чингис хааны байгуулж, Их Монгол Улсын сүр хүчийг илтгэж байсан **хишигтэн, хэвтүүл, хорчин** зэрэг цэрэг байхгүй болж, **бага хаадын дэргэд 33 өрлөгтөн, 61 хийртэн зэрэг бараа бологсод, амь сахигчид бий болж, ноёдын хиа, түшмэдүүд нь хэв журам сахиулах гол хүч болж байжээ.**

220 гаруй жил Монгол орон Манж Чин улсын дарлал, мөлжлөгт байсан нь түүхийн хуудаснаа хараар тэмдэглэгдэн үлдсэн. Энэ үед Манжийн хааны зарлигаар томилогдсон сайд жанжин, цагдаа, цэрэг хэв журам сахиулах, хэрэг зөрчилтэй тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байсан.

Манж Чин улсын хаан

- **Цагдаа харуул**
- **Суман харуул**
- **Гэрийн харуул**
- **Дотуур харуул** гэсэн албан тушаалуудыг бий болгож, эдгээр нь тус тусдаа чиг үүрэг гүйцэтгэдэг байсан. Тухайлбал, цагдаа, суман, гэр харуулууд нь монголчуудыг Оростой харилцахыг хориглож цагдах, харин дотуур харуул нь хятадын худалдаачдыг хил хязгаар, харуулын нутаг дэвсгэрт нэвтрэн орохыг хориглох чиг үүрэгтэй байжээ.

Цагдаа гэдэг нэр томъёо нь 1727 онд бий болсон бөгөөд ариун, цагаан гэсэн утгыг агуулж, ёс, харьцаа сэтгэл тэргүүтэнг ёс журамтай болгох, ёсоор нь дэглэх үүрэгтэй, зэрэг

<sup>84</sup> А.Думбурай. Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжилт. УБ., 1999. 18 дахь тал

<sup>85</sup> А.Думбурай. Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжилт. УБ., 1999. 25 дахь тал

байлгахад үйлчилдэг хийгээд цагаан зүгийн тэнгэрийн зарлиг, тааллыг **ЦАГДАА** хэмээжээ.<sup>86</sup>

### **3.Манжийн ноёрхлын түлхэн унагаж, Монгол оронд Ардын хувьсгал ялсан 1921 он хүртэлх үе**

**Монголын Цагдаагийн байгууллагын үндэс суурь нь Богд хаант засгийн үед анх тавигдсан гэж үзэж болно.** Тухайлбал, 18-р зууны үед Богд хааны зарлигаар тусгай түшмэдүүд томилон Их хүрээнд хэв журам сахиулах арга хэмжээг авахдаа Их хүрээний газрыг төвөөс нь тал бүр тийш 3 хувааж тус бүрд нь 60 алдыг нэгэн газар болгож хуваагаад газар бүрд тусгай пайз хатгаж, овоо тэмдэг босгон эдгээр 15 газрыг аймгуудад хариуцуулж, аймаг тус бүр тусдаа өрхийн цагдааг ажиллуулах журам гарч **“Арван тавны цагдаа”** бий болжээ.

“Арван тавны цагдаа” нь хуваарьт газраа сэргийлэн хамгаалах, хэрмэл цагаачин хүмүүсийг нутагт нь буцаах, хулгай дээрэм зэрэг гэмт хэрэг өдүүлэгчдийг илрүүлэн эрхлэх газарт нь хүргэх үүргийг гүйцэтгэж байжээ.

1920 оны “Хүрээний цагдан цээрлүүлэх хорооны тухай дүрэм”-д хүрээний цагдан сэргийлэх хорооны алба хаагчид:

- Цагдагч дарга,
- Дэд цагдагч,
- Цагдагч тэргүүн цэрэг,
- Цагдагч хуяг,
- Тусгай цагдагч,
- Жинхэнэ цэрэг,
- Дэсэлсэн цэрэг гэсэн тушаал дээр ажилладаг байжээ.<sup>87</sup>

### **4.1921 оноос 1990-ээд оны үе**

1921 онд Ардын хувьсгал ялснаар шинэ тогтсон хувьсгалт хэв журам, энх амгалан байдлыг сахиулах үүрэг бүхий **“Сэргийлэх цэрэг”-ийн салааг** 1921 оны 07-р сарын 19-нд байгуулснаар цагдан сэргийлэх байгууллагын үндэс тавигдсан.

Улмаар Улсын Цагдан Сэргийлэх Ерөнхий газар байгуулагдаж, нийгмийн хэв журам сахиулж, гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг гүйцэтгэж эхэлсэн. Тухайн үед УЦСЕГ нь эрхэлсэн дарга, Комиссар, нарийн бичгийн дарга, хэлтэс эрхэлсэн түшмэл, туслах түшмэл, орчуулагч, гянданы эрхлэгч, гянданы хуяг, сумангийн дарга, салааны дарга, цагдаа нарын дарга, морьт цагдаа, явган цагдаа гэсэн орон тоотойгоор ажиллаж байв.<sup>88</sup> Тухайн үед сэргийлэх цэргийн алба хаагчдад **энхжүүлэгч, төвхнүүлэгч** гэсэн цол олгож байсан ба 1930-аад оны сүүлчээр буюу одоогийн хэрэглэж байгаа буюу цагдаагийн дэд ахлагч, ахлагч, ахлах ахлагч, дэслэгч, ахлах дэслэгч, ахмад, хошууч, дэд хурандаа, хурандаа гэх цолонд шилжсэн бөгөөд энэ үед бага дэслэгч хэмээх цол хэрэглэгдэж байсан ба 1993 оны Цагдаагийн байгууллагын тухай хуульд цагдаагийн албан хаагчийн цол хуульчлагдахдаа бага дэслэгч цолыг хассан байна.

### **5.Ардчилал шинэчлэл өрнөсөн 1990 оноос хойшхи үе**

1993 оны Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуульд цагдаагийн цолыг тодорхой зааж өгсөн бөгөөд 1995 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн 222 дугаартай зарлигаар “Цагдаагийн цол олгох журам”-ыг баталсан.

<sup>86</sup> МУИС-ийн Монгол хэл соёлын сургуулийн зөвлөх багш, доктор /Sc.D/, профессор Г.Гантогтохын судалгаа

<sup>87</sup> Д.Таванжин. Монголын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт түүний хөгжилт. УБ., 2000. 23 дахь тал

<sup>88</sup> Т.Гомбодаш. Монгол төрийн цагдаагийн түүхэн лавлагаа, тодотгол, судалгааны эх бичгүүдийн хураангуй. УБ.,2006. 58 дахь тал



1993 оны Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 31-р зүйлд “**Цагдаагийн алба хаагчийн албан тушаал, алба хаасан хугацаа, ажлын бүтээлийг харгалзан:**

- Сонсогч,
- Түрүүч,
- Цагдаагийн дэд ахлагч,
- Цагдаагийн ахлагч,
- Цагдаагийн ахлах ахлагч,
- Цагдаагийн дэслэгч,
- Цагдаагийн ахлах дэслэгч,
- Цагдаагийн ахмад,
- Цагдаагийн хошууч,
- Цагдаагийн дэд хурандаа цол олгохоор заасан.

Мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Цагдаагийн удирдах албан тушаалтанд цэргийн дээд цол олгож болно” гэж заасан нь Цагдаагийн төв байгууллагын даргад генерал цол олгох эрх зүйн үндэслэлийг бүрдүүлж өгсөн.

1995 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн 222 дугаартай зарлигаар батлагдсан “Цагдаагийн цол олгох журам”-д цагдаагийн алба хаагчид:

- Цагдаагийн дэд ахлагчаас цагдаагийн ахлагч 5 жил,
- Цагдаагийн ахлагчаас цагдаагийн ахлах ахлагч 5 жил,
- Цагдаагийн дэслэгчээс цагдаагийн ахлах дэслэгч 3 жил,
- Цагдаагийн ахлах дэслэгчээс цагдаагийн ахмад 3 жил,
- Цагдаагийн ахмадаас цагдаагийн хошууч 4 жил,
- Цагдаагийн хошуучаас цагдаагийн дэд хурандаа 5 жил,
- Цагдаагийн дэд хурандаагаас цагдаагийн хурандаа 6 жил хугацаагаар цагдаагийн цол олгохоор заасан.

2013 онд Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд батлагдсан Цагдаагийн албаны тухай хуульд цагдаагийн алба хаагчид албан тушаалын цол олгохоор хуульчилсан. Тухайлбал,

**Дээд цол:** **Тэргүүн комиссар** - цагдаагийн төв байгууллагын даргад

**Тэргүүн дэд комиссар** - цагдаагийн төв байгууллагын тэргүүн дэд даргад

**Дэд комиссар** - цагдаагийн төв байгууллагын дэд даргад

**Туслах комиссар** - цагдаагийн төв байгууллагын албаны даргад

**Ахлах цол:** **Цагдаагийн хурандаа** - цагдаагийн төв байгууллагын бүтцийн нэгжийн дарга болон нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга, тэдгээртэй адилтгах удирдах албан тушаалтанд

**Цагдаагийн дэд хурандаа** - харьяа алба, нэгжийн дарга, тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн хэлтсийн дарга, тэдгээртэй адилтгах удирдах албан тушаалтанд

**Цагдаагийн хошууч** - тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн хэлтсийн тасгийн дарга, түүнтэй адилтгах бусад албан тушаалтанд

Хотын цагдаагийн байгууллагын даргад **туслах комиссар** цол олгож болно.

Цагдаагийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх гадаад, дотоодын сургуульд суралцаж байгаа иргэнд цагдаагийн **сонсогч** цол олгож болно.

**Дүнд цол:** Цагдаагийн ахмад, цагдаагийн ахлах дэслэгч, цагдаагийн дэслэгч

**Бага цол:** Цагдаагийн ахлах ахлагч, цагдаагийн ахлагч, цагдаагийн дэд ахлагч гэсэн цолууд орно.<sup>89</sup>

Цагдаагийн байгууллагад хэрэглэж байсан цолны асуудлыг авч үзэхэд нийгмийн тодорхой үеүдэд гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журам сахиулах чиг үүрэг бүхий алба хаагчдад

<sup>89</sup> [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) “Цагдаагийн албаны тухай хууль” /Шинэчилсэн найруулга/

албаны онцлогийг илэрхийлсэн, эрхэлж буй албан тушаал, ажлын үр дүнг харгалзан тодорхой цол, зэрэг дэв, хэргэмийг олгож иржээ.

Цагдаагийн алба хаагчийн цол нь цагдаагийн алба хаагч өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа явуулах, захирах, захирагдах ёс, бие биеэ хүндлэх, нөгөө талаас иргэдтэй харьцах харилцаанд гол үүргийг гүйцэтгэдэг бөгөөд төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагад зайлшгүй байх ёстой зүйл билээ.

Гэвч цолоор цагдаагийн алба хаагчид бие биеэ дарамтлах, дорд үзэх, иргэдийг цолоор айлгаж, сүрдүүлж, дарамтлах, цагдаагийн албан хаагчид цолыг авахын төлөө танил тал ашиглах, авлига өгөх, цол олгох журмыг зөрчих, гэмт хэрэгтэй тэмцэх шууд үүрэггүй албан тушаалтан цол хэрэглэх зэрэг сөрөг хандлагууд ажиглагдаж, улмаар цагдаагийн байгууллага хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, Нэгэн цагдаагийн тасгийн дарга хошууч цолтой, түүний удирдлагад ажилладаг ахлах ажилтан дэд хурандаа цолтой тул захирах, захирагдах ёсны зарчим зөрчиж, даргын өгсөн хууль ёсны тушаалыг эсэргүүцэж, цолоороо түүнийг дарамтлах гэж оролдон үл ойлголцох байдал гарсан.<sup>90</sup>

Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд батлагдсан Цагдаагийн албаны тухай хуульд цагдаагийн албан хаагчдад цагдаагийн албан тушаалын цол олгохоор заасан тул энэ мэт асуудал гарахгүй гэж үзэж болно. Учир нь тасгийн дарга хошууч, тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн хэлтсийн дарга дэд хурандаа, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга хурандаа цолтой байх, тухайн цагдаагийн алба хаагч албан тушаал буурсан тохиолдолд цол мөн адил буурах, албан тушаал ахисан тохиолдолд цол дэвших, тухайн цагдаагийн хэлтэст зөвхөн тасгийн дарга нар хошууч цолтой байх юм.

**Цагдаагийн алба хаагчдын цол албан тушаалаас шалтгаалдаг болсноор ажлын бүтээмж дээшлэх, цолны төлөө ажиллах, өрсөлдөх бус зөвхөн хүний эрхийг хангах, хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэх нөхцөл бүрдэх, иргэдтэй харьцах хандлага өөрчлөгдөх, ажил үүргийн давхцал арилах, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанар, шуурхай байдал сайжрах, цолыг ашиглаж хууль бус үйл ажиллагаа явуулах зэрэг байдал үгүй болох, ингэснээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа шинэ түвшинд гарах, олон улсын жишигт нийцэх юм.**

---

<sup>90</sup> УИХ, Засгийн газрын гишүүн, Хууль зүйн сайд Х.Тэмүүжингийн сэтгүүлчидтэй хийсэн уулзалтын үеэр хийсэн мэдээллээс

## **ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ**

*Сорокин Михаил Владимирович,  
Владимирский юридический институт ФСИН России,  
преподаватель кафедры уголовно-исполнительного права  
sorokinmike@mail.ru*

### **ПРОБЛЕМЫ ОБОРУДОВАНИЯ ОБЪЕКТОВ УИС СИСТЕМАМИ НЕЛЕТАЛЬНОГО ЭЛЕКТРОШОКОВОГО ВОЗДЕЙСТВИЯ**

В соответствии с распоряжением Правительства Российской Федерации от 14 октября 2010 г. № 1772-р «Об утверждении Концепции развития уголовно-исполнительной системы Российской Федерации до 2020 года» предлагается создание системы противодействия преступному поведению осужденных на основе применения современных инженерно-технических средств охраны и надзора, использование новых технологий и подходов к организации безопасности объектов уголовно-исполнительной системы, а также формирования единой технической политики в области их оснащения комплексами инженерно-технических средств охраны и надзора (далее – ИТСОН)<sup>91</sup>.

Учитывая современное состояние комплекса ИТСОН, состоящего на вооружении УИС и его неспособность обеспечить необходимые условия для гарантированного задержания подозреваемых, обвиняемых или осужденных совершающих покушения на побег из-под охраны, перед ФСИН России назрела необходимость принципиального изменения отношения к оборудованию запретных зон охраняемых объектов. Кроме того, о такой необходимости свидетельствует и анализ побеговой активности лиц, отбывающих наказания в виде лишения свободы и содержащихся под стражей.

За 3 квартала 2012 г. было совершено 7 побегов из-под охраны, в том числе 1 групповой (АП 2011 г. – 4/0). При анализе способов совершения побегов, можно сделать вывод, что более 57% из них были совершены путем преодоления различными способами внутренней и внешней зоны исправительного учреждения.

О необходимости модернизации и оптимизации оборудования ИТСОН объектов УИС свидетельствует и анализ допущенных покушений на побег. В течении 3-х кварталов 2012 г. было совершено 23 попытки побега из-под охраны, в том числе 6 групповых. Способом совершения 65%, из них, являлись попытки преодоления основного ограждения (АП 2011 г. – 14 покушений)<sup>92</sup>.

Приведенные статистические данные свидетельствуют о наметившейся отрицательной тенденции и характеризуют криминальные процессы происходящие в среде лиц, содержащихся в исправительных учреждениях и местах содержания под стражей, что вызывает особую озабоченность центрального аппарата ФСИН России.

В этой связи, в настоящее время проводятся мероприятия по строительству и реконструкции инженерных ограждений запретных зон. План реализации Концепции включает в себя, оборудование учреждений двумя линиями ограждений высотой не менее 6 метров с использованием современных материалов (железобетон, металлопрофиль, сетчатое (решетчатое) заполнение), с противопобеговым устройством по верху основного ограждения типа «Бочка». Данные ограждения должны обеспечивать

<sup>91</sup> Концепция развития уголовно-исполнительной системы Российской Федерации до 2020 г.: Утверждена распоряжением Правительства РФ от 14 октября 2010 г. № 1772-р // Собрание законодательства РФ. 2010. № 43. Ст. 5544.

<sup>92</sup> Обзор ФСИН России от 23.03.2012 г. № 9-5306-08 «О состоянии надежности охраны исправительных учреждений и следственных изоляторов в 2011 году и мерах по ее совершенствованию».

не только длительное по времени их преодоление, но и задержку нарушителя вплоть до полного отказа от намерений совершить побег из-под охраны. При этом существенную роль играет психологическое воздействие, которое может оказать на потенциального нарушителя как видимая трудность преодоления ограждений, так и реальная возможность получения им различных травм и повреждений<sup>93</sup>.

Необходимо отметить, что оборудование предупредительного ограждения высотой не менее 5,5 метров выполняется из оцинкованной металлической плетеной сетки. Однако для осложнения преодоления и задержания преступника во внутренней запретной зоне мы предлагаем в качестве предупредительного заграждения использовать плоское колючее заграждение (далее – ПКЗ). Основу ПКЗ составляет полотно из армированной колючей ленты, скреплённой особым образом для получения ромбовидных ячеек. ПКЗ относится к агрессивным типам заграждений и предназначено для внутренних территорий объекта. Они считаются труднопреодолимыми препятствиями, кроме того плоские колючие заграждения сложно разрушить простым слесарным инструментом, поскольку они обладают высокой прочностью на разрыв и перекус. Времени на их преодоление требуется больше, чем в случае с сетчатыми ограждениями и его вполне достаточно для организации ответных действий со стороны личного состава караула подразделения охраны и резервной группы дежурной смены.

При рассмотрении вопроса о техническом обеспечении безопасности учреждений УИС России мы считаем, что заслуживает особого внимания положительный опыт применения электризуемых заграждений при осуществлении охраны пенитенциарных учреждений зарубежных стран.

По периметру учреждений ряда зарубежных стран устанавливаются активные рубежи защиты с применением заграждений из проводов и подачей по ним напряжения смертельного или не смертельного номинала. Применение электризуемых заграждений разрешено законодательством Франции, Германии, Израиля, ряда штатов США и некоторых других стран<sup>94</sup>.

Одним из путей решения вопроса повышения надежности охраны исправительных учреждений России, могло бы стать внедрение противопобеговых электризуемых заграждений отталкивающего действия. Важной предпосылкой допустимости их применения должно послужить то обстоятельство, что современные заграждения этого типа функционируют на принципе отталкивания, а не поражения нарушителя, пытающегося совершить побег из-под охраны.

В нашей стране до начала 90-х годов XX века в практике деятельности внутренних войск МВД России для надежности изоляции осужденных и снижения побеговой активности успешно применялись в качестве опытных образцов противопобеговые электризуемые заграждения типа «Кактус». За время опытной эксплуатации они показали высокую эффективность за счет причинения осужденному, пытающемуся незаконно нарушить установленные рубежи охраны, неопасного в целом для его здоровья кратковременного шокирующего электрического воздействия в момент контакта с указанным техническим устройством. Данная система являлась, практически непреодолимой без использования подручных средств, а также при совершении одиночных побегов осужденных. Поскольку возможности и условия использования таких средств регулировались на уровне только подзаконных актов, то сама практика применения их являлась нарушением законности. Анализ норм, содержащихся в ведомственных нормативных правовых актах того периода, свидетельствует о том, что данные типы заграждений не охватывались условиями их применения, не носили четкого

<sup>93</sup> Актуальные проблемы деятельности подразделений УИС. В 2 т. Т. 1.: сборник материалов открытой Всероссийской научно-практической конференции / ФКОУ ВПО Воронежский институт ФСИН России. – изд. Полиграфия, 2011. С. 45.

<sup>94</sup> Пантелеев В.А. Предупреждение и пресечение кризисных ситуаций в пенитенциарных системах зарубежных стран: Учеб. пособие / ВЮИ Минюста России. Владимир, 2005. С. 20.

выраженного характера и механизма их применения. В этой связи системы «Кактус» не получили своего практического полного внедрения<sup>95</sup>.

В целях повышения надежности охраны исправительных учреждений представляется целесообразным рассмотреть вопрос о возможности оборудования объектов УИС электризуемыми ограждениями отталкивающего действия и создания правовой базы их применения.

В этой связи заслуживает особого внимания разработка российских ученых «Система нелетального электрошокового воздействия» (далее – СНЭВ). Охранно-защитная система (комплекс) «СНЭВ» основывается на сертифицированном, согласно российским государственным и ведомственным стандартам, защитном электрошоковом устройстве (далее – ЗЭШУ) отечественного производства нелетального действия «ОХРА-О».

Система «СНЭВ» квалифицирована как техническое средство охраны, предназначенное для предотвращения несанкционированного прохода нарушителя через запретную зону периметра охраняемого объекта, проникновения на объект (в помещение, сооружение и коммуникации).

От аналогичных систем зарубежного и отечественного производства, данная система отличается тем, что электрический заряд оказывает воздействие на правонарушителя даже в том случае, если он изолирован от земли диэлектриком или находится в воздухе.

Работа системы основана на процессах, аналогичных происходящим в конденсаторе, в роли которого выступает человек. В результате воздействия «СНЭВ» нарушитель в течение определенного времени не в состоянии осуществлять осмысленные действия. Мощность системы не превышает 2 Вт при допустимых 4 Вт по российскому ГОСТу. Данная система полностью отвечает всем современным требованиям как по эффективности решения задач по охране исправительных учреждений, так и по вопросам обеспечения безопасности ее применения.

По нашему мнению, для применения в учреждениях УИС России, наиболее подходит комплекс «МАХАОН-СНЭВ». Принцип действия высокоэффективного физического барьера, данного комплекса основан на безопасном электрошоковом воздействии высоковольтными импульсами по однополюсной схеме, путем перезарядки емкости тела.

Комплекс «МАХАОН-СНЭВ» активно препятствует попыткам проникновения на охраняемый объект и физического воздействия на него при прикосновении или приближении к электризуемому элементу на расстояние до 15мм.

Характер электрического воздействия на организм человека обладает отталкивающим свойством, основанным на естественной рефлекторной реакции живого организма, вынуждающей нарушителя отказаться от противоправных действий.

Комплекс соответствует действующим стандартам, отвечает современным требованиям к средствам безопасности и принципиально отличается от применяемых в отечественной и зарубежной практике пенитенциарных учреждений.

Воздействие системы безопасно, но крайне неприятно и болезненно. При этом защитная диэлектрическая одежда, обувь и перчатки не способны защитить человека от высоковольтного удара электрическим током.

Мы считаем, что тактико-технические характеристики системы оптимальны для использования ее при оборудовании предупредительных ограждений запретных зон охраняемых объектов УИС. Кроме того, учитывая тот факт, что работы по реконструкции и переоборудованию ограждений периметров исправительных учреждений требует

---

<sup>95</sup> Актуальные проблемы деятельности подразделений УИС. В 2 т. Т. 1.: сборник материалов открытой Всероссийской научно-практической конференции / ФКОУ ВПО Воронежский институт ФСИН России. – изд. Полиграфия, 2011. С. 47.

большого финансового обеспечения, считаем целесообразным, рассмотреть вопрос по оборудованию СНЭВ нулевых рубежей обнаружения внутренних зон действующих исправительных учреждений. Данная мера позволит пресекать покушения на побег на первоначальной стадии совершения данного преступного деяния.

Однако, также, необходимо отметить, что при принятии положительного решения о постановке данных систем на вооружение ФСИН России возникнет необходимость переработки ряда нормативных правовых актов в сфере исполнения уголовных наказаний и меры пресечения в виде содержания под стражей.

Так, например, в настоящее время существует ситуация, когда применение того или иного вида инженерно-технического средства установлено ведомственным нормативным правовым актом, но не определено законом. Это относится к инженерно-техническим средствам охраны. В ст. 83 Уголовно-исполнительного кодекса РФ не регламентируется возможность применения администрацией исправительного учреждения ИТСО и уделено внимание только техническим средствам надзора и контроля, отсутствуют нормы, разрешающие использование в охране и надзоре инженерных средств.

#### Список литературы

- Актуальные проблемы деятельности подразделений УИС. В 2 т. Т. 1.: сборник материалов открытой Всероссийской научно-практической конференции / ФКОУ ВПО Воронежский институт ФСИН России. – изд. Полиграфия, 2011.
- Концепция развития уголовно-исполнительной системы Российской Федерации до 2020 г.: Утверждена распоряжением Правительства РФ от 14 октября 2010 г. № 1772-р // Собрание законодательства РФ. 2010. № 43. Ст. 5544.
- Обзор ФСИН России от 23.03.2012 г. № 9-5306-08 «О состоянии надежности охраны исправительных учреждений и следственных изоляторов в 2011 году и мерах по ее совершенствованию».
- Пантелеев В.А. Предупреждение и пресечение кризисных ситуаций в пенитенциарных системах зарубежных стран: Учеб. пособие / ВЮИ Минюста России. Владимир, 2005.

## ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

### МОНГОЛ УЛСЫН ШҮҮХ ЭРХ МЭДЭЛ ДЭХ ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ТОГТОЛЦОО ҮНДСЭН ХУУЛИЙГ ТАЙЛБАРЛАХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД

Г.Давааням  
Нагоягийн Их сургуулийн магистрант  
Б.Содномдаржаа  
Хуульчдийн холбооны судалгаа,  
шинжилгээ хариуцласан мэргэжилтэн

#### Нэг. УДИРТГАЛ ХЭСЭГ

##### 1.1.Шударга шүүхээр шүүлгэх эрх

Монгол Улсын Үндсэн хуулийн 16.14 “...шударга шүүхээр шүүлгэх...эрхтэй”, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын<sup>96</sup> 10 дугаар зүйлд “Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр тэгш байдлын үндсэн дээр нээлтэй, **шударгаар шүүлгэх эрхтэй**”, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын<sup>97</sup> 14 дүгээр зүйлийн 1-д “...Хүн бүр өөрт тулгасан эрүүгийн аливаа ялыг авч хэлэлцэхэд буюу иргэний ямар нэг байцаан шийтгэх ажиллагаанд эрх үүргийг нь тодорхойлоход хуулийн дагуу байгуулагдсан, эрх мэдэл бүхий, бусдын нөлөөнд автагдаагүй гагцхүү хуульд захирагдах шүүхээр хэргээ нээлттэй, **шударгаар шүүлгэх эрхтэй**” хэмээн хүний салшгүй эрх байхаар тунхагласан байна.

Шударга шүүхээр шүүлгэх үндсэн хуулийн зарчмыг судлаачид дараах агуулгаар тайлбарладаг **Х.Тэмүүжин** “...Өөрийн холбогдсон болон сонирхсон хэрэг маргааныг “шударга шүүхээр шүүлгэх эрх” бол хүний эр, эрх чөлөө, нэр төр, хууль ёсны ашиг сонирхлыг төрийн байгууллага, албан тушаалтан, нийгмийн алива хүчний зүгээс дур зоргоороо халдан эвдэхээс хамгаалах төдийгүй нөгөөтэйгүүр энэ эрх нь **шүүх эрх мэдлийн байгууллагын хууль бус үйл ажиллагаанаас**, шударга бус хууль тогтоомжоос иргэдийг хамгаалах эрх зүйн үндсэн механизм болох бөгөөд товчоор хэлбэл шударга шүүхээр шүүлгэх эрхийн агуулга нь хүний эрхийг төр, хуулийн зүй бус халдлагаас баталгаатай хамгаалахад оршино...”<sup>98</sup>, **Г.Совд** “Шударга шүүхийн үйл ажиллагааны зарчим нь аливаад алагчлалгүй, шударга шийдвэр гаргах хоёрын нийлбэрээр хэмжигдэнэ. Алагчлалгүй хандах гэдэг бол хууль шүүхийн өмнө адил тэгш байх Үндсэн хуулийн зарчмыг хангадаг...Шударга шийдвэр...шүүхээс хэрэг маргааныг хянаж үзээд эцэслэн шийдвэрлэхдээ хүн бүрийн үйлдсэн зөрчлийн нийгмийн хор аюулын шинж чанар, учруулсан хохирлын хэмжээ, үйлдлээ хэрэгжүүлсэн арга, гэм буруугийн хэлбэр, хариуцлагыг хөнгөрүүлэх буюу хүндрүүлэх талаархи хуулийн заалт, хэрэгт холбогдсон хүний хувийн байдал зэргийг бүх талаас нь дүгнэж хүн бүрт ялгамжтай хандах явдал юм...”<sup>99</sup>, **Б.Чимид** “...Шударга шүүх байхын эрх зүйн үндэс нь шүүх эрх мэдлийн үндсэн зарчмууд бөгөөд ...“анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчийг хуульд заасан журмын дагуу оролцуулах” ...”<sup>100</sup> нь шүүх эрх мэдлийн үндсэн зарчим хэмээн үзсэн байдаг.

<sup>96</sup> НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 217А(III) тогтоол, НҮБ-ын баримт бичиг А/810 АТ 71(1948)

<sup>97</sup> Монгол улс 1968 онд гарын үсэг зурж, 1974.11.18-ны өдөр соёрхон баталсан.

<sup>98</sup> Х.Тэмүүжин. “Jus Frast буюу Ёст үг”.УБ., 2004. 94 дэх тал

<sup>99</sup> Г.Совд. Монгол Улсын Үндсэн хууль хүний эрх /харьцуулсан эрх зүй/.УБ., 1999. 84-85 дахь тал.

<sup>100</sup> Б.Чимид. “Хууль Дээдлэх ёсыг хангадаг шударга шүүхийн үүрэг” ҮНДСЭН ХУУЛЬТ ЁС БА ҮНДЭСНИЙ ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО олон улсын симпозиум II. УБ., 2009 он. 28 дахь тал.

Өөрөө хэлбэл шударга шүүх гэдэг нь төвийг сахисан, ил тод, нээлттэй шүүн таслах ажиллагааны баталгааны тухай агуулгыг багтаах ба шууд болон шууд бус нөлөөлөл, дарамт, сүрдүүлэг, хэлэлцээр үл орших тухай ойлголтыг илэрхийлэхээр<sup>101</sup> байна.

Иргэн шүүх бүрэлдэхүүнд орж хэрэг маргаан шийдвэрлэх явцад оролцох нь шүүхийн ил тод, нээлттэй байх зарчимд бүрэн нийцэж, шүүхийн шүүн таслах ажиллагаанд олон нийтийн хяналтыг тогтоож, шүүхээс шударга шийдвэр гарах үндсэн механизм болох учиртай. Энэ талаар судлаач Х.Тэмүүжин шүүхийн шүүгчийн хараат бус байдлаар хамгаалагдсан шүүгчид гагцхүү хуульд захирагдан иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг ханган ажиллаж буйг ил тод харуулан иргэдийн итгэлийг бэхжүүлэх, нөгөө талаар шүүн таслах ажиллагааг хариуцлагажуулахад чухал ач холбогдолтой шударга ёсонд нийцсэн механизм бол иргэдийн төлөөлөгчийн шүүх бүрэлдэхүүн дэх оролцоо хэмээн дүгнэсэн нь бий.

Шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгч оролцохын ач холбогдлыг дэлхийн улс орнуудад “маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд олон янзын мэдлэг, туршлага бүхий иргэн оролцооноор илүү сайн хянан шийдвэрлэх ажиллагаа явагдана, иргэн, шүүгч хоёрын эрх мэдлийн хуваарилалтыг сайн хийж өгсөнөөр хамтын шийдвэр гаргах зарчим илүү үр дүнтэй хэрэгжинэ”<sup>102</sup> гэх хандлага хүчтэй хөгжсөн байна.

### **1.2.Шүүх дэх иргэдийн оролцоо, төрөл**

Шүүхэд иргэдийн оролцоог дэлхийн ихэнх улс орнуудад дараах 2 аргаар оролцуулж байна. Нийтийн эрх зүйн системтэй Англи, Америк, Австрали, Канад, Шинэ Зеланд зэрэг орнуудын тангаргатны шүүхийн (jury system), эх газрын (иргэний) эрх зүйн системтэй Герман, Франц, Итали, зэрэг орнуудын мэргэжлийн бус шүүгч (lay judge) шүүх бүрэлдэхүүнд оролцдог үндсэн хоёр хэлбэр байна.

Дээрх хоёр хэлбэрийг хослуулан хэрэглэдэг Дани, Норвеги зэрэг орнууд, тангаргатны шүүхийн (jury system), мөн 2008, 2009 оноос харьцуулсан судалгаанд суурилж мэргэжлийн бус шүүхийн (lay judge)-ийн зарим нэг шинжийг уялдуулах байдлаар хэрэглэж буй Солонгос, Япон (хэрэглэж байсан) зэрэг өвөрмөц чиг хандлагууд ч бий болжээ.

**Тангаргатны шүүхийн (jury system) талаархи үндсэн ойлголт:** Тангаргатны шүүх (jury system) гэдэг бол иргэдээс бүрдсэн тангаргатны шүүгчид, мэргэжлийн шүүгчээ хараат бусаар маргааныг хянан шийдвэрлэх тогтолцоо юм<sup>103</sup>. Энэхүү тогтолцоо нь цаг хугацаа, зардал нэлээд зарцуулдаг, хуулийн мэдлэггүй иргэн өөрийн дотоод ухамсараар буруу шийдвэр гаргах эрсдэлтэй зэрэг дутагдалтай талуудтай.<sup>104</sup>

Англи, Америк улсын шүүх дахь иргэдийн оролцоо “jury system”: Энэ хэлбэр нь Англид анх үүссэн гэж үздэг. Улмаар 17-р зууны үеэс Америк тангаргатны шүүхийн систем (jury system) хэрэгжүүлж эхэлсэн. Өнөөдөр шүүх дахь иргэдийн оролцооны хамгийн хүчтэй хэлбэрийг өргөн хүрээнд хэрэгжүүлж буй улс Америк болжээ. Энэхүү тогтолцоог хэрэгжүүлэх эрх зүйн үндэс нь мужуудын Үндсэн хуулийн түвшинд баталгаажсан байдаг бөгөөд үүгээрээ иргэний эрх зүйн системтэй Герман, Франц, Итали зэрэг орнуудаас ялгарах юм. *Хүснэгт №2-оос тодорхой харна уу*

<sup>101</sup> Хөвсгөл аймгийн шүүхийн шүүгч Нямын Мөнхөө <http://www.court.khs.gov.mn/index.php/fag/aimgiin-shuuhiiin-tailan/68-esse> “Шударга шүүх, хараат бус байдлын талаарх ойлголт нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлд үндэслэн бий болдог тухай судлаачид өгүүлсэн байна”

<sup>102</sup> Сэризава Хитоши, “Шинэ Үндсэн хуулийн тайлбар” - 芹沢 齊、「新基本法コメンタール憲法」（日本評論社）pp 407-408,

<sup>103</sup> Зарчмын хувьд ялтан сонгох эрх эдлэнэ.

<sup>104</sup> Lee Eun Mo, “Солонгос улсын иргэдийн шүүх дэх оролцооны тогтолцооны агуулга, асуудал, Японы мэргэжлийн бус шүүгчийн тогтолцоотой харьцуулан авч үзэв” - 李銀模、『韓国の国民参与裁判制度の内容と問題点』 「日本の裁判員制度との比較を中心に」 （2009年）p65



## **Мэргэжлийн бус шүүгч (lay judge) шүүх бүрэлдэхүүнд оролцуулах тогтолцооны үндсэн ойлголт<sup>105</sup>**

Мэргэжлийн бус шүүгч (lay judge) шүүх бүрэлдэхүүнд оролцуулах гэдэг бол иргэд мэргэжлийн шүүгчтэй хамт шүүх ажиллагаанд оролцож, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль зүйн болон үйл баримтын үнэлгээг хэрэгжүүлэх тогтолцоо юм.<sup>106</sup> Энэхүү тогтолцоо Тангаргатны шүүхээс (jury system) цаг хугацаа болон зардал бага зарцуулдаг, буруу шийдвэр гарах эрсдлийг бууруулдаг зэргээр давуу боловч, иргэдийн оролцоо хэлбэрийн төдий болон хувирах эрсдлийг агуулдаг.

Эдгээрээс шүүх дахь иргэдийн оролцоо нэлээд хүчтэй хөгжсөн гэж хэлж болох нийтийн эрх зүйн системийн Англи, Америкийн Тангаргатны шүүх (jury system), сонгодог иргэний эрх зүйн системийн Герман, Францийн (lay judge), ялангуяа дээрх хоёр тогтолцоог харьцуулах замаар үүсч хөгжсөн Япон, Солонгосын шүүхийн иргэдийн оролцооны тогтолцоо, түүний онцлогийг гол объект болгон авч судална.

**Герман улсын шүүх дэх иргэдийн оролцоо:** Герман улсын (lay judge) гэж дүүргийн шүүх дэх 1 шүүгч, 2 иргэдийн төлөөлөгчөөс /цаашид ИТ гэх/ бүрдсэн шүүхийг ойлгодог. Үүнээс гадна Мужийн шүүхийн 1 шүүгч, 2 ИТ, мөн зарчмын хувьд давж заалдах шатны шүүхийн маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд 3 шүүгч, 2 ИТ байх ба (lay judge)-ийн тогтолцооны өвөрмөц хэлбэр юм. Түүнчлэн ИТ-ийг 5 жилээр томилдог, ИТ-ийн тоо 2 байдаг зэргээрээ онцлог<sup>107</sup> байна.

ИТ нь мэргэжлийн шүүгчтэй адил эрхтэйгээр үйл баримтыг үнэлэх, ялын хэмжээг тогтооход оролцдог<sup>108</sup> бөгөөд Иргэдийн төлөөлөгчид шүүгчийн хараат бус байдлын тухай зохицуулалт хамаардаг.<sup>109</sup> Шийдвэрийн хувьд 3-ний 2-оор буюу дийлэнх олонхиор шийдвэр гаргадаг.<sup>110</sup> Давж заалдах шатны шүүхийн анхан шатаар хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд ИТ 2 байдаг тул олонхи болж чадахгүй ч, 2 ИТ эсрэг саналтай байгаа тохиолдолд шийдвэр гаргах боломжгүй юм.

**Франц** улсад анх Францын хувьсгалын буюу 1790 оноос эхлэн эрүүгийн, иргэний хэрэгт jury system-ийг хэрэглэж эхэлсэн боловч, одоо (lay judge)-ийн хэлбэрийг хэрэглэж байна. *Хүснэгт №2-оос тодорхой харна уу*

**Япон улсын шүүх дэх иргэдийн оролцоо “холимог-lay judge”:** Япон улсад 1923 онд тангаргатны шүүхийн (jury system) систем агуулсан хууль батлагдаж, 1928 оноос 1943 он хүртэл хэрэгжиж байсан. Гэвч их хэмжээний зардлыг ялтан хариуцаж байсан, тангаргатны шүүхийг сонгосон тохиолдолд үйл баримттай холбогдуулан давж заалдах боломжгүй байсан, иргэдийн оролцоо хэлбэрийн төдий байсан зэрэг маш олон шалтгааны улмаас тангаргатны шүүхийн загвар үр дүнтэй хэрэгжээгүй байдаг.

Харин 2009 оноос (lay judge)-д маш ойртсон хэлбэрийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Иргэдийн төлөөлөгчийн тогтолцоо тангаргатны шүүхийн иргэдийн төлөөлөгчийг сонгохтой холбогдсон шинжийг агуулах боловч, иргэдийн төлөөлөгчийн бүрэн эрх, шийдвэр гаргах хэлбэр зэрэг асуудлын хувьд (lay judge) тогтолцооноос ялгарахгүй.

Зарчмын хувьд 3 шүүгч, 6 иргэдийн төлөөлөгчөөс бүрдсэн хурлын хэлбэрээр маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулна. (lay judge) тогтолцооны нэг том сул тал нь иргэдийн төлөөлөгчдийн тоо тангаргатны шүүхээс харьцангуй цөөхөн, шүүгчтэй

<sup>105</sup> Lee Eun Mo, “Солонгос улсын иргэдийн шүүх дэх оролцооны тогтолцооны агуулга, асуудал, Японы мэргэжлийн бус шүүгчийн тогтолцоотой харьцуулан авч үзэв” - 李銀模、『韓国の国民参与裁判制度の内容と問題点』 「日本の裁判員制度との比較を中心に」 (2009年) pp 65-66

<sup>106</sup> Зарчмын хувьд ялтанд сонгох эрх байхгүй.

<sup>107</sup> Такүчи Моричи, “Герман улсын шүүх дэх lay judge, мэргэжлийн шүүгч хоорондын харилцаа” - 田口守一、「ドイツの裁判所における参審員」 職員裁判官との関係 pp163-164

<sup>108</sup> Шүүгчийн бүрэлдэхүүний тухай хууль 30.1, 77.1

<sup>109</sup> Шүүгчийн тухай хууль 45-р зүйл

<sup>110</sup> Шүүгчийн бүрэлдэхүүний тухай хууль 196.1

хамтран шийдвэр гаргадаг тул иргэдийн оролцоо хэлбэрийн төдий болох эрсдэлтэй.<sup>111</sup> Иймээс Японы судлаачид Герман улстай харьцуулан судалсаны үндсэн дээр иргэдийн төлөөлөгчдийн тоог нэмж, илүү олон иргэдийн төлөөлөгчийн оролцуулах замаар иргэдийн оролцоог бодитой болгохыг зорьсон байна.

Иргэдийн төлөөлөгчийн бүрэн эрхийн хувьд үйл баримтыг үнэлэх болон ялын хэмжээг тогтоох асуудалд мэргэжлийн шүүгчтэй адил эрх эдэлдэг.

**Солонгос улсын шүүх дэх иргэдийн оролцоо “-холимог- jury system -”:** Солонгос улсад 2007 онд jury system-д холбогдох “Иргэдийн шүүхийн оролцооны тухай хууль” батлагдаж, 2008 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж эхлэсэн. 2008 онд “jury system” тогтолцоог хэрэгжүүлэх гол үндэс нь 5 жил туршиж үзэх асуудал байсан юм. Улмаар үр дүнг дүгнэж, Үндсэн хуулийн зөрчилтэй холбоотой асуудлыг харгалзан судалж, сүүлийн загварын боловсруулахыг зорилго болгожээ.

Уг тогтолцооноос найдаж буй үр дагаварын хувьд *1-т иргэдийн шүүхэд оролцуулж, нийгмийн эрүүл, энгийн ухамсарыг шүүхэд тусгах үндсэн дээр иргэдийн эрх зүйн ухамсарт нийцсэн шүүхийн шийдвэр гаргаж, түүгээр дамжуулан иргэдийн шүүхийн үйл ажиллагаанд итгэх итгэлийг сайжруулах, 2-т уламжлалт тогтолцооноос зайлсхийж, шүүх эрх мэдлийн хууль бус байдлыг зогсоох, 3-т иргэдийн шүүхэд оролцуулж, шүүхийн процесс болон агуулгыг иргэдэд ойлгомжтой болгох, бичгэн хэлбэрийн шүүх ажиллагаанаас зайлс хийхэд оршиж байсан.*

Эндээс Солонгос улсын 2008-2013 он хүртэлх туршлага нь шүүхийн иргэдийг оролцоог бодитойгоор бий болгох гэж буй Монгол улсын хувьд чухал судалгааны объект гэж хэлж болно.

Солонгосын “jury system” нь дараах онцлогтой. 1-т Ялтан ИТ-ийн оролцоотойгоор шүүн хэлэлцүүлэх, эсхүл мэргэжлийн шүүгчээр хянан шийдвэрлүүлэхээ сонгох эрхтэй, 2-т ИТ шүүгчийн оролцоогүйгээр үйл баримт (гэм буруутай эсэх)-ийг үнэлэх боловч, бүгд санал нэгдээгүй тохиолдолд шүүгчийн саналыг сонссоны үндсэн дээр дийлэнх олонхийн саналаар шийдвэр гаргана, 3-т ИТ үйл баримтыг үнэлэх асуудалд бодитойгоор оролцох боловч, ял ногдуулах асуудлын хувьд санал илэрхийлэх төдий эрхийг эдлэх бөгөөд шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүй.<sup>112</sup> Өөрөөр хэлбэл ИТ-ийн шийдвэрийн хүчин чадал эцсийн шинжтэй бус байдаг гэж хэлж болно. Энэ нь дараахи шалтгаантай байна. “ИТ-ийн тогтолцоог бий болгохтой зэрэгцэн хуульч, судлаач нарын зүгээс иргэд шүүн таслах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь Үндсэн хуультай зөрчилдөнө гэх шүүмж их байжээ. Иймээс Үндсэн хуулийн маргаанаас зайлсхийхийн тулд ИТ-д шийдвэр гаргах эцсийн эрхийг үл олгон, эцсийн шийдвэрийг шүүгч гаргах байдлаар зохицуулсан”<sup>113</sup> байна.

Өнөөгийн байдлаар Солонгос улсын “jury system” тогтолцоонд дараахи 2 зүйлийг бэхжүүлэх асуудал хүчтэй тавигдаж байна.

1. “jury system” тогтолцоо нь нийгмээс өндөр үнэлэмж, итгэл олж авсантай холбогдуулан ИТ-ийн шийдвэрт эцсийн байх буюу шүүгчээс хараат бус шийдвэр гаргах эрх олгох (jury system-ийн үндсэн хэлбэрт шилжих асуудал)
2. ялтан “jury system” тогтолцоог сонгохгүй байх, ИТ-ийн шийдвэрлэж болох хэргийн хүрээ хумигдвал байгаатай холбогдуулан шүүхээс “jury system” тогтолцоог илүү өргөн хүрээнд ашиглаж байна.

<sup>111</sup>Lee Eun Mo, “Солонгос улсын иргэдийн шүүх дэх оролцооны тогтолцооны агуулга, асуудал, Японы мэргэжлийн бус шүүгчийн тогтолцоотой харьцуулан авч үзэв”- 李銀模, 『韓國の国民参与裁判制度の内容と問題点』 「日本の裁判員制度との比較を中心に」 (2009年) p68

<sup>112</sup>Ямаүчи Масая, “Солонгос улсын шүүх дэх иргэдийн оролцооны тогтолцооны талаарх судалгааны тайлан”- 山内雅哉, 「韓國の国民参与制度の調査報告」 (2009年) p34

<sup>113</sup>Үагүчи Тацүо, “Солонгос улсын иргэдийн төлөөлөгч шүүхэд оролцох тогтолцооны талаарх ажилаглалт”-上口達夫 「韓国「国民参与裁判」の視察を終えて」 p1

Энэ нь Солонгост “jury system” тогтолцооны үнэлэмж болон иргэдийн итгэх нэмэгдэж, шүүх эрх мэдлийн ил тод байдал сайжирч, иргэдийн хандлага өөрчлөгдөж нийгэмд эерэг хандлага тогтож байгаатай холбоотой.

### **1.3. Монгол улсын шүүх дэх иргэдийн оролцоог хангаж байсан түүхээс:**

Манай улсын хувьд Үндсэн хуулиар боловсруулахдаа гадаад улсуудын дэвшилтэт Үндсэн хуулиудыг өргөнөөр харьцуулан, хэрэглэх уламжлалтай билээ. Үндсэн хууль батлах үед буюу 20-р зууны сүүлийн хагаст ардчилсан орнууд хүрээнд “jury system”, “lay judge” системүүд нь хууль эрх зүйн тогтолцооны нэгэн томоохон хэсэг болж, төлөвшиж байсан<sup>114</sup> гэдгийг дурьдах нь зүйтэй.

Судаачдын<sup>115</sup> тэмдэглэснээр 1993 оноос өмнөх 70 жилийн хугацаанд ардын шүүхийн тогтолцоо Монгол улсад байжээ. Тухайлбал, 1960 оны Үндсэн хуулийн 60-р зүйлд “Бүх шүүхэд хэрэг таслах явдлыг хэрэв хуульд зориуд заасан хэрэгт бус ахул ардын төлөөлөгчдийн оролцуулан байнга шүүгч нар гүйцэтгэж байна”, 60.3-д “Шүүгч ба ардын төлөөлөгчид шүүхээр шийдэгдээгүй бөгөөд сонгуулийн эрхтэй 23 нас хүрсэн бүх ард иргэд сонгогдож” шүүгч, ардын төлөөлөгч хоёр адил статустай 4 жилийн хугацаатайгаар улсын бага хурал болон орон нутгийн хурлаас томилдог байжээ.

Харин 1993, 1994 оноос эхлэн ЭБШХ, ИХШХШТХ-д хэрэгжиж буй иргэдийн төлөөлөгчийн тогтолцоо нь иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт хууль зүйн ямар нэг үр дагавар агуулдаггүй хэлбэр төдий байна.<sup>116</sup> Энэ талаар судлаач Н.Нарангэрэл өнөөг хүртэлх иргэдийн төлөөлөгчийн институт нь “хууль зүйн хувьд ямар ч үр дагаваргүй, шүүх хуралдааны хүчин төгөлдөр байдлыг хангах зорилго бүхий хэсэг бүлэг хүний суудал төдий болж хувирсан”<sup>117</sup> хэмээн дүгнэсэн байдаг.

## **Хоёр. ҮНДСЭН ХЭСЭГ**

**2.1. ШИТЭБТХ-ийн үзэл санаа, агуулга:** ШИТЭБТХ нь 2012 оны 05 дугаар сарын 22-ны өдөр батлагдаж, 2013 оны 04-р сарын 15-ны өдрөөс үйлчилж эхэлсэн. Хуулийн үйлчлэлийг 2013 оны 11-р сарын 1-ээс хэрэгжилтийг хангахаар яригдаж байсан ч ҮХЦ-д маргаан үүссэнтэй холбоотойгоор хойшлуулаад байсан.

Энэ хуулиар “Иргэдийн төлөөлөгч” гэж эрүү, иргэн, захиргааны анхан шатны шүүхийн шүүн таслах үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх болон шүүхийн хараат бус байдлыг баталгаажуулах чиг үүрэгтэйгээр оролцох энэ хуульд заасан шаардлагыг хангаж байгаа Монгол улсын иргэнийг<sup>118</sup> хэлнэ гэж тодорхойлж болохоор байна.<sup>119</sup>

<sup>114</sup> Улсын дээд шүүх, Хэйсэй 22 он, дугаар 1196, Их суудал Хэйсэй 23 он 11 сар 22 өдөр, Шийдвэр 「覺せい刑取締法違反、関税法違反被告事件」

<sup>115</sup> Б.Бат-Эрдэнэ УДШ-ийн ерөнхий шүүгч асан, Монголын төр эрх зүй сэтгүүлийн 2009 он№4 “Хуулийн тогтолцоонд хэдэн хүн тоглоод ярилцлагандаа”, Ч.Хосбаяр шүүгч Хууль дээдлэх ёс сэтгүүлийн 2011 №1/32/ “Монголд тангаргатны шүүх хэрэгтэй юу?” өгүүлэлд, Б.Чимид Увс аймгийн шүүхийн 80 жилийн ойн баярын эрдэм шинжилгээний хуралд тавьсан Шүүхийн тогтолцоо, бүтцийн шинэчлэл илтгэлдээ. Х.Тэмүүжин ҮХЦ-д өгсөн тайлбартаа.

<sup>116</sup> ХЗҮХ-ээс 2005, 2011 оны явуулсан судалгаагаар “шүүхийн тухай хуульд иргэдийн төлөөлөгчөөр ямар хүнийг сонгох шалгарыг тогтоож өгөөгүйгээс ихэвчлэн шүүхэд зав чөлөөтэй тэтгэвэрийн насны хүмүүс иргэдийн төлөөлөгчөөр ороцдог жишээ тогтсон. Тэд шүүх хуралдаанд хэрэгт ач холбогдолгүй зүйл асуух, дахин давтгаж асуух зэрэгээр шүүх хуралдааныг сунжруулах бусдыг калхаах хэргийн бусад оролцогчдод үл итгэх байдлыг бий болгоход хүргэж байна.” хэмээн дүгнэсэн байна.

<sup>117</sup> Н.Нарангэрэл 2012 онд Б.Чимид багшийн нэрэмжит “Үндсэн эрх” судлаачдын ЭШХ-д тавьсан “Хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэдийн оролцоог хангах нь” илтгэлдээ.

<sup>118</sup> 5.1. Иргэдийн төлөөлөгч нь дараах шаардлага хангасан байна:

- 5.1.1. эрх зүйн бүрэн чадамжтай, 25 нас хүрсэн Монгол Улсын иргэн байх;
- 5.1.2. тухайн анхан шатны **шүүхийн** харьяаллын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг байх;
- 5.1.3. ял шийтгүүлж байгаагүй;
- 5.1.4. сонгогдон шалгарах үедээ эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэргийн оролцогч бус байх;
- 5.1.5. монгол хэлээр чөлөөтэй ярьж, ойлгодог байх;

ШИТЭБТХ-д зааснаар эрүү, иргэн, захиргааны анхан шатны журмаар хэргийг шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд 2 шүүгч, 1 иргэдийн төлөөлөгч оролцох юм.

Ингэснээр 1993-2013 оныг хүртэл явж ирсэн хэлбэрийн төдий иргэдийн төлөөлөгчийн тогтолцоог халж, иргэдийн төлөөлөгч шүүхэд бодитойгоор оролцох эрх зүйн механизм бүрдэж байгаа юм. Энэ нь иргэдийн төлөөлөгчийг шүүгчтэй адил түвшинд томъёолж буй хэрэг бөгөөд иргэд шүүх хуралдаанд оролцсоноор хууль, шүүхийн тухай мэдлэг нь нэмэгдэж, эрх зүйн ухамсар нь дээшилж, шүүн таслах үйл ажиллагаа ил тод, хяналттай болж, шүүх шударга байх олон нийтийн үнэлэмж нэмэгдэж, нийгмийн шүүхэд итгэх итгэл, хандах хандлага сайжирч шүүхийн нэр хүнд дээшлэнэ гэж үзэж байна.<sup>120</sup>

Цаашид тулгарч болох бэрхшээлүүд: ШИТЭБТХ-ийг хэрэгжүүлэхтэй холбогдон дараах бэрхшээлүүд учирч болохыг үгүйсгэх аргагүй. ШИТЭБТХ-ийн 8-р зүйлд иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтыг нутгийн захиргааны байгууллагтай хамтран гаргах, 9-р зүйлд иргэдийн төлөөлөгчийг тохиолдлын журмаар сонгон шалгаруулж, ажлын хоногийн дотор сонгон шалгарсан тухай мэдэгдлийг иргэнд хүргүүлэх хугацаа зэргийг дурьджээ. Эдгээр заалтын хэрэгжилттэй холбогдон иргэд албан ёсны шуудангийн хаяг байхгүй, байнгын шилжилт хөдөлгөөнтэй, оршин суугаа хаяг тогтворгүй, алслагдсан газар оршин сууж буй малчдын асуудал, түүнд зарцуулагдах зардал зэрэг олон хүндрэлүүд гарах нь дамжиггүй. Энэ асуудлууд нь өнөөг хүртэлх иргэдийн төлөөлөгчийн оролцооны хүрээнд ч яригдаж байсан<sup>121</sup> юм.

Тиймээс хуулийн хэрэгжилтээс урьтаж дээрх асуудлуудыг сайтар төлөвлөх нь зүйтэй. Сууринд газар оршин сууж буй иргэдэд мэдээлэл хүргэх асуудлын хувьд иргэний бүртгэл мэдээллийн системийн дэвшил, нутгийн удирдлага, багийн шуудан харилцааны зохион байгуулалтыг ашиглах боломжтой. Малчдын хувьд төрийн эрүүл мэнд “багийн эмч”, шуудан харилцааны үйлчилгээ “багийн дарга” болон бусад үйлчилгээтэй хамтатгах замаар хэрэгжүүлэхэд боломжгүй зүйл байхгүй.

Энэ нэг талаас зардлыг хэмнэх ач холбогдолтой, нөгөө талаас илүү хурдан, шуурхай, үр дүнтэй байж болох юм. Энэхүү ШИТЭБТХ-ийг хэрэгжүүлэх асуудалд холбогдуулан нарийвчлан судалгаа хийх нь зүйтэй болов уу.

#### Үндсэн хуулийн цэцийн шийдвэр

### **1. Иргэдийн төлөөлөгч шүүх бүрэлдэхүүнд оролцсоноор үүсэх үр дагавар ба шүүгчийн хараат бус байдал**

Үндсэн хуулийн Цэц №4 дүгнэлтээрээ ШИТЭБТХ-ийн “3.3.1 дэх заалтад иргэдийн төлөөлөгч анхан шатны шүүхээр маргааныг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд оролцох”, мөн хуулийн 12.1 дэх хэсэгт “Хэрэг, маргааныг анхан шатны журмаар шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд нэг иргэдийн төлөөлөгч оролцуулна” гэж тус тус заасны “...шүүх бүрэлдэхүүнд...”<sup>122</sup> гэсэн нь дээр дурьдсанчлан Үндсэн хуулийн 49.2 хэсэг дахь **“Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй”** гэсэн заалтыг зөрчсөн буюу ШИТЭБТХ-ийн “Шүүх бүрэлдэхүүнд ИТ оролцох” үзэл санаа нь шүүгчийн хараат бус байдалд харшилна гэж дүгнэсэн байна.

---

5.1.6.сүүлийн нэг жилийн хугацаанд иргэдийн төлөөлөгчөөр шүүх хуралдаанд оролцоогүй байх.

<sup>119</sup> Д.Хуяг. “ИХШХШ эрх зүйн үндсэн болон тулгамдсан асуудлууд”. УБ., 2013 он. 165-166 дахь тал.

<sup>120</sup> Д.Хуяг. “ИХШХШ эрх зүйн үндсэн болон тулгамдсан асуудлууд”. УБ., 2013 он. 166 дахь тал. Х.Тэмүүжин УИХ-ын чуулганы үед хэлсэн үгэндээ дээрх санааг хэлсэн байдаг. <http://wap.eagle.mn/mcontent/read/7201.htm?sessionid=7F95A56859B4B427520935E03F3E856B> 2013.12.13-нд хандав.

<sup>121</sup> Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлт 2013 оны 11 сар №4

<sup>122</sup> Н.Нарангэрэл 2012 онд Б.Чимид багшийн нэрэмжит “Үндсэн эрх” судлаачдын ЭШХ-д тавьсан ““Хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэдийн оролцоог хангах нь” илтгэлдээ.

<sup>122</sup> Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлт 2013 оны 11 сар №4

Үндсэн хуулийн 49.2 дахь хэсгийн шүүгчийн хараат бус байдлын агуулгыг “Шүүгч улс төрийн болон бусад нөлөөнд автахгүй”<sup>123</sup> байх гэсэн агуулгатай. Гэтэл иргэдийн төлөөлөгч шүүх бүрэлдэхүүн орсоноор хэрхэн шүүгчид нөлөөлж байгааг ҮХЦ-ээс шийдвэртээ тайлбарлаагүй нь эргэлзээг төрүүлж байна.

Энэ асуудлаар Япон улсын судлаачид **дээд шатны шүүх доод шатны шүүхийн шийдвэрийг үнэлэх, бүрэлдэхүүнд шүүх хурлын хамтын шийдвэр гаргахтай адил агуулгаар ойлгох үчиртай**<sup>124</sup> **гээд уг зарчим нь ТУЙЛИЙН ШИНЖ-тэй ойлголт биш бөгөөд “Шүүхээс шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхтэй холбогдон бий болох бүсдын буюу дотоодын оролцоо хүлээн зөвшөөрөгдөнө”**<sup>125</sup> хэмээн тайлбарласан байдаг.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тогтолцоотой холбогдуулан судлаач Сасата “Шүүгчийн шүүн таслах үйл ажиллагаан хараат бус байдал” гэдгийг “бусад ямар нэгэн субъектийн тушаал, заавар, зөвлөгөөг үл авч, өөрийн үнэлгээнд үндэслэн шүүн таслах үүргээ хэрэгжүүлэх асуудал бөгөөд хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс гадна хуулиас гадуур шүүх эрх мэдлийн дотоод зааварчилгаа, зөвлөгөөнд үл автах агуулгыг илэрхийлдэг”<sup>126</sup> буюу иргэдийн төлөөлөгч шүүх бүрэлдэхүүнд орцох нь шүүгчийн хараат бус байдалд нөлөөлж байгаа хэлбэр биш гэдгийг тогтоож өгсөн байна. Судлаач Аоно шүүх шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхтэй холбогдон хуулийн хүрээнд бий болсон дотоод оролцоог хүлээн зөвшөөрөх тул **“Шүүгчийн шүүн таслах ажиллагааны хараат бус байдал нь тухайн шүүгч ЦОРЫН ГАНЦ, ЭЦСИЙН ШИЙДВЭР-ийг ганцаараа гаргах ойлголт биш”**<sup>127</sup> гэж үзсэн.

Мөн НҮБ-ийн Шүүхийн хараат бус байдлын зарчмын 2-д **“Аливаа хэргийг алагчлалгүйгээр, хэний ч нөлөөнд авталгүйгээр, нотлох баримтад үндэслэн, хуульд нийцүүлэн, хууль бус нөлөөлөл, сэтгэл хөдлөл, дарамт шахалт, сүрдүүлэггүйгээр, шүүд болон шүүд бус хөндлөнгийн оролцоогүйгээр шийдвэрлэх”**, 5-д **“Хүн бүхэн хууль ёсны дагуу байгуулагдсан ердийн болон тангаргатны шүүхэд хандах эрхтэй”**<sup>128</sup> хэмээн тунхагласан байгаа нь дээрх Япон судлаачдын тайлбарыг бид хэрэглэх бүрэн боломжтойг харуулж байна.

2009 онд Япон улс мэргэжлийн бус шүүгчийн шүүх бүрэлдэхүүнд оролцуулж эхэлсэнтэй холбоотойгоор Японы Дээд Шүүхээс дараах шийдвэрийг<sup>129</sup> гаргасан байна.

**ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ: Иргэдийн төлөөлөгчийн шүүх бүрэлдэхүүнд оролцох тогтолцоо иргэдийн төлөөлөгч шүүгчийн шийдвэрт нөлөөлөх, хязгаарлахад хүрэх тул нь шүүгчийн шүүн таслах ажиллагааны хараат бус**<sup>130</sup>-ийг баталгаажуулсан Үндсэн хуулийн 76.3-т харшилна гэж үзсэн.

**ДЭЭД ШҮҮХ:** Их суудлын хуралдаанаар Үндсэн хууль зөрчөөгүй гэж шийдвэрлэжээ.

- Үндсэн хуулиар шүүх бүрэлдэхүүн дэх **иргэдийн төлөөлөгчийн тогтолцоог хүлээн зөвшөөрөх эсэх асуудал бол** улсын удирлага, эрүүгийн процессийн олон зарчим, Үндсэн хууль батлах үеийн түүхэн байдал болоод Үндсэн хуулийн зохицуулалт, заалт зэрэг бүх олон зүйлийг харгалзан шийдвэрлэх асуудал юм.
- Шүүх бол нотолгоонд үндэслэн үйл баримтыг дүгнэж, хүний эрх, үүргийг эцсийн байдлаар тогтоох замаар хүний хувь заяаг шийдвэрлэх маш том эрхийг хэрэгжүүлэгч юм. Иймд **олон ардчилсан оронд эрүүгийн шүүх процессыг зүй**

<sup>123</sup>Н.Лүндэндорж, Ч.Өнөрбаяр, М.Батсуурь “Монгол улсад шүүхийн хараат бус байдлын бэхжүүлэх нь” 2010 он, тал 31

<sup>124</sup> Шүүхийн тухай хууль 2013 он

<sup>125</sup>Сэризава Хитоши, “Шинэ Үндсэн хуулийн тайлбар”- 芹沢 齊、「新基本法コメンタール 憲法」（日本評論社）407-408頁

<sup>126</sup>Сасата Эйжи, “Үндсэн хуулийн өнцгөөс харсан мэргэжлийн бус шүүгчийн тогтолцоо”- 笹田 栄司、「憲法から見た裁判員制度」（2008年）p 109頁、

<sup>127</sup>Аоно Ацү, “Мэргэжлийн бус шүүгчийн тогтолцооны талаарх Үндсэн хууль судлалын ажиглалт”-青野篤、「裁判員制度の憲法学的一考察」（2011年）pp209-210

<sup>128</sup>Basic Principles on the Independence of the Judiciary 2, 5., 1985

<sup>129</sup> Дээд шүүх, Хэйсэй 22 он, дугаар 1196, Их суудал Хэйсэй 23 он 11 сар 22 өдөр, Шийдвэр 「覚せい剤取締法違反、関税法違反被告事件」

<sup>130</sup> Судлаачид Шүүх албаны хараат бус байдал хэмээн хэрэглэсэн нь бий

**ёсоор явуулахад шударга шүүхээр нээлттэй, ил тод шүүлгэх эрх, зүй процесс, өмгөөлөгч авах эрх маш олон тогтолцоо бий болсон.** Улмаар эрх мэдэл хувиарлалтаар шүүх эрх мэдлийн хүрээнд шүүгчийн албаны хараат бус байдал, эдийн засгийн хараат бус байдал зэрэг баталгаажсан. **Энэ бүхнээс Эрүүгийн шүүхийн хэрэгжүүлэгч бол шүүгч байхаар тогтоосон нь харагдаж байна.**

- Нөгөө талд түүхэн болон олон улсын хандлагаас харахад Европ болон Америкийн орнуудад 18-20 зууны хагас хооронд иргэдийн шүүх дэх шууд оролцоонд үндэслэн шүүх дэх иргэдийн байр суурийг хүчирхэгжүүлэх үндсэн дээр **Үндсэн хууль батлах үе буюу 20-р зууны эхний хагас хүртэл тангаргатны шүүхийн (jury system) болон мэргэжлийн бус шүүгч оролцуулах (lay judge) аргыг өргөн хүрээнд хэрэгжих болсон.** Япон улсын хувьд ч Тайшогийн 12 оноос Шоовагийн 3 он хүртэл Тангаргатны шүүхийн (jury system)-ийг хэрэглэж байсан түүх бий.
- Орчин үед асуудлын гол нь **шүүгч болон иргэдийн төлөөлөгчөөс бүрдсэн шүүх бүрэлдэхүүн нь** эрүүгийн шүүхэд холбогдох Үндсэн хуулийн шаардлагад нийцсэн “Шүүх” байж чадах эсэх юм.
- **Мэргэжлийн бус шүүгчийн тухай хуулийн 13, 37 дахь зүйлд** зааснаар “Иргэдийн төлөөлөгчийг доод танхимын сонгуулийн саналыг эрх бүхий иргэдээс сугалах замаар сонгох бөгөөд шударга бус шүүх ажиллагааг явуулах магадлалтай этгээд, үл сонгож хүсэлтийн жагсаалтад орсон этгээд зэргийг үл тооцно. Мөн иргэдийн төлөөлөгчийн бүрэн эрх”, 6-р зүйл “Шүүн таслах ажиллагааг шударгаар биелүүлэх болон бусад үүргийг хүлээсэн”, 9-р зүйл “Шүүгч, прокурор, өмгөөлөгч иргэдийн төлөөлөгчид ойлгогдохуйц байдлаар шүүн таслах ажиллагааг явуулах”, 51-р зүйл “шүүгчтэй адил эрх эдлэх тухай”, 6.1, 66.1-р зүйл “Шийдвэр гаргах үйл явц болон иргэдийн төлөөлөгчийн саналын эрхийг тусгасан”, 67-р зүйл “нууц хадгалах үүрэг”, 70.1-р зүйл “Иргэдийн төлөөлөгчид нөлөөлөх, сүрдүүлэх үйлдэлд хариуцлага хүлээлгэх”, 106, 107-р дахь заалтуудаар иргэдийн төлөөлөгч, шүүгчтэй адил түвшинд шүүн таслах үйл ажиллагаа явуулах систем бүрэлдэж хэмээн дүгнэсэн байна.
- Үндсэн хуулийн 76-р зүйлд “Шүүгч бол Үндсэн хууль болох хуульд захирагдана”-аар заасан. Тиймээс “иргэдийн төлөөлөгчдийн шүүх бүрэлдэхүүн орох” нь **Үндсэн хуулиар тогтоосон “хүний эрхийг хангах систем”-ийг бүрдүүлсэн, Үндсэн хуулийн дагуу хуульчлагдсан байх тул Үндсэн хуулийн 76.3-ийг зөрчсөн гэх үндэслэлгүй юм.** Мөн 76.3 дэх заалт нь шүүгчийн албаны хараат бус байдлыг баталгаажлуулсан байх ба бусдын хэлэлцээ, дарамтын нөлөөнд үл автан, шударга, төвийг сахисан шүүн таслах ажиллагааг явуулах агуулгыг илэрхийлэх боловч, **шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тогтолцооны хувьд ч шүүгч нь хуулийн тайлбар болон бусад шийдвэрийг гаргах бөгөөд шударга, төвийг сахисан шинжээ хадгалсаар байхаар хуульчлагдсан байх тул 76.3-ийг зөрчсөн гэх тайлбар үндэслэлгүй** байна хэмээн дүгнэсэн байна.

## **2. Анхан шатны шүүхийн “шүүх бүрэлдэхүүн” ба хамтын зарчмаар шийдвэр гаргах асуудал**

ҮХЦ-ийн 2013 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн №4 үндэслэл хэсэгт “Үндсэн хуулийн 52 зүйлийн 1 дэх хэсэгт “Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ” гэсэн нь шүүх бүрэлдэхүүнд хамааралтай байна”, “Үндсэн хуулийн 52 зүйлийн 2 дахь хэсэгт “Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна” гэснийг иргэдийн төлөөлөгчийг шүүх бүрэлдэхүүнд оролцуулахаар заасан гэж үзэхээргүй байна” хэмээн товч дүгнэлтийг хийсэн байна.

Яагаад дээрх дүгнэлтийг хийж байгаа талаарх ямар ч тайлбар байхгүй учир ҮХ-ийн 52.1, 52.2 дахь хэсгийн агуулгыг тайлбарлахыг оролдож үзвэл.

Хамгийн гол үндэслэл болгосон хэсэг нь ҮХ-ийн 47.1-т “Монгол улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Бүх шатны шүүх нь Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ” гэсэн заалтаар тайлбарласан байна.

Монгол Улсын ҮХЦ-ийн дүгнэлтээс “Шүүх эрх мэдлийг зөвхөн шүүгч хэрэгжүүлнэ, шүүх бүрэлдэхүүнд зөвхөн шүүгч орно, шүүгчид хэргийг хамтын зарчмаар шийдвэрлэнэ” гэх логик гарч байна.

Гэтэл Үндсэн хуулиар УДШ Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ<sup>131</sup>(51.1) гээд, анхан шатны шүүхийн шүүх бүрэлдэхүүнийг тусгайлан тогтоолгүйгээр анхан шатны шүүхэд иргэдийн төлөөлөгчийг оролцуулан шийдэж болохоор 52.2-т тусгай зохицуулалт хийж өгчээ. Эндээс шүүх бүрэлдэхүүн зөвхөн шүүгчдээс бүрдэх ёстой юу гэх асуулт гарч ирнэ.

Бусад улс оронд ч энэ талаар маргаан гарч байжээ. Япон улсын өмнөх Үндсэн хууль болох Мэйжигийн Үндсэн хуулийн 24-р зүйлд иргэн “Шүүгчээр маргаанаа таслан шийдвэрлүүлэх эрх”-тэй хэмээн тусгасан байжээ. Гэвч уг заалт шүүх дэх иргэдийн оролцооны тогтолцоог бий болгоход хаалт болно гэсний үндсэн дээр одоогийн Үндсэн хуулийн 32-р зүйлд “Шүүхээр маргаанаа таслан шийдвэрлүүлэх эрх” хэмээн шинэчлэн найруулж, улмаар анхан шатны шүүхийн шүүх бүрэлдэхүүнийг Үндсэн хуулиар тогтоолгүй үлдээсэн гэх сонирхолтой баримт байдаг.

Энэхүү хоёр заалт нь судлаачдын зүгээс шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгч оролцох тогтолцоо нь Үндсэн хууль зөрчөөгүй буюу Үндсэн хуулиар зөвшөөрсөн гэх үндэслэлийг дэмжих томоохон хөшүүргэ болсон байдаг.

Солонгосын улсын хувьд ч холимог тангаргатны шүүхийн систем нь Үндсэн хуулийн 27-р зүйл дэх иргэд “Шүүгчээр маргаанаа шүүн таслуулах эрх”<sup>132</sup>-тэй хэмээх зохицуулалтыг зөрчиж байна гэсэн шүүмж их байдаг.

Шүүх зөвхөн шүүгчдээс бүрдэх эсэх асуудалтай холбогдуулан Япон улсын Дээд шүүхээс дараах тайлбар бүхий шийдвэрийг<sup>133</sup> гаргасан байна.

**ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:** Үндсэн хуулийн 80-р зүйл (доод шатны шүүгчийн томилгоо, эдийн засгийн баталгааны тухай заалт) бол доод шатны шүүх зөвхөн шүүгчдээс бүрдэх тухай агуулгыг илэрхийлэх тул шүүгчээс өөр субъект шүүх бүрэлдэхүүнд оролцох нь Үндсэн хуульд заасан “шүүх” гэх ойлголтод хамаарахгүй юм. Улмаар шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ гэх Үндсэн хуулийн 76.1 зүйлийг зөрчинө.

**ДЭЭД ШҮҮХ:** Их суудлын хуралдаанаар Үндсэн хууль зөрчөөгүй гэж шийдвэрлэжээ.

- Үндсэн хуулийн зохицуулалтын хувьд ч Мэйжигийн Үндсэн хуулийн 24-р зүйлд заасан “Иргэн ... шүүгчээр шүүлгэх эрхтэй” гэх заалт одоогийн Үндсэн хуулийн 32 –р зүйлд “Хэн ч бай шүүхээр шүүлгэх эрхтэй” хэмээн, 37.1-д “шударга шүүхийн хялбар, нээлттэй шүүхээр шүүлгэх эрхтэй” гэх зэрэг “**шүүгчээр шүүлгэх**”-ээс “**шүүхээр шүүлгэх**” гэж шинэчлэгдэн найруулагдсан байна.
- Мөн Үндсэн хуулийн шүүх эрх мэдлийн талаархи 6-р бүлэгт Дээд шүүхээс ялгаатайгаар доод шатны шүүхийн шүүх бүрэлдэхүүний тогтоож өгөөгүй байдаг. Энэ нь Үндсэн хууль батлах үеийн тэмдэглэлд jury system болон lay judge-ийг бий болгох боломжтой байлгахад оршиж байсан нь тодорхой тусчээ.
- Улмаар дээр дурьдсанаар Үндсэн хууль бол доод шатны шүүхэд иргэдийн төлөөлөгч оролцохыг хориглоогүй тул шүүгч болон иргэдийн төлөөлөгчөөс бүрдсэн шүүх нь Үндсэн хуулийн 80-р зүйл заасан “шүүх” гэх ойлголтод хамаарахгүй гэж тайлбар үндэслэлгүй хэмээн дүгнэсэн байдаг.

<sup>131</sup> Үндсэн хуулийн 51.1. “Улсын Дээд Шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ” 1992

<sup>132</sup> Солонгос улсын Үндсэн хуулийн 27-р зүйл

<sup>133</sup> Улсын дээд шүүх, Хэйсэй 22 он, дугаар 1196, Их суудал Хэйсэй 23 он 11 сар 22 өдөр, Шийдвэр 「覚せい剤取締法違反、関税法違反被告事件」

Монгол Улсын Үнсэн хуулийн 52.2 “...**шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна**” буюу хууль тогтоох эрх мэдэлд хэрхэн, ямар журмаар оролцуулах ёстойг тогтоох эрхийг шилжүүлсэн байна.

Японы хувьд Монгол улсаас ялгаатай нь иргэдийн төлөөлөгчийг шүүхэд оролцуулах тухай Үндсэн хуулиараа тодорхой заалт байхгүй юм.

**Японы ДЭЭД ШҮҮХ:** “Үндсэн хуульд иргэдийн шүүх дэх оролцоог шууд тогтоогоогүй нь дээрх маргааныг бий болгож байна. Гэвч тодорхой заалт байхгүй байгаа нь иргэдийн төлөөлөгчийн шүүх бүрэлдэхүүн дэх оролцоог хориглосон гэх утга биш”<sup>134</sup> гээд:

- Үндсэн хуулиар шүүх бүрэлдэхүүн дэх иргэдийн төлөөлөгчийн тогтолцоог хүлээн зөвшөөрөх эсэх асуудал бол улсын удирлага, **эрүүгийн процессийн олон зарчим, Үндсэн хууль батлах үеийн түүхэн байдал болоод Үндсэн хуулийн зохицуулалт, заалт зэрэг бүх олон зүйлийг харгалзан шийдвэрлэх асуудал юм.**
- Асуудлын гол нь шүүгч болон иргэдийн төлөөлөгчөөс бүрдсэн шүүх бүрэлдэхүүн нь эрүүгийн шүүхэд холбогдох Үндсэн хуулийн шаардлагад нийцсэн “шүүх” байж чадах эсэх юм. *Үндсэн хуулийн шаардлага бол эрүүгийн шүүхийн суурь зарчимд нийцэх, иргэний эрхийг баталгаатай хангах/*
- Шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгчийн оролцуулах асуудлыг эрүүгийн шүүхийн олон зарчимтай уяалдуулах замаар хэрэгжүүлэх боломжтой тул Үндсэн хуулиар иргэдийн төлөөлөгчийн шүүх дэх оролцоог хориглосон гэж тайлбарлах шалтгаан байхгүй бөгөөд **бодитоор бий болсон тогтолцоон нь эрүүгийн процессийн суурь зарчмуудтай нийцэж буй эсэхээр Үндсэн хуультай зөрчилдөх эсэх тухай асуудлыг шийдвэрлэх учиртай гэжээ.**

Өөрөөр хэлбэл Үндсэн хууль бол шүүх дэх иргэдийн оролцоог хүлээн зөвшөөрөх бөгөөд эрүүгийн процессийн зарчмуудад нийцүүлэн jury system болон lay judge-ийн алийг нь сонгохоос эхлээд түүний агуулгыг **тогтоох нь хууль тогтоох эрх мэдэлд олгогдсон** гэж үзсэн байна.

Монгол улсын хувьд ч **ШТЭБмХ-ийн үзэл санаа, түүний бодит хэлбэр, систем нь Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөө, Эрүүгийн шүүхийн олон зарчим, үнэт зүйлд нийцэх эсэх нь чухал юм.**

Эрх мэдэл хувиарлалтын онол ёсоор **хүний жам ёсны эрхийг хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах суурь хүчин зүйлийн үндсэн дээр Шүүхийн эрх мэдэл, түүний бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдал, нийгмийн болоод эдийн засгийн баталгааны тухай асуудал тавигдсан байдаг билээ. Улмаар Үндсэн хууль болон бусад хуулиар шүүх тогтолцоо, шүүийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдал, хараат бус томилгоо, чөлөөлөхөдд холбогдох эрх зүйн механизмүүд бий болжээ.** Тухайлбал, **Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар баталгаажсан** Шүүх албаны хараат бус байдал, шүүгчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх баталгаа, шүүгчийн эдийн засгийн баталгаа, шүүгчийн томилгоо зэрэг шүүгч төвийг сахисан, шударга шүүн таслах ажиллагааг явуулахад чиглэгдэн **маш олон механзмийг дурьдаж болно.**

**Энэхүү механизмүүд нь Үндсэн хуульд заасан хүний суурь эрх, эрх чөлөө болон эрүүгийн шүүхийн “Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дүр мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглох, Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй”<sup>135</sup>. Гэм бүрүүтэй нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт**

<sup>134</sup> Улсын Дээд Шүүх, Хэйсэй 22 он, дугаар 1196, Их суудал Хэйсэй 23 он 11 сар 22 өдөр, Шийдвэр 「覚せい剤取締法違反、関税法違反被告事件」

<sup>135</sup> Үндсэн хуулийн 16.13, 1992



хэрэг үйлдсэн гэм бүрүүтайд үл тооцох<sup>136</sup>, өөрийгээ өмгөөлөх, өмгөөлөгч авах зэрэг суурь зарчмуудыг хангахад чиглэгдсэн байдаг.

**Явцын дүгнэлт:** Энэ бүхнээс үзэхэд “иргэдийн төлөөлөгч шүүх бүрэлдэхүүнд оролцож шүүн таслах чиг үүргийг хэрэгжүүлэх” тогтолцоо нь Үндсэн хуулийн ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХАМГААЛАЛ, ЭРҮҮГИЙН ШҮҮХИЙН СУУРЬ ЗАРЧМУУД-ЫН шаардлагыг хангаж чадахгүйц байдлаар системлэгдсэн эсэх нь Үндсэн хуульд нийцэж буй эсэхийн томоохон шалгуур болох учиртай.

Тиймээс бусад улс оронд хүний эрх, эрх чөлөөг хангах, эрүүгийн шүүхийн суурь зарчмуудын агуулгыг хангах хүрээнд хүлээн зөвшөөрөгдөж буй тогтолцоотой элементийн хүрээнд ерөнхий байдлаар харьцуулалт хийж үзье. Хүснэгт 2-ээс үзнэ үү

Энэ хүрээнд иргэдийн төлөөлөгчийн шүүн таслах ажиллагаанд хамтран оролцоходоо системийн хувьд Үндсэн хуулиар баталгаажсан шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдалд холбогдох бусад тогтолцоотой эн түнцэхүйц байдлаар хуульчлагдсан байх асуудал яригдана. Өөрөөр хэлбэр ШИТЭБтХ болон бусад хуулиар хуульчлагдсан “шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгчийг оролцуулах” тогтолцоог хэрэгжүүлэх механизм сул тохиолдолд эсрэгээрээ “иргэний шударга шүүхээр шүүлгэх эрхийг”-хангаж чадахгүй байх эрсдлийг дагуулна.

Харин ШИТЭБтХ-ийн тухай хуулийн 4-р зүйл иргэдийн төлөөлөгчийн үйл ажиллагаанд хориглох зүйл, 5-р зүйл иргэдийн төлөөлөгчид тавигдах шаардлага, 7-р зүйл иргэдийн төлөөлөгчийн хараат бус байдал, 8-р зүйл иргэдийн төлөөлөгчдийн нэрсийн жагсаалт, 9-р зүйл сонгон шалгаруулалт, 12-р зүйл иргэдийн төлөөлөгч шүүх бүрэлдэхүүнд оролцох, 16-р зүйл хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага зэргээс харахад иргэдийн төлөөлөгч шүүх бүрэлдэхүүнд оролцож маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх зүйн үндсэн систем бүрдсэн гэж дүгнэж болохоор байна.

### 2.3.Харьцуулсан судалгаа

Хүснэгт 1. Jury system, Lay judge-ийн ерөнхий шинж, ШИТЭБтХ-тай харьцуулалж үзвэл.

|                            | Шүүгчийн оролцоо | Гэм буруу   | Ялын хэмжээ | Хуулийн асуудал     | Томилгоо      | Сонгох      |
|----------------------------|------------------|-------------|-------------|---------------------|---------------|-------------|
| Сонгодог Jury system       | Зөвхөн ИТ        | Үнэлэнэ     | Тогтоохгүй  | Зөвхөн шүүгч        | Тухайн хэрэгт | Эс үйлдэхүй |
| Сонгодог Lay judge         | Шүүгчтэй хамт    | Үнэлэнэ     | Тогтооно    | ИТ оролцоно         | Хугацаатай    | Шалгаруулах |
| Япон “холимог Lay judge”   | Шүүгчтэй хамт    | Үнэлэнэ     | Тогтооно    | <u>Зөвхөн шүүгч</u> | Тухайн хэрэгт | Эс үйлдэхүй |
| Солонгос “холимог Jury”    | Ялтан Сонгоно    | Үнэлэнэ     | Тогтооно    | -                   | Тухайн хэрэгт | Эс үйлдэхүй |
| Монгол ШИТЭБтХ “Lay judge” | Шүүгчтэй хамт    | Тодорхойгүй | Тодорхойгүй | Тодорхойгүй         | Тухайн хэрэгт | Эс үйлдэхүй |

<sup>136</sup> Үндсэн хуулийн 16.14, 1992

Гэвч, Эрүүгийн шүүх хуралд иргэдийн төлөөлөгчийн хэрэгжүүлэх бүрэн эрх, шийдвэр гаргахад буюу үйл баримт үнэлэх, ялын хэмжээг тогтоох зэрэг эрүүгийн процессийн чухал асуудалд оролцох байдал зэрэг асуудал тодорхой бүс байна.

**1- Хүснэгт “Зарим орны шүүх дэх иргэдийн оролцоо, ерөнхий харьцуулалт”. Жич: Lay judge, болон jury system-ийн хоёр хэлбэрийг агуулсан<sup>137</sup>**

|                          | Монгол<br>“Lay judge”<br>-ШИТЭБтХ-                                        | Япон<br>“Lay judge”<br>-Онцлог-                                                       | Америк<br>“jury system”                                                | Англи<br>“jury system”                                                 | Герман<br>“Lay judge”                                                                                            | Франц<br>“Lay judge”                                                                         | Солонгос<br>“jury system”<br>- Онцлог-                                                                             |
|--------------------------|---------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Маргаан<br>ний<br>объект | Эрүү, иргэн,<br>Захиргааны<br>эрх зүйн<br>маргаан                         | Хүнд төрлийн<br>эрүүгийн<br>хэрэг                                                     | Эрүүгийн<br>хэрэг,<br>Иргэний хэрэг                                    | Эрүүгийн<br>хэрэг, Зарим<br>иргэний хэрэг                              | Эрүүгийн<br>хэрэг,<br>Хөдөлмөр,<br>Захиргаа<br>болон бусад<br>хэрэг                                              | Эрүүгийн<br>хэрэг,<br>Насан хүрээгүй<br>хүүхэд,<br>Нийгмийн<br>халамж,<br>даатгалын<br>хэрэг | Хүнд төрлийн<br>эрүүгийн хэрэг                                                                                     |
| Бүрэлд<br>эхүүн          | <u>Шүүгч 3</u><br><u>(болон)</u><br><u>ИТ-1</u>                           | <u>Шүүгч 3</u><br><u>(болон 1)</u><br><u>ИТ 6 (болон</u><br><u>4)</u>                 | <u>Шүүгч 1:</u><br><u>Juryman 12:</u>                                  | <u>Шүүгч 1:</u><br><u>Juryman 12:</u>                                  | <u>Муж,</u><br><u>Дүүргээс</u><br><u>шалтгаалан</u><br><u>Шүүгч 1-3</u><br><u>(болон)</u><br><u>Lay judges 2</u> | <u>Шүүгч 3</u><br><u>(болон)</u><br><u>Lay judges 9</u>                                      | <u>Шүүгч :</u><br><u>Juryman 5, 7,</u><br><u>9:</u><br><u>(Ялын хүнд</u><br><u>хөнгөнөөс</u><br><u>шалтгаална)</u> |
| Сонгох<br>арга           | 25 наснаас<br>дээш,<br>Иргэдийн<br>төлөөлөгчийн<br>нэрсийн<br>жагсаалт ЭҮ | 20 наснаас<br>дээш,<br>Сонгуулийн<br>нэрсийн<br>жагсаалтаас<br>ЭҮ                     | 18 наснаас<br>дээш,<br>Сонгуулийн<br>нэрсийн<br>жагсаалтаас<br>ЭҮ      | 18 наснаас<br>дээш,<br>Сонгуулийн<br>нэрсийн<br>жагсаалтаас<br>ЭҮ      | 18 наснаас<br>дээш, 4<br>жилийн<br>томилолт, Улс<br>төрийн намын<br>сонгон<br>шалгаруулна                        | 23 наснаас<br>дээш,<br>Сонгуулийн<br>нэрсийн<br>жагсаалтаас<br>ЭҮ                            | 20 наснаас<br>дээш,<br>Солонгос<br>улсын<br>иргэдээс ЭҮ                                                            |
| Эрх<br>хэмжээ            |                                                                           | Шүүгчтэй<br>адил эрх<br>хэмжээтэй<br>Гэм бурууг<br>үнэлэх, ялыг<br>хэмжээг<br>тогтоох | Шүүгч<br>үнэлэлтэд үл<br>оролцоно.<br>Шүүгчээс<br>хараат бус<br>үнэлэх | Шүүгч<br>үнэлэлтэд үл<br>оролцоно.<br>Шүүгчээс<br>хараат бус<br>үнэлэх | Шүүгчтэй адил<br>эрх хэмжээтэй<br>хууль зүйн<br>болон үйл<br>баримтыг<br>үнэлэх                                  | Шүүгчтэй адил<br>эрх хэмжээтэй<br>Гэм бурууг<br>үнэлэх, Ялын<br>хэмжээг<br>тогтоох           | Шүүгчээс<br>хараат бус<br>Гэм бурууг<br>үнэлэх,<br>Шийдвэр<br>Juryman-ийн<br>үнэлгээнд<br>нөлөөлөхгүй              |

<sup>137</sup> <http://www.iaajapan.com/> Зарим улс орны иргэдийн төлөөлөгчийг шүүх бүрэлдэхүүнд оролцох тогтолцоо, харьцуулалт

|                                       |      |                                                                       |                                                                           |                                                                                           |                                                       |                                                                                         |                                                                                                         |
|---------------------------------------|------|-----------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------|
|                                       |      |                                                                       |                                                                           |                                                                                           |                                                       |                                                                                         |                                                                                                         |
| Шийдвэр гаргах арга                   |      | Дийлэнх олонх<br>Гэхдээ Шүүгч болон ИТ тус бүр 1 хүний санал хэрэгтэй | Зарчмын хувьд бүгд санал нэгдэх, Зарим мужид 10 дээш хүний санал хэрэгтэй | Зарчмын хувьд бүгд санал нэгдэх, 2-цагаас дээш хэлэлцсэн тохиолдолд 12-оос 10 хүний санал | Гэм буруутайд тооцох шийдвэрт 3-ний 2 оор шийдвэрлэнэ | Гэмт буруутайд тооцход 8-аас дээш, ялын хэмжээний хувьд ердийн олонхиор буюу 7-оос дээш | Зарчмын хувьд бүгд санал нэгдэх, Санал хуваагдсан тохиолдолд шүүгчтэй зөвлөлдсөний эцэст дийлэнх олонхи |
| Давж заалдах оролцох эсэх             | Үгүй | Үгүй                                                                  | Үгүй                                                                      | Үгүй                                                                                      | Зөвхөн дүүргийн шүүхэд боломжтой                      | Хүнд төрлийн гэмт хэрэгт Lay judges 12 болгон дахин хянан хэлэлцэх                      | Үгүй                                                                                                    |
| Нийтэд мэдээлэх                       | Үгүй | -                                                                     | Болно. Гэвч хуульчийн ёс зүй нэлээд хүчтэй нөлөө үзүүлдэг                 | Хэргийг хянан шийдвэрлэж дуустал хориотой                                                 | Үгүй                                                  | Үгүй                                                                                    | -                                                                                                       |
| “Хэргийн хавтас хэрэг”, Бодит процесс | Үгүй | Үгүй                                                                  | Үгүй                                                                      | Үгүй                                                                                      | Үгүй                                                  | Үгүй                                                                                    | -                                                                                                       |
| Сэжигтний сонгох боломж               | Үгүй | Үгүй                                                                  | Иргэд оролцоогоор хангагдах эрхээ эдлэхгүй байж болно                     | Тийм<br>-Хязгаартай-                                                                      | Үгүй                                                  | Үгүй                                                                                    | Тийм                                                                                                    |

|                   |         |         |                                                      |         |         |         |   |
|-------------------|---------|---------|------------------------------------------------------|---------|---------|---------|---|
| Нууцла<br>х үүрэг | Хүлээнэ | Хүлээнэ | Хэргийг хянан<br>шийдвэрлэсн<br>ий дараа<br>үүрэггүй | Хүлээнэ | Хүлээнэ | Хүлээнэ | - |
|-------------------|---------|---------|------------------------------------------------------|---------|---------|---------|---|

## ДҮГНЭЛТ, САНАЛ

Орчин үед шүүх дэх иргэдийн оролцоог хангахад Тангаргатны шүүхийн (jury system), мэргэжлийн бус шүүгч оролцуулах (lay judge), энэ хоёр системийн холимог хувилбар гэсэн тогтолцоонууд төлөвшин тогтож байна.

Шүүх эрх мэдлийн шинэчлэлийн хүрээнд баталсан ШИТЭБТХуулиар “Мэргэжлийн шүүгчтэй хамт шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгчийн оролцуулах” үзэл санааг буюу мэргэжлийн бус шүүгч шүүх бүрэлдэхүүн орох “lay judge” загварыг хуульчлан тогтоосон байна.

Энэ хуулийн иргэдийн төлөөлөгч “шүүх бүрэлдэхүүнд оролцох” гэх заалт нь Үндсэн хуульд харшилсан гэх иргэний мэдээллээр Үндсэн хуулийн Цэцэд маргаан үүссэн бөгөөд ҮХЦ-ээс 2013 оны 11 сарын 13-ны өдрийн №4 шийдвэртээ Үндсэн хуулийг зөрчсөн хэмээн дүгнэжээ.

Ийнхүү дүгнэхдээ Үндсэн хуулиар шүүх эрх мэдлийг шүүх хэрэгжүүлнэ, шүүхийн тухай хуульд зааснаар шүүх бүрэлдэхүүн нь зөвхөн шүүгчдээс бүрдэнэ гэх үзэл баримтлалын үндсэн дээр иргэдийн төлөөлөгч шүүх бүрэлдэхүүнд оролцож болохгүй, Үндсэн хуулийн маргааныг шийдвэрлэх хамтын зарчим бол шүүгчид хамаарах зохицуулалт гээд Үндсэн хуулийн 49.2–г зөрчиж байна гэжээ.

Цэцийн шийдвэр ёсоор Үндсэн хуулийн “шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах” 49.1, “шүүгчийн албаны хараат бус байдал” 2, “Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдал” 3, “шүүхийн бие даасан байдлыг хангах” 4 зэрэг заалтуудаас үзэхэд шүүх эрх мэдлийн хүрээнд шүүхийн шүүн таслах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч бол шүүгч байхаар тогтоосон байх агуулга харагдаж байна.

Гэхдээ дээрх шүүх, шүүгчид холбогдох Үндсэн хуулийн тогтолцоо бол Үндсэн хуулиар баталгаажсан ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАМГААЛАХ, иргэний шударга шүүхээр шүүлгэх эрхийг баталгаатай хангах үзэл санааны үндсэн дээр бий болсон байдаг.

Иймд Үндсэн хуулийг тайлбарлах асуудлын хүрээнд “иргэдийн төлөөлөгч шүүх бүрэлдэхүүнд оролцох” тогтолцоо нь Үндсэн хуулиар баталгаажсан ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХАМГААЛАЛ, ЭРҮҮГИЙН ПРОЦЕССИЙН СУУРЬ ЗАРЧМУУД-ын шаардлагыг хангаж чадахуйц байдлаар хуульчлагдсан эсэх нь Үндсэн хуульд нийцэж буй эсэхийн шалгуур болох учиртай.

Эндээс дүгнэвэл **Нэгдүгээрт:** Монгол Улсын ШИТЭБТХ-ийн “Шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгчийн оролцуулах” үзэл санаа нь Үндсэн хуулийн 16.14-т заасан “иргэний шударга шүүхээр шүүлгэх эрх”-ийн агуулгын хүрээнд уг эрхийг хангахад чиглэгдсэн байна, **Хоёрдугаарт:** шүүн таслах үйл ажиллагаанд иргэдийн төлөөлөгчийг оролцуулах замаар иргэдийн эрх зүйн ухамсарыг дээшлүүлж, шүүн таслах ажиллагааг ойлгомжтой болгох, шүүхийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох, шударга, нээлттэй, ил тод байлгах, олон нийтийн шүүхэд итгэх итгэл, үнэлэмжийг дээшлүүлэхэд чирлэгдэж буй тул Үндсэн хуулийн ардчилсан ёс, шударга ёсны суурь зарчимд нийцэхээр байна.

Мөн ШИТЭБТХ-иар иргэдийн төлөөлөгчийн сонгох механизм, тавигдах шаардлага, хараат бус байдал, үүрэг, хариуцлага зэргийг нарийвчлан тогтоож өгсөн байгаа нь иргэдийн төлөөлөгч шүүх бүрэлдэхүүнд оролцож маргааныг хянан шийдвэрлэх үндсэн систем бий болсон буюу уг тогтолцоог хэрэгжүүлэх эрх зүйн механизм бүрдсэн гэж дүгнэж болохоор байна.

Харин иргэн, шүүгч хоёрын эрх мэдлийн хуваарилалтын (гэм бүрүүг үнэлэх, ялын хэмжээг тогтоох, хэм хэмжээ хэрэглэх гэх мэт шийдвэр гаргах ажиллагааг гол болгосон) асуудал, шүүх хуралдаан дахь иргэний бодит оролцоо (шүүх хуралдаан дэх иргэний оролцооны хэлбэр нь эрүүгийн процесс хууль дахь суурь зарчим, үнэт зүйлтэй хэрхэн үялдах, нийцэх) зэрэг нь хуульчлагдаагүй байгааг анхааран авч үзэх шаардлагатай болов уу.

Түүнчлэн, Монгол улсын “Lay judge”-ийг бусад улс орны тогтолцоотой харьцуулан авч үзвэл: **Нэгдүгээрт:** бусад орнуудад хоёр ба түүнээс олон тоотой буюу иргэдийн оролцоог илүү бодитой болгоход чиглэсэн байдаг. Харин Манай улсад Иргэдийн төлөөлөгч нэг буюу цөөнх байна. **Хоёрдугаарт:** Хэрэг маргааны төрлийн хувьд ихэнх улс оронд зөвхөн эрүүгийн процесст оролцуулдаг жишиг байна. Харин ШИТЭБТХ-ийн зохицуулалтаас үзэхэд иргэн, захиргаа, эрүүгийн процесст оролцох боломжтой харагдаж байна.

### **Дээрх судалгааны ажилдаа үндэслэн дараах САНАЛ-ыг дэвшүүлье.**

- 1- Үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд “Шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгч оролцуулах тогтолцоог” тайлбарлахдаа:

Үндсэн хуулийн 16-т заасан иргэний шударга шүүхээр шүүлгэх эрхийн агуулгын хүрээнд тайлбарлан шийдвэрлэх учиртай. Өөрөөр хэлбэл иргэний шударга шүүхээр шүүлгэх эрхийн хангаж чадах эсэх гэх асуудлын хүрээнд маргааныг авч үзэв ёстой болов уу.

Эндээс Үндсэн хуулийн 52.1-т заасан “Маргааныг шийдвэрлэх хамтын зарчим” гэдгийг зөвхөн субъектээр хязгаарлан үл ойлгох буюу маргааныг шийдвэрлэх процесс ажиллагааны агуулгын хүрээнд ойлгон тайлбарлах нь оновчтой.

Мөн Үндсэн хуулийн 52.2-т заасан “Анхан шатны шүүх хэрэг маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчийг хууль заасан журмын дагуу оролцуулна” гэдгийг хууль тогтоох эрх мэдэл анхан шатны шүүхэд маргааныг шийдвэрлэхэд иргэдийн оролцуулах хэлбэрийг тогтооно гэж тайлбарлах нь зүйд нийцнэ. Гэхдээ Хууль тогтоох эрх мэдлээс хуульчилсан тогтолцоо нь Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөө, эрүүгийн шүүхийн суурь зарчим, үнэт зүйлд нийцэж байх гэх агуулгаар хязгаарлагдах учиртай ба үүнд холбогдох Үндсэн хуулийн зөрчлийн маргааныг Үндсэн хуулийн Цэц хянан шийдвэрлэх учиртай.

- 2- Түүнчлэн Үндсэн хуулийн 49.2-т заасан “Шүүгчийн шүүн таслах ажиллагааны хараат бус байдал(албаны хараат бус)”-ыг маргааныг шийдвэрлэх хамтын зарчмын үүднээс тайлбарлах буюу бүрэлдэхүүнд шүүх хурлын хүрээнд нэг шүүгчийн эцсийн, цорын ганц шийдвэр биш гэх (бүрэлдхүүний оролцоо хүлээн зөвшөөрөгдөх) агуулгаар ойлгох нь зүйтэй.

Цэцээс эцсийн шийдвэр гаргахдаа “иргэдийн төлөөлөгч шүүх бүрэлдэхүүнд оролцох тогтолцоо” нь Үндсэн хуулийн баталгаажсан хүний эрх, эрх чөлөө, эрүүгийн шүүхийн суурь зарчим, үнэт зүйлд нийцэх, хангах эсэх асуудлыг чухалчлан анхаарах шаардлагатай.

- 3- Цаашид хууль тогтоогч болон Цэцийн зүгээс дараах хоёр асуудлыг анхаарах нь зүйтэй.

52.1-т Үндсэн хуулиар тогтоосон маргааныг шийдвэрлэх хамтын зарчмыг “шүүгчдээс бүрдсэн шүүх бүрэлдэхүүн”-ээс илүү үр дүнтэй хэрэгжүүлэх эсэх гэх асуудлын хүрээнд иргэн, шүүгч хоёрын эрх мэдлийн хуваарилалтын (гэм бүрүүг үнэлэх, ялын хэмжээг тогтоох, хэм хэмжээ хэрэглэх гэх мэт шийдвэр гаргах ажиллагааг гол болгосон) асуудлыг чухалчлах нь зүйтэй.

52.2-т Үндсэн хуулийн эрх зүйн маргааны хувьд “Шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгч оролцуулах тогтолцоо”-ны бодит хэлбэр буюу ШИТЭБТХ болон бусад хуулиар тогтоосон шүүхийн хуралдаан болон өмнөх шатан дахь иргэний бодит оролцооны хэлбэр (эдлэх эрхээс эхлэн хуучин хуулийн ялгагдах тал нь эрүүгийн процесс хууль дах суурь зарчим, үнэт зүйлтэй хэрхэн уялдах, нийцэх) зэрэг хуульчлагдан тогтоогтоогүй байгаа асуудлууд маш чухлаар тавигдах ёстой.

## Ном зүй

### **Ном, Судалгааны өгүүлэл, илтгэл, сэтгүүл, хууль, эрх зүйн акт**

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1960
2. Монгол Улсын Үндсэн хууль. 1992
3. Монгол Улсын Шүүхийн тухай хууль. 2012
4. Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлт №4 2013
5. Н.Лүндэндорж, Ч.Өнөрбаяр, М.Батсуурь. “Монгол улсад шүүхийн хараат бус байдлын бэхжүүлэх нь” 2010
6. Накамура Масаки. “Гадаад улсуудын Үндсэн хуулийн орчууллага ба Монгол Улсын анхны Үндсэн хуультай холбогдох баримт бичиг. Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрхзүй судлалын хөгжил” Хуульзүйн Үндэсний Хүрээлэн. 2004
7. Х.Тэмүүжин. “Jus Frast буюу Ёст үг”. УБ., 2004
8. Г.Совд. “Монгол Улсын Үндсэн хууль хүний эрх” /харьцуулсан эрх зүй/. УБ., 1999
9. Б.Чимид. “Хууль Дээдлэх ёсыг хангадаг шударга шүүхийн үүрэг” ҮНДСЭН ХУУЛЬТ ЁС БА ҮНДЭСНИЙ ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО олон улсын симпозиум II. УБ., 2009
1. The Constitution law of Japan, Shouwa 25
2. The Constitution law of Korea, 1987
3. The Bangalore Principles of Judicial conduct, 2002
4. Basic Principles on the Independence of the Judiciary, 1985
5. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 217A(III) тогтоол, НҮБ-ын баримт бичиг A/810 AT 71(1948)
6. Улсын Дээд Шүүх, Хэйсэй 22 он, дугаар 1196, Их суудал Хэйсэй 23 он 11 сар 22 өдөр, Шийдвэр 「覚せい剤取締法違反、関税法違反被告事件」
7. Сэризава Хитоши, “Шинэ Үндсэн хуулийн тайлбар” - 芹沢斉、「新基本法コメントル 憲法」（日本評論社）
8. Сасата Эйжи, “Үндсэн хуулийн өнцгөөс харсан мэргэжлийн бус шүүгчийн тогтолцоо” - 笹田栄司、「憲法から見た裁判員制度」（2008年）
9. Ямаүчи Масая, “Солонгос улсын шүүх дэх иргэдийн оролцооны тогтолцооны талаарх судалгааны тайлан” - 山内雅哉、「韓国の国民参与制度の調査報告」（2009年）
10. Яагүчи Тацүо, “Солонгос улсын иргэдийн төлөөлөгч шүүхэд оролцох тогтолцооны талаарх ажилаглалт” - 上口達夫「韓国「国民参与裁判」の視察を終えて」（2011年）
11. Аоно Ацү, “Мэргэжлийн бус шүүгчийн тогтолцооны талаарх Үндсэн хууль судлалын ажиглалт” - 青野篤、「裁判員制度の憲法学的—考察」（2011年）
12. Аоно Ацү, “Мэргэжлийн бус шүүгчийн тогтолцооны Үндсэн хуульд нийцэж буй байдал” - 青野篤、「裁判員制度の合憲性」（2011年）
13. Такүчи Моричи, “Герман улсын шүүх дэх lay judge, мэргэжлийн шүүгч хоорондын харилцаа” - 田口守一、「ドイツの裁判所における参審員」職員裁判官との関係
14. Lee Eun Mo, Сүмомо, “Солонгос улсын иргэдийн шүүх дэх оролцооны тогтолцооны агуулга, асуудал, Японы мэргэжлийн бус шүүгчийн тогтолцоотой харьцуулан авч үзэв” - 李銀模、『韓国の国民参与裁判制度の内容と問題点』『日本の裁判員制度との比較を中心に』（2009年）
15. Нишино Ёшиказү, “Мэргэжлийн бус шүүгчийн тогтолцооны Үндсэн хуульд нийцэж буй талаарх Улсын дээд шүүхийн байр суурь, асуудал” - 西野喜一、「裁判員制度合憲判決をみる最高裁判所の思想とその問題点」（2012年）

### **Вэт сайт, цахим материал**



1. <http://www.president.mn/> Монгол улсын шүүхийн тухай хуулийн төсөл болон түүнтэй холбогдох бусад хуулийн төслийн танилцуулга
2. <http://www.unodc.org/>
3. Хөвсгөл аймгийн шүүхийн шүүгч Н.Мөнхөө <http://www.court.khs.gov.mn/> “Шударга шүүх, хараат бус байдлын талаархи ойлголт нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлд үндэслэн бий болдог тухай судлаачид өгүүлсэн байна”
4. <http://www.saibanin.courts.go.jp/> Япон улсын шүүхийн нэгдсэн вэб
5. <http://www.nichibenren.or.jp/> Япон улсын Өмгөөлөгчдийн холбооны нэгдсэн вэб
6. <http://www.nichibenren.or.jp/> Герман улсын иргэдийн төлөөлөгчийн шүүх бүрэлдэхүүнд оролцох тогтолцоо
7. <http://www.waseda.jp/> Герман улсын Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн шүүх бүрэлдэхүүнд оролцох тогтолцоон дэх Шүүгч болон иргэдийн төлөөлөгчийн хамаарал
8. <http://www.compumag2005.com/> Америкийн jury system болон япон улсын шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тогтолцооны ялгааны тухай
9. <http://www.iiajapan.com/> Зарим улс орны иргэдийн төлөөлөгчийг шүүх бүрэлдэхүүнд оролцох тогтолцоо, харьцуулалт
10. <http://www.superdramatv.com/> Америкийн jury system болон Япон улсын иргэдийн төлөөлөгчийн тогтолцооны тухай
11. <http://www.kansai-u.ac.jp/> Солонгос улсын шүүх дэх иргэдийн төлөөлөгчийн тогтолцооны агуулга, хандлага